

Хүүхдийн номын ордон
Мөрөөдөл танхим



Данс 6842 (вкмон) / 14470-3-3


Шифр ББК 84.8(2Орос) / Г.649



ндр

Грин

•
**АРЯНЗЯЛ
ДАРВУУЛТ
ХӨЛӨГ**
•



Хүүхдийн номын ордон
Мөрөөдөл танхим




Данс 6842 (bkmn) / 14470-3-3
Шифр ББК 84.8(2Орос) / Г.649



ндр

Грин

•
**АРЯНЗЯЛ
ДАРВУУЛТ
ХӨЛӨГ**
•



А. С. ГРИН

АРАНЗАЛ ДАРВУУЛТ ХӨЛӨГ
(*Шидэт үлгэр*)

“БНМАУ. Ардын боловсролын яамны хэвлэл” Улаанбаатар хотноо 1983
онд эрхлэн хэвлүүлсэн номыг

Цогт охин тэнгэр сангийн захиалгаар **Цагаан бамбарууш хэвлэлийн**
газарт 2021 онд цахим хэлбэрт хөрвүүлэв.



ЦАХИМ НОМЫН САН: www.e-nom.mn

-

Уг номыг “[Болор дуран](#)” шалгуураар шүүсэн болно.
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу
орно уу.

Б
БОЛОР ДУРАН 2.0
АЛДАА ШАЛГУУР

**“БОЛОР ДУРАН”
ЗӨВ БИЧИГ ШАЛГАХ
ПРОГРАМ**

- ✓ 60 сая үгийн сантай.
- ✓ Алдаатай үгсийг илрүүлж, зөв үгсийг санал болгоно.
- ✓ Хэлзүйн тайлбар тольтой.
- ✓ Хувийн үгийн сан үүсгэх боломжтой.

БОЛОР

АРАНЗАЛ ДАРВУУЛЫН ТУЯА

Цэлмэг тэнгэрт мандсан алтан нарны доогуур, цэнхэрлэн мяралзсан их далайн мандлаар аранзал улаан дарвуултай хаш цагаан хөлөг хурдлан хөвнө. Нүүртээ галтай, нүдэндээ цогтой залуу ахмад Грей сэтгэл зүрхээ зориулсан ялдам бүсгүй Ассолийгоо авахаар зорин яваа нь тэр билээ...

Зохиолч [Александр Степанович Грин](#) (Гриновский) 1917 онд Петербургийн тоглоомын дэлгүүрийн үзмэрийн цонхонд цагаан торгон далбаатай бяцхан завь байгааг үзээд ихэд шохоорхжээ. «Энэ тоглоом надад нэгийг хэлээд байх шиг санагдсан боловч чухам юу хэлээд байна вэ гэдгийг мэдэхгүй байлаа. Тэгэхэд нь би улаан, дарвуул, тэгэхдээ бүр аранзал дарвуул ихийг хэлэх юм биш биз гэж ургуулан бодсон» гэж зохиолч хожим нь бичсэн билээ. Грин зохиолоо бүтэн тавал жил бичиж, цэрэгт байхдаа ч гар нооргоо цүнхэндээ хадгалж явжээ. Гриний «Аранзал дарвуулт хөлөг» гэсэн алдарт туужийн гарсан түүх ийм юм. Гриний ном нь биелсэн мөрөөдлийн тухай гайхамшгийг зөвхөн болох байх гээд хүлээж суулгүй гардан бүтээх хэрэгтэй тухай өгүүлнэ. Тэгэхдээ тэр гайхамшгийг үзүүр нэгэн зорилготой, шийдвэр зоригтой Артур Грей шиг тийм улс бүтээдэг. Нэг үгээр хэлбэл хүн өөрөө хичээвэл л аз жаргалтай золгоно гэдгийг аранзал дарвуул бэлгэдэж байна.

Грин аз жаргалын тухай их бичдэг байсан боловч өөрөө жаргал гэдгийг үзэлгүй, хуучин Орос орны амьдралын хамгийн хатуу хүтүүг биеэр эдлэн өсжээ. Бүх юм Гриний эсрэг эргэж, түүнийг гэмт хэрэгтэн буюу хар амиа бодсон бэртэгчин болгохоор заяасан юм шиг байлаа. Гэвч зол жаргал, сайн сайхан амьдрал, шударга ариун ёсны тухай мөрөөдөл нь хаант ёсны харгис ширүүн, бэртэгчин байдалд бөхөж унтарсангүй, харин түүний зохиолч болохын үндэс болжээ.

Грин зодуулж нүдүүлэх, басамжлуулж доромжлуулахыг ханатал үзсэн айлын шоовдор хүү байлаа. Эцэг нь Гринийг «Реальное училище» гэдэг сургуульд оруулав. Тааруухан сурдаг байсан боловч [Майн Рид](#), [Жюль Верн](#), Густав Эмирийн зохиолыг толгой өөд татахгүй уншдаг байв. Найман настайгаасаа аялан жуулчлахыг мөрөөдөх болжээ. Гэтэл ангийнхаа багшийн тухай нэгэн шүлэг бичсэний учир сургуулиасаа хөөгдлөө. Эцэг нь уг сургуулийн босгыг элтэл

хөөцөлдсөн боловч хүүг нь сургуульд дахин аваагүй учир хотын сургуульд өгөв.

Эх нь нас барж, эцэг нь тамлагчийн бэлэвсэн эхнэртэй гэрлэв. Умгар жаахан өрөөнд, хэрүүл маргаан дунд шар нар бор хоног өнгөрсөөр байлаа. Жаал хүү хотын эмнэлгийн төсвийг сийрүүлэн бичиж, цаасан дэнлүү нааж, хөдөөгийн театрын жүжигчдийн үгийг хуулан тав арван зоос олно.

1895 оны хавар Грин усан цэргийн цагаан хувцастай хоёр хүнтэй зогсоол дээр дайралджээ. Үүнээс хойш тэнгис далайгаар аялах сан гэж өдрийн бодол шөнийн зүүд болов. Тэгээд Одесс орохоор шийдэв. Ийнхүү алсын замд гарахад нь эцгийн нь өгсөн 25 рубль, Ганг мөрний эрэг дээр зураг зурна гэж их санаа санаж авсан усан будаг хоёроос өөр юм Гринд бараг байсангүй.

Грин хөлөг онгоцонд ажилд орох гэж Одесс хотын усан боомтоор өлөн хоосон хөлөө сунатал алхавч санаашрангүй нүдтэй чөргөр залууг хараад шууд голно. Тэгж тэгж намар нь Гринийг Одессоос Батум ордог хөлөгт цалингүй сурагчаар авав. Гэвч хоолныхоо үнийг төлж чадахгүй байсан тул дорхноо халж орхижээ.

Тэгээд Вяткадаа буцахаар шийдэв. Пиу авах мөнгөгүй учир галт тэргэнд хулгайгаар суун газар дөхөөд, сүүлийн хоёр зуун километрийг явган туулах хэрэг гарчээ.

Вяткийн ойролцоох Мураши өртөөнд халуун усны газар ажиллаж, албан газар бичээч хийж, гуанзанд сууж шүүхэд өгөх өргөдөл тариачдад бичиж өгч байлаа.

Вяткад удаан байж тэссэнгүй. Баку оров. Боомтын усанд шон шаах, хуучин онгоцны будаг цэвэрлэх, нефтийн цамхгийн гал унтраах зэрэг арав таван мөнгөний аль дайралдсан ажил хийж хэсэг болов. Халуун хумхаагаар өвдөн загасчны артельд тарчлан хэвтэж Баку, Дербентийн хоорондох элсэнд цанган амь алдах дөхөж явлаа. Зогсоолын хоосон тогоонд, хөмөрсөн завины доор, үгүй бол ердөө хашааны ёроолд хоног төөрүүлж байлаа. Бакуд ядарч зүдрэхийн туйлд хүрч их л овор сууж, нүүр царай нь, өөрийн нь хэлснээр, хорчгор гуравтын дэвсгэр шиг болжээ. Гэвч хүүхэд ахуйн дүрслэх ариун сэтгэлээ гээсэнгүй. Тэр бээр гэрэл зурагчдын үзэсгэлэнгийн самбарын дэргэд удтал зогсож, хатуу хүтүү амьдралд нухлагдаж, өвчин зовлонд шаналсан олон хүний дотроос ганц ч гэсэн баяр баясгалантай, сэргэлэн цовоо хүний царай олж үзэх гэж боддог байлаа. Тэгээд нэг

бүсгүйн тийм зураг үзжээ. Тэр бүсгүйн төрх царайг тэмдэглэлийнхээ дэвтэрт бичиж авлаа. Гэтэл тэмдэглэлийн дэвтрийг хонох газрын эзэн олж үзчихээд Грин, үл таних бүсгүй хоёрыг холбож доромжилсон тул тэр хүнтэй зодолдох шахжээ.

Дахин Вятка руугаа буцахаас аргагүй болов. Ирэхэд нь архинд орсон эцэг нь мөнгө нэхэв. Гэтэл Гринд юуны нь мөнгө байх билээ.

Амь зуух ямар нэгэн арга олох хэрэгтэй байлаа. Гэвч амьдралд байраа олж чадахгүй л байв. Дахиад гэнэтийн таарч магадгүй гэсэн хүсэлдээ автаж, хөхөө өвлийн дүн хүйтнээр өвөртөө эцгийн өгсөн гурван рублийн бэлтэйгээр Урал руу алт эрэхээр явган гарчээ. Грин Шуваловын уурхайд, ажиллаж, Уралаар тэнүүчлэв. Хийх ажил олдохгүй амьдрахад бэрхтэй боллоо. Тэгэхэд цэрэгт орьё гэж сэтгэл шулуудав. Хаант засгийн хатуу харгис дэглэмтэй цэрэгт сайн дураар орно гэдэг хүнд бөгөөд ичгэвтэр байсан боловч нас дээр гарсан эцгийнхээ хүзүү дээр зайдлан сууна гэдэг бүр ч хэцүү байв.

Грин Пензад явган цэргийн хороонд алба хаав. Уг хороонд эсерүүдтэй таарч, хувьсгалт ном уншиж эхлэв. Цэрэгт жил хэртэй болоод оргож, хувьсгалт ажилд оров. Киев, Севастопольд ажиллаж, усан цэрэг, цэргүүдийн дотор нууц цогт илтгэгч гэсэн нэр олжээ. 1903 оны намар Грин Севастопольд баригдаж, 1905 оны аравдугаар сарын шувтарга болтол гянданд суув. Гянданд байхдаа анх зохиол оролдож эхлэв.

Гяндангаас гараад дахин баригдаж, Тобольскод цөлөгдөн, замаасаа оргож, Вяткад шөнөөр өвчтэй эцэг дээрээ ирж, эцэг нь хүүдээ хотын эмнэлгээс түшмэл Мальгиновын үхсэн хүүгийн паспортыг хулгайлан авч өгчээ. Тэндээсээ Петербург орж, энд анхныхаа өгүүллэгийг «Биржевые ведомости» сонинд нийтлүүлэв. Грин баярлах гэдгийг анх ингэж үзэв. Өөрийн нь өгүүллэгтэй сониныг худалдаж явсан өвгөнийг үнсэх нь холгүй болж, энэ өгүүллэгийг өөрөө бичсэн гэж батлахад нь сонин худалдагч итгэж өгөхгүй, сэвхтэй чөргөр залууг их сэжигтэй харжээ. Ингээд зохиол бичих ганц хүсэлд автаж, өөрт нь саад болоод байсан эсер байгууллагаас гарав. Гриний зохиол нийтлэгдэж эхэллээ. Грин бэртэгчин амьдралыг мөхөөсэй гэж туйлгүй хүсэж байв. Иймээс зохиолдоо бэртэгчингүй ертөнцийг дүрслэн үзүүлж байв. Зохиолч баатруудаа цэцэглэх байгалийн дунд аваачиж, хайр дурлалаас аз жаргал олж байгаагаар дүрсэн үзүүлж байв. Гэвч баатрууд нь жинхэнэ аз жаргалтай болж чадахгүй байлаа.

Гринийг Финландад байхад 1917 оны хоёрдугаар сарын хувьсгал гарлаа. Хувьсгал гарсныг дуулаад Грин хамаг юм, ном, хаа л бол салахгүй авч явдаг Эдгар Погийн зургийг хүртэл хаячхаад Петроградад явган хүрч иржээ. Дараа нь Октябрын их хувьсгалтай золголоо.

Грин хайр энхрийлэл гэдгийг үзээгүй болохоор өөрийг нь жаахан ч гэсэн анхааран халамжлахад туйлгүй сэтгэл догдлон баярладаг байжээ.

1920 онд Грин Улаан Армид татагдаж, Псковын ойролцоох Остров хотод харуулын хороонд алба хааж байв. Тэнд хижиг өвчин тусч, бусдын хамт Петроград хотод хүргэгдэн ирж, Боткиний эмнэлэгт хэвтэв. Их хүнд өвчилсөн учир эмнэлгээс гарахдаа бараг тахир дутуу болсон байлаа. Орох оронгүй, өлөн хоосон, өвчин нь сайн эдгээгүй Тэр бээр идэх юм, дулаан газар эрэн хотоор тэнүүчилж байлаа. Үхэх нь гэсэн бодол сэтгэлээс нь гарахгүй болж иржээ.

Зохиолчийн гэргий дуртгалдаа бичихдээ: «Энэ үед Гринийг Максим Горький аварсан юм. Горький Гриний хэцүүдэж байгааг мэдээд бололцоотой бүхнийг хийв. Уран бүтээлийн ажилтнуудад ховорхон олгодог байсан хүнсний хувь, «Урлагийн ордонд» гэрэлтэй, дулаан бөгөөд ор, ширээтэй өрөөг Горькийн хүсэлтээр Гринд өгөв.

... Шөнөдөө хүнд амьдралаа, Горькийн халамжилсныг санахдаа өвчин нь сайн илаарьшаагүй байсан Грин баярлан уйлдаг байлаа» гэжээ.

Хувьсгалын дараагаар Гриний уран бүтээлд эрс өөрчлөлт гарлаа. Гоо сайхан гэдэг хүнээс, түүнийг бүтээх чадвараас шалтгаална гэж Грин итгэх болов. Мөрөөдөл гэдэг ертөнцийг өөрчлөх бодит хүчин гэдгийг номдоо үзүүлэх боллоо.

1920—1921 онд алдарт «Аранзал дарвуулт хөлгөө» туурвив. Үүнийг биелсэн мөрөөдлийн тухай ном гэж болно. Уг туужид «Аранзал дарвуулт хөлгийн» хөвөх түүхийг үлгэрч өвгөн Эгель ярина. Эгель Ассольтой далайн хөвөөнд дайралдаж, эцгийнх нь хийсэн улаан дарвуултай тоглоомын завийг үзээд: «Хэдэн жил болохыг хэлж би мэдэхгүй байна. Капернад удтал дурсагдах үлгэрийн нэгэн явдал болно. Ассоль чи өсөж томоо болно. Алс далайн уудамд өглөөний нарны доогуур аранзал улаан дарвуул солонгорон харагдах болно. Туяаран гэрэлтэх гал улаан дарвуултай хаш цагаан хөлөг номин цэнхэр давлагаа зүсэн чанх өөдөөс чинь чиглэн ирнэ» гэж бэлгэдэн хэлнэ. Номын төгсгөлд үлгэрт гардагчлан яг л Эгелийн хэлснээр болно. Грин

номоо шидэт үлгэр гэж нэрлэсэн юм. Гэвч энэ нь болсон явдлын тухай үлгэр гэж хэлж болно. Учир нь ид шидийн явдал үлгэрийн ертөнцөд болсонгүй, барин тавин бодитой ертөнцөд болж байна. Ассоль бүсгүйд учирсан явдлыг ч ид шид гэж хэлж болохгүй юм. Сэтгэлт залуугаа олоход нь тусалсан сайн санаат шидэт эмгэн бүсгүйн дэргэд байсангүй. Грей өөрөө Ассольг олж байна.

Грэй амьдралд яруу найраг, гоо сайхныг батлах гэж эрмэлзэн, Ассольд баяр хөөрийг авчрах гэж хүсээд түүнийгээ авчирснаар барахгүй, уншигч биднийг ч баяр хөөртэй учруулж байна.

Аранзал дарвуулын туяа Гриний цаашдын бүх уран бүтээлд туссан юм. Тэр бээр хамгийн чухал асуудал, хүний аз жаргалын асуудлыг шийдвэрлэхэд уран бүтээлээ зориулав. Түүний баатрууд хүний аз жаргалд саад болж байгаа бүхэнтэй тулалдана. Гриний номын хуудас нь цэнхэрлэн туналзах далай, наранд умбасан хот, нэг л тохиолдох сонин хүмүүсийг дүрсэлсэн зураглалаар дүүрэн юм. Салхины исгэрэх, далайн цалгих, хөгжмийн уянгалах нь хүнийг өөрчлөх чадалтай гэдгийг зохиолын нь баатрууд харан, үүнийг олж харахад бусдыг сургаж байна. «Гялтганах ертөнц», «давлагаан дээгүүр гүйгч бүсгүй» зэрэг роман нь ийм билээ. «Хорвоо дэлхий, өөртөө байгаа бүхний хамт бидний амьдрахын төлөө байгаа газар бүрд нь энэ амьдралыг бататгахын төлөө заяасан юм» гэж Грин хэлсэн билээ. Ийнхүү ер бусын энэ зохиолч бүтээл туурвилаараа амьдралыг бататгахад хувь нэмрээ оруулсаар байгаад 1932 оны зургаадугаар сард нас нөгчжээ.

Орчуулагч [Г. Аким](#)

ГЭРГИЙ НИНА НИКОЛАЕВНА ГРИНДЭЭ ӨРГӨН БАРИВ.

*1922 ОНЫ АРВАН НЭГДҮГЭЭР САРЫН 22
ЛЕНИНГРАД*

I : БЭЛГЭДСЭН НЬ

«Орион» хэмээх гурван зуун тонны даацтай бөх хөлгийн усан цэрэг Лонгрэн гэгчийн бие арван жил алба хаагаад, зарим хүүхэд төрүүлсэн эхдээ дасдагаас ч илүү ижил дасал болсон хөлгөө орхиж, ажлаасаа гарахаас өөр аргагүй болжээ.

Учир юун хэмээвэл гэрийн бараа ховорхон хардаг» түүнийг нэг ирэхэд нь, үүдэндээ гараа сарвайн зогсож байснаа ааг амьсгаагүй гүйсээр өөдөөс нь тосдог байсан гэргий Мэри нь алга байлаа. Дотогш орвоос жижиг байшинд нь шинээр нэмэгдсэн хүүхдийн орны дэргэд айлын авгай сэтгэл хөдөлсөн зогсож:

— Охиныг тань гурван сар бөөцийллөө. Охиноо хар даа гэж хэлжээ.

Лонгрэн, царай нь хувхай цайж, тонгойн хартал, найман сартай өөдсөн охин урт сахлыг нь дүрлийтэл ширтэж байсанд, дорогш суугаад, толгой гудайж, сахлаа шувтартал сахал нь шал нойтон байв.

— Мэри минь хэзээ өөд болсон бэ? гэж Лонгрений асуухад мөнөөхөн авгай охиныг нь эгшиглэн бүүвэйлж, талийгаачийг нь диваажинд очсон гэж ам алдсаар нэгэн гунигт явдлыг ярьж өглөө. Нарийн учрыг дуулбал тэр диваажин гэдэг нь түлээ хадгалдаг модон саравчнаас нь дээрдэх юмгүй, харин арай гэгээтэй бол уу гэж бодогдож, одоо ердийн дэнлүүний энэ гэрэлд ч гэлээ гурвуул, халуун амиараа байсан сан бол диваажин гэгчид очсон гэргийд нь юутай ч зүйрлэмгүй аз жаргал байсандаа гэж санагдав.

Гурван сарын өмнө залуу эх мөнгөөр суун тун зүдэрсэн байна. Ядарч байж амаржсан болохоор биеэ эмчилж сувилуулах, шинэ хүнийг өвчин хүргэлчхэлгүй байлгахад Лонгрений орхисон мөнгөний дийлэнх нь явж, бас гай болоход, цөөн ч атугай амь зуухад нь тун их дэм болох байсан хэдийгээ гээчихсэн тул хамгийн чинээлэг гэгддэг мухлаг гуанзны эзэн Меннерсээс мөнгө зээлүүлэхийг гуйсан юм санжээ.

Мэри тэднийд оройн зургаан цагт очсон гэнэ. Долоон цагийн алдад Мэри айлынхаа авгайтай Лисса орох зам дээр уйлж уйлчихсан, санаагаар уначихсан дайралдаад хот орж хуримынхаа бөлзгийг дамжлагын газар тавихаар явж байгаагаа хэлж өөрт нь нууц амраг болбол л мөнгө өгнө гэж Меннерс үнэрхлээ гэж эгдүүцэн ярьжээ. Мэрийн амны гарз болсон байв.

— Манайд хэлэн дээр тавих юм алга. Хот ороод ирвэл охинтойгоо эр нөхрөө иртэл дөнгөөд байна байгаа гэж Мэри нь айлынхаа авгайд хэлсэн байна.

Тэр үдэш хүйтэн салхитай байсан учир авгай харанхуй шөнөөр хот яваад юугаа хийх вэ гэж залуу бүсгүйг хориглож, «Бороо шивэрч байна, салхины байрыг харахад аадар цутгах төлөвтэй. Мери минь, норж даарчихна» гэж хэлж яджээ.

Далайн эргийн тосгоноос хот ороод буцаж ирэхэд хурдан явлаа гэхэд гурваас наашгүй цаг орох боловч Мери, авгайн үгэнд орсонгүй: «Та нарын алийн болгон шарлаах вэ. Бараг л айл болгоноос талх цай гурил зээллээ. Бөлзгөө л барьцаанд өгч мөнгө авлаа бол болох нь тэр» гээд яваад өгсөн байжээ. Тэгээд явж ирснийхээ хойд өдөр халуурч дэмийрээд хэвтчихсэн аж. Сайхан сэтгэлт авгайн дуудлагаар ирсэн хотын эмч түүнийг үзээд, хүйтэн бороонд цохиулснаас хоёр уушгиндаа хатгаа авсан байна гэж хэлсэн гэнэ. Долоо хоноод Лонгрений өргөн ор ханхайран хоцорч, айлынх нь авгай охиныг асарч бөөцийлөхөөр тэднийд ирж суусан нь тэр байжээ. Ганц бие авгайд нялзрай охин дараас болох юмгүй байсны дээр түүний хэлэх нь «Ийм ангаахайтай байхад юундаа уйдаах вэ» гэнэ.

Лонгрэн хот орж, хөлс хүчээ бодуулан, нөхөд сэлттэйгээ салах ёс гүйцэтгэж ирээд бяцхан охиноо асрах боллоо. Айлын авгай, бяцхан Ассольг нь торниж хөлд сайн ортол эхийн нь оронд эх болон усан цэргийнд сууж байсан боловч Лонгрэн охиноо уналгүй босго алхаад гардаг болмогц, халамжилж байсанд нь авгайд тал өгөөд одоо охиноороо хүн хийж дөнгөнө гэж тас түс хэлж, хамаг санаа бодол, итгэл найдвар, элбэрэл хайр, өнгөрсөн дуртгалаа охиндоо зориулж, ганц биеэр зожгирон суулаа.

Арван жил дэвэн дэлхийгээр тэнэхдээ мөнгө гэх шалтай юм хурааж чадаагүй болохоор ажил хийж эхэллээ. Удалгүй Лонгрений тун хөөрхөн хийцтэй, тоглоомын жижиг завь, хөлөг, дан, давхар далбаат онгоц, байлдааны хөлөг, галт онгоц хотын дэлгүүрт гарах болов. Ийнхүү сайн мэддэг юмаа хийж суухад усан боомтын нүргээн дунд орж, тэнгис далайгаар аялан яваа юм шиг болдог, тэгээд ч Лонгрэн энэ ажил хийснээрээ хоёр идэхгүй хоосон хонохгүй амь зуугаад байх боллоо. Уулын зожигдууг хэлэх үү, гэргийгээ бие барснаас хойш бүр ч оорцог, нийцгүй болжээ. Баяр ёслолын үеэр хааяа нэг гуанзанд үзэгдэх боловч тэнд саатаж сууна гэж огт үгүй, лангууны дэргэд зогсож байж

аяга архи сандруухан залгилаад, хажуугийнхаа улсын найр тавих, юм асуухад «тийм ээ», «үгүй ээ», «сайн уу», «баяртай», «яах вэ дээ» гэх зэргээр товч товчхон хариулаад гарч одно. Гэртээ хүн ирэхэд их л тээршээж, шулуухан хөөж туудаггүй ч гэсэн, битүүхэн санаа авхуулж байх байхгүй шалтгаан тоочиж байгаад зочныг явахаас өөр аргагүй болгодог байлаа.

Өөрөө айлээр орно гэж зангүй. Тэг тэгсээр тосгоныхноосоо улам хөндийрөн холджээ. Хэрэв Лонгрений хийдэг тоглоом тосгоных нь аж төрөлтэй холбоотой сон бол тийм хөндий хүйтэн байхын гай өөрт нь мэдэгдэм ирэх сэн биз ээ. Өмсөж зүүх, идэж уухаа хотоос авчихна. Лонгренийг өөрөөсөө ганц хайрцаг чүдэнз авсан гэж Меннерс сайрхаж чадахгүй байв. Лонгрэн, гэрийнхээ хамаг ажлыг өөрөө хийж, охин хүүхэд өсгөх эрэгтэй хүн хийхээргүй ажилд тэвчээр гарган дадаж байлаа.

Ассоль таван нас хүрлээ. Охиноо өвдөг дээр нь суугаад хантаазных нь товчийг тайлах гэж ноцолдох буюу усан цэргийн хар хүр гэсэн зэрлэгдүү дууг зугаатайяа аялан байхад булбарай царайд нь ихэд мэрийсэн байдал тодрохыг харахдаа аав нь туниа муутайхан инээмсэглэх болжээ. «Р» үсэг гүйцэд хэлж чадахгүй охины шулганан дуулах дууг сонсоход хөх бүч хүзүүнд нь уясан баавгай бүжиг хийх мэт сэтгэлд буух билээ. Энэ үед болсон явдал эцгийг нь ч нэрийг хугалаад, охины нь ч хөөдсөн юм.

Өвлөөс ялгаагүй хатуу боловч нэг л янзтай хавар их эрт боллоо. Гурван долоо хоног умрын ширүүн салхи нүүр нүдгүй балбав.

Эрэг дээр татан гаргасан загасчны завь цагаан элсэн дээр ирийтэл харлаж үзэгдэх нь үлгэрлэвээс аварга том загасны нуруу гүвийн байна уу гэлтэй. Тэнгэр ийм байхад загасанд явах зүрхтэй хэн байх вэ. Бяцхан тосгоны цорын ганц гудамжаар явах хүн өдрийн од шиг цөөн. Эргийн толгодын тэндээс нүцгэн талын зүг хүйтэн хавсарга тавьж, гадаа гармагц тас хайрна. Каперны айлуудын яндангаас өглөөнөөс аваад үдэш болтол утаа баагин, шовгор дээврийн дээгүүр эрчлэн хуйларна.

Гэвч алтан нарны шижир туяанд далайн ус, Каперна тосгон тэр аяараа умбан байдаг цэлмэг сайхан цагаар Лонгрэн умгар дулаахан байшингаасаа цухуйдаггүй шахам мөртөө салхи шуургатай энэ хэдэн өдөр далайн хөвөөнд очиж, ирийсэн тулгууртай урт тавцан дээр гаран, бүр үзүүрт нь тулж очоод салхинд очисхийнгээ тамхиа удтал татаж,

алсад гаран амрыг олох гэсэн юм шиг сүрэг сүргээрээ улангасан давхилдагч хур дэлт үлгэрийн амьтад гэмээр лужир лужир давлагаан шуурга балбан багирлах тэртээ тэнгэрийн хаяа тийш хүрхрэн түрхрэн одохуйяа эргийн усны нүцгэрсэн ёроол буурал хөөс сахруулан үлдэхийг харан харан зогсдог байлаа. Их далай урхиран шуугьж, аварга том давалгаанд нүргэлэн мөргөлдөж, салхины гүйдэл нүдэнд ч үзэгдэм сэнсрээд лав орчныг тас шавхуурдан байхад Лонгрений энэлэн шаналсан сэтгэл чил чилсээр бөглөрөн мэнэрч гүн нойрт автах мэт болох билээ.

Тийм нэгэн өдөр Меннерсийн арван хоёр настай хүү Хин эцгийнхээ завийг гүүрэн дор бөөрөө цөмлөх шахан тулгуур мод мөргөж байгааг хараад, очиж эцэгтээ хэлэв. Шуурга эхлээд удаагүй, Меннерс завиа элсэн дээр гаргахаа мартсан байжээ. Меннерсийг ус руу яаран хүр ирэхэд Лонгрэн тавцангийн үзүүрт цаашаа хараад тамхиа татан зогсож байлаа. Эрэг дээр тэр хоёроос өөр хүн байсангүй. Меннерс гүүрний дунд очоод, улаан хоормог эргэлдэх ус руу бууж, завиндаа ороод аргамжааг нь тайлж, сэлүүрээ ч авсангүй, зогсоогоороо тулгуураас татан эрэг рүү гулсав. Тэгтэл тэнцүүр алдаад, дараагийн тулгуураас барихын завдгүй завины нь хошуу хүчит салхинд гуядагдан далай руу огцом эргэв. Одоо Меннерс бүх биеэрээ сунаад ч хамгийн ойрын тулгуурт хүрэх аргагүй боллоо. Салхи, давлагаан хоёр бяцхан завийг далбилзуулан, үхлийн их усруу туулаа. Меннерс хэрэг бишидсэнийг мэдээд ус руу үсрэн эрэг рүү сэльеү гэсэн боловч энэ бодол нь баахан хожимдож, завь нь гүүрний үзүүрийн харалдаа давлагаан оволзох хөлгүй гүн газар нэгэнт очсон тул үсэрвэл гарцаагүй үйж үхэх байлаа. Тэнгэрийн муухайд завьтай хүмүүс энд зогсох болбол гүүрэн дээрээс чулуудаж өгдөг үзүүртээ туухай бүхий эвхээстэй татлага Лонгрений гар дор байсны дээр далай тийш туугдан яваа Меннерс одоохондоо нэг их холдоогүй арваад сажин хэртэй байсан учир бас ч гэж аминд нь орж болох байлаа.

— Хүүе Лонгрэн! Мануухай шиг зогсоод байдаг чинь юу вэ! Үхэх гэж байгааг минь харахгүй байна уу. Аль, тэр татлага чулуудаач гэж сүнс нь зайлсан Меннерс хашхирав.

Лонгрэн завин дотор тэлүүлэх Меннерсийг тайван харж, үг дуугарсангүй, зөвхөн тамхиа хүчтэй баагиулснаа, түүний яаж байгааг нь сайн харж авах гэсэн мэт гаансаа амнаасаа авав.

— Лонгрен, чи дуулж байна уу? Үхэх нь, амь авраач! гэж Меннерс орилов.

Гэвч Лонгрен түүний цөхрөн хашхирахыг үл сонсох мэт мөн л дуу гарсангүй. Завь холдон одож, Меннерсийн хашхирах, хэлэх үг дуулдахтай үгүйтэй болох энэ завсар Лонгрен хөлөө ч зөөж гишгэсэнгүй. Меннерс айсандаа уйлж нэг үзэж, усан цэргийг загасчид дээр очин, туслахыг гуйгаач гэж гуйж нэг үзэж, мөнгө өгнө гэж амлаж ч нэг үзэж, занан сайн амьсгаа аваад

— Нэг эмэгтэй чамаас бас ингэж гуйж байсан шүү. Меннерс, чи амьдадаа түүнийг сайн санаж, сайн бод гэж хашхирчээ.

Меннерсийн бархирах чимээ сонстохоо болиход Лонгрен гэрийн зүг явав. Ассоль охин сэрж харвал эцэг нь бөхөх гаж байгаа дэнгийн гэрэлд гүн бодлого болон сууж байлаа. Охиныхоо дуудахад босож хажууд нь очоод, унасан хөнжлийг нь засан хучаад

— Миний охин унт аа, өглөө болох яагаа ч үгүй байна гэсэнд

— Та яаж суугаа юм бэ? гэвэл

— Аав нь муухай тоглоом хийчихлээ, хүүхээ, унт! гэжээ.

Меннерсийг алга болсонд маргааш нь Капернаар л нэг бөөн яриа болж, зургаа хонож байтал хорсож уурласан түүнийг дөнгөж голтой юм олж авчирчээ. Түүний ярьсан зүйл ойр хавийн тосгоноор дорхноо тарав. Меннерс орой болтол хөвжээ. Ухаан алдсан мухлагийн эзэн осолхон л бол далай руу авч хаях гэж сандарган дошгирох давлагаатай үхэлдэн тэмцэлдсээр завины хажуу, ёроолд няц нүдүүлэн явтал нь Кассет орж яваа «Лукреция» онгоц таарч авчээ.

Салхинд цохиулж, сандарч цочсоноос болж Меннерсийн хоногийн тоо гүйцсэн аж. Дөчин найман цаг хүрэхтэй үгүйтэй амьд байхдаа хорвоо ертөнцөд байж болох, ухаан санаанд багтаж болох гай зовлон бүр Лонгренд ирэг гэж туж харааж зүхжээ. Үхэх гэж байхад нь усан цэрэг туслалгүй, харж зогссон гэж Меннерсийн ярихад капернийхан цочирдон гайхав. Тэгээд ч амь тавьж байгаа хүн дөнгөж амьсгалж, дуу тавин ёолж байсан болохоор түүнд нь бүр ч үнэмшихээс биш яах вэ. Лонгрений доромжлуулснаас илүү доромжлол гэж байхгүйг санах хүн, Мерийнхээ хойноос Лонгрений насан туршаа гашуудаж байгаа шиг тэгж гашуудах хүн тэдний дотор тоотойхон гэдгийг үл өгүүлэн өгүүлэхэд Лонгрен юм дуугараагүй нь тэдэнд үзэшгүй булай, ухаанд оромгүй, онц хачирхам байжээ. Меннерсийн араас хэдхэн үг хашхиртлаа огт дуугаралгүй зогсож, хар цагааныг

шүүн тунгаагч адил хөдөлгөөнгүй, буурьтай чимээгүй байж, Меннерсийг яснаасаа жигшиж байгаагаа үзүүлжээ. Лонгрэн дуугараагүй нь зүгээр нэг үзэн ядсанаас ч хамаагүй жинтэй байсныг цөм мэджээ. Хэрэв Меннерсийн айн бачимдаж байгааг харахдаа бах тав ханан хашхирч, зангаж, дэвхэцсэн буюу эсвэл өөрийн баярласныг өөр ямар нэг байдлаар илчилсэн бол загасчид түүнийг ойлгох байлаа. Гэтэл Лонгрэн тэднээс өөр байж, буурьтай, ухаанд багтамгүй аашилж үүгээрээ бусдаас давуутайгаа харуулсан боловч үнэндээ уучлагдашгүй юм хийчихсэн юм. Толгой дохиж, гар барьж мэндлэх, танимхайран амарчилж харах ч хүн үгүй болов. Тосгоны ажил явдлаас тийнхүү хөндийрлөө. Хүүхэд багачуул түүнийг хармагц «Энэ Лонгрэн чинь Меннерсийг живүүлсэн» гэж хойноос нь хашхиралддаг байлаа. Лонгрэн үүнийг ер үл тооно. Бас гуанз далайн эрэг дээр завины дэргэд түүнийг очиход нь загасчид дуугаа хурааж, тахал туссан хүнээс зугтах шиг холдохын түүс болдгийг ч анзаарахгүй байх шиг санагддаг байлаа. Урьд тосгоныхон нь түүнд хөндийвтөр байдаг байсан бол Меннерст тохиолдсон явдлаас хойш бүр мөсөн холдож улмаар бие биеэ илт үзэж чадахаа больж, үүний гай Ассольийг ч дайрав.

Охин найз нөхөдгүй өслөө. Каперныхан эцэг эхээ юу гэвэл дагах ёстой гэсэн гэр бүлийн бүдүүлэг ёсыг ягштал баримталдгийг хэлэх үү, бас хаа газрын хүүхэд дуураймтгай байдаг болохоор үе тэнгийн нь хорь гучаад хүүхэд байвч бяцхан охинтой огт тоглож наадахаа больжээ. Томчуул хүүхдээ Ассольд ойртож болохгүй гэж тас хорьж, хавьтвал нь дуудан буцаах тул усан цэргийнх рүү зүглэж болохгүй юм байна гэж хүүхэд балчирхан ухааныхаа хэрээр ойлгож, хов жив, цуу яриа дайран дээр нь давс нэмсээр тэднийхээс айн ширвээтэх болжээ.

Түүний дээр Лонгрэн зожгирон суудгаараа элдэв цуу дам үг гарахын морийг нь эмээллээд өгчихжээ. Усан цэргийг хаа нэгтээ хүн алсан юм гэнэ лээ, үүнээс болоод хөлөг, онгоцонд алба хаахаа байсан юм гэнэ лээ, «ял үйлдсэндээ гэмшин тарчлах» учир ийм дүнсгэр оорцог байдаг юм байх гэж улс амьтан цуурхах болов. Багачуул тоглож байгаад Ассольийг дэргэдээ ирвэл шавраар шидэж, эцгийг нь хүний мах иддэг, одоо хуурамч мөнгө хийдэг болсон гэж дооглон хөөдөг байлаа. Охин тэдэнтэй ойртох гэж гэнэхэн оролдох болгондоо гомдон уйлж, хөх няц болтлоо зодуулж, зулга шалба маажуулж, олон түмэн өөрт нь яаж хандаж байгааг биеэр үздэг байлаа. Сүүл сүүлдээ энэ бүхнийг тоохоо больсон боловч «Бид хоёрт яагаад хүмүүс дургүй байдаг юм

бол?» гэж ааваасаа үе үе асуудаг, аав нь «Ээ охин минь, цаадуул чинь хайрлах энэрэхийг мэддэг гэж үү? Хайрлаж чадах гэдэг том юм аа, хүүхээ цаадуул чинь тэгж чаддаггүй улс аа!» гэж хариулдаг байжээ. «Хайрлаж чадна гэж юу хэлж байгаа юм бэ?» гэж охиноо шалгаахад Лонгрэн түүнийг өргөж, гуниг дүүрэн нүдээ таатайяа анихад нь нүдэн дээр нь чанга гэгч үнсээд «Үүнийг л хэлдэг юм даа!» гэх билээ.

Орой үдшийн цагаар юм уу, баяр ёслолын үеэр эцгийгээ лаазтай цавуу, багаж хэрэгслээ хойш тавьж, хийж байгаа ажлаа гүйцээлгүй орхиод, хормогчоо тайлж, гансаа зуун амрахаар суухад нь Ассоль өвөр дээр нь гарч, эцэгтээ тэврүүлэн эрхэлж, тоглоомын энэ тэр хэсгийг заан, юу хийх гэж байгааг нь шалгааж байхдаа нар нь гардаг байлаа. Аж амьдрал, амьтан хүний тухай өвөрмөц яриа ингэж эхэлнэ. Лонгрэн урьд үзэж харсандаа дулдуйдаж, гэнэтийн явдал, санаандгүй тохиолдол, ер нь гайхалтай хачин сонин явдлыг голчилж ярина. Охиндоо хөлгийн хэрэгсэл дарвуул, далайд хэрэглэгддэг зүйлийн нэрийг хэлж өгөн яриандаа булуу нь халж бархагын тогтоолго залуурын хүрд, шураг буюу зарим завь ийм үед тийм юманд хэрэглэгддэг гэх зэрэг нарийн юм руу орон энд тэндээс замбараагүй ярьж байснаа. болиод далайн аяллыг нэлэнхийд нь зураглаж, итгэж сүсэглэдэг юмаа үнэн бодитой болгож, үнэн бодитой юмыг зөгнөл мөрөөдлөөрөө тайлбарлана. Онгоц сүйрэхийн ёр бол судалт муур гэнэ, хүний хэл мэддэг далавчит загас тааралдаад айлдсаныг нь дагахгүй бол замаас төөрүүлдэг гэнэ. Догшин багийнхныхаа хамт явах Нисдэг Голланд зөн совин, хий юм, лусын дагина, далайн дээрэмчин зэрэг намуун сайхан өдөр буюу наргиж суух дуртай архины мухлагт далайчдын цаг нөхцөөхдөө ярьдаг үлгэр домгийг хүүрнэдэг байлаа. Тэрчлэн хөлөг онгоц нь сүйдээд зэрлэгшин хэлээ мартсан хүн, нууцлагдсан эрдэнэс, цөлөгдөгсдийн үймээн гээд олон олон юмыг ярихад охин шинэ тив нээсэн тухай Колумбын яриаг хүн анх сонссоноос ч илүү анхааралтай чагнадаг байлаа. Лонгренийг бодлогошрон чимээгүй болоход Ассоль «Дахиад ярь л даа» гэж шалгаасаар элгэнд нь толгойгоо нааж, сайхан зүүд зүүдлэнхэн унтчихдаг байсан юм.

Лонгрений хийсэн зүйлийг дуртай худалдан авдаг хотын тоглоомын мухлагийн даамлыг ирэхэд Ассоль бөөн баяр болдог байв. Учир юу гэвэл ахиухан юм хямдхан авах гэж тэр даамал эцэгт нь тал засан охинд нь хоёр алим, амтат бялуу, атга самар авчирч өгдөг байлаа.

Лонгрэн үнэ хаялцах угаас дургүй учир жинхэнэ өртгөөр нь авахыг ихэвчлэн гуйх боловч даамал заавал буулгаж хэлнэ. «Би энэ завийг хийх гэж долоо хоног суусан юм. Таван ямхын завь шүү дээ, хараач, ямар бөх, ямар сайн суулттай, ямар ястай гээ? Ийм завь ямар ч шуургатайд арван таван хүн өлхөн даана» гэж Лонгрэн хэлнэ. Алимаа бувар бувар идэн, дороо шуухитнах охиноо харахдаа Лонгрэн зүтгээд байх тэсвэр алдан үнээ буулгахад даамал бөх гэгчийн маш хөөрхөн тоглоомоор сагсаа пиг дүүргэж аваад, дотроо инээсээр явж өгдөг байлаа.

Лонгрэн мод хагалж, ус зөөж, зуухаа галлаж, юм угааж, цагаан хэрэглэлээ индүүдэх зэргээр гэрийнхээ хамаг ажлыг бөөрөнхийлөхийн хажуугаар самбаачлан мөнгө олох ажил хийдэг. Ассолийг найм хүрэхэд эцэг нь уншиж бичиж сургав. Лонгрэн хот орохдоо хааяа түүнийг авч явдаг болж, сүүлдээ дэлгүүрээс мөнгө авах юм уу, бараа хүргэж өгөх болбол ганцаарыг нь ч явуулах боллоо. Лисс, Капернаас дөрөвхөн мод газар орших боловч охиныгоо бас тэр бүр үл явуулна. Хот ойрхон болохоор амь биед нь халдах аюул гайгүй ч гэсэн зам ой дотуур гардаг учир хүүхдийг айлгаж ичээх юм мундахгүй, юмыг яаж мэдэх вэ гэж хаширлана. Харин тэнгэрийн сайханд, зам гардаг төгөлд нарны гэрэл тунаж, цэцэг навч алаглан, анир чимээгүй налайсан өглөөний цагаар, сэтгэлд нь элдэв юм орж, айж цочих юмгүй үед л Ассолийг хот явуулдаг болсон юм.

Нэгэн удаа охин хот орж яваад зууртаа идээрэй гэж сагсанд хийж өгсөн тал бялууг идэхээр замын хажууд суув. Бялуугаа хазах зуураа тоглоомоо нэг нэгээр нь гарган харж байтал аавын нь шөнө хийсэн ер үзээгүй хоёр гурван тоглоом байжээ. Энэ дотор уралдааны жижиг завь байлаа. Худалдан авагч баячуулд зориулсан тоглоомын хөлгийн өрөөг доторлодог торгоны өөдсөөр цагаан завинд улаан дарвуул хийжээ. Завийг хийхдээ дарвуул болгочихмоор юм олдсонгүйд ганц байсан улаан торгоны өөдсийг хэрэглэсэн нь тэр бололтой.

Ассольд энэ завь их гоё санагдав. Галын дөл мэт баясгалант өнгө гарт нь цог шиг содхон улайрна. Шургааг дамнуулан тавьсан бяцхан горхи зам огтлон шаагина. Горхины эх адаг хоёр тийш битүү мод үргэлжилнэ. «Үүнийг усанд жаахан хөвүүлээд үзье байз, юу л норно гэж, сүүлд нь арчих юм чинь» гэж Ассоль боджээ. Гүүрийн цаадах мод тийш горхи уруудан очоод сэтгэл булаасан онгоцоо усанд болгоомжтойхон тавив. Улаан дарвуул тунгалаг уснаа тольдон туяарч,

ёроолынх нь цагаан чулуу ягааран жирвэгэнэв. «Ахмад аа, чи хаанаас ирэв?» гэж Ассоль додигор гэгч нь асуугаад өөрөө дорхон нь «Би... би... би... Хятадаас ирлээ» гэж хариулав. «Чи юу авчрав?», «Юу авчирснаа хэлэхгүй ээ», «Уухай, тийм бий, чамайг эргүүлж сагсанд хийнэ дээ» гээд би тоглосон юм, авч яваа заанаа үзүүлье гэж ахмадын өмнөөс хэлэх гэтэл эрэг мөргөсөн долгион буцахдаа завины хошууг горхины гол руу эргүүлсэнд нөгөөх нь бүр ёстой завь шиг хамаг хурдаараа холдож, доошоо намалзтал хөвж гарав. Агшин зуур нүдэнд нь бүх юм өөрчлөгдөж, бяцхан горхи асар том мөрөн шиг, жижиг завь нь алс хол яваа аварга том хөлөг шиг, айж сандарсан Ассоль ус руу арай л уналгүй тэр хөлгийн зүг сарвайн зогсох мэт бодогдлоо. «Мань ахмад айж» гэж бодоод урсан одох тоглоомынхоо араас гүйж, нэг газар урсгалаар эрэгд ээр гарчих биз гэж найдаж байв. Нэг их хүндгүй ч гэсэн гүйхэд нь тээр болох сагсаа чирэн алдсаар «Ээ тэнгэр минь! Үгүй мөн гай яа... » гэж үглэж явлаа. Алгуурхан хөвсөөр байгаа гоё гурвалжин дарвуулын барааг алдчихгүйг хичээн унан тусан гүйсээр байв.

Ассоль хэзээ ч ингэж ойд лав орж байсангүй. Тоглоомоо л барьж авах сан гэж сэтгэл яараад хажуугийнхаа сатааран саатмаар сонин хачныг ч харах сөгөөгүй явна. Хөвдөт нүүл, нүх сүв, өндөр ойм, нохойн хошуу, мэлрэг цэцэг, шид мод алхам тутамд нь саад болж эдгээрийг туулж гарах гэсээр тэнхээ барагдаж, амсхийх буюу нүүртээ наалдсан аалзны шүлсийг арчих гэж зогсох нь улам олширлоо. Ожирс, зэгс өргөхөн шагшуургалсан газарт нь улалзан гялалзах дарвуулын барааг алдаж, горхины тохойг тойрохдоо баригдах ёргүй зугтаах завиа дахин олж харна. Нэгэн удаа эргэн үзвэл хүглэгэр их ой нэвсийн нүүгэлтэж, нэг хэсэг газар зурвас гэрэл навч нэвтлэн тоосорч, нэг хэсэг газар балар харанхуй татах зэргээр цоохорлон байх нь их л сүртэй ажээ. Ассоль агшин зуур зүрх алдсанаа тоглоомоо санахдаа хэдэнтээ урт амьсгаа аваад хар тэнхээгээрээ гүйв.

Ийнхүү дэмий сандран хөөцөлдсөөр байтал цаг хэртэй болж, нэг үзвэл өмнөх мод сийрэгшин шингэрч, далайн цэнхэр мандал, сэмжин үүл шар элсэн эрэг нүднээ цэлсхийсэнд гайхах, сэтгэл амрах хоёр хослон, ядарсандаа сөхөрчих шахсаар элсэн эрэг дээр гүйж гарав. Горхи энд адагтаа ирээд, улам нарийсан, ёроолын нь чулуу хөхрөн ирвэгэнэн үзэгдэхээр гүехэн болоод, далайн долгионд шингэн алга болох ажээ. Модны үндэс сэрвийлдэх намхан эрэг дээр горхины

хажууд хавтгай том чулуун дээр нэг хүн цааш харан суугаад, завийг нь барин, эвэртэй туулай үзсэн мэт эргүүлж тойруулан үзэж байв.

Тоглоом нь бүтэн байсанд дотор нь жаал уужран, ганга руу гулсан буугаад, үл таних хүнд дөтлөн очиж түүний дээшээ болохыг нь хүлээх зуураа сонжин харав. Гэвч тэр хүн ойд тааралдашгүй оньсого шиг тоглоомыг үзэн хамаг бүхнийг огоорсон байсан учир охин түүнийг зулгаас зулайг нь хүртэл харж амжаад энэ танихгүй хүнэрхүү хүнийг огт үзээгүй юм байна гэж боджээ.

Тэр хүн бол явгаар аялж, үлгэр, домог, дуу шүлэг цуглуулдаг нэрт үлгэрч Эгль байсан юм санжээ. Буржгар буурал үс нь сийрсэн бүрх малгайн дороос цухуйж, саарал цамцаа хөх өмднийхөө дотуур чихэж, өндөр түрийтэй гутал өмссөнийг нь үзвээс анчин гөрөөчин юм уу гэмээр цагаан зах, зангиа, мөнгөн товруу шигтгэсэн агсарга, таяг, шинэхэн дэц түгжээтэй цүнхийг нь ажваас хотын хүн ч юм уу гэмээр. Гялтганасан өтгөн бавгар сахал, дээшээ атиран сөрвийсөн живрийн нь дотроос цухуйх хамар, уруул, нүд гурвыг нь нүүр гэж хэлж болдог бол тэр хүний нүүр нь шарангуй, цэвэр ган шиг гялтганах хонин бор нүдний нь харц эршүүд бөгөөд зоримог ажээ.

— Одоо надад өгчих. Та зөндөө тоглолоо шүү дээ.

Та яаж бариа вэ? гэж охин хулгасхийн асуув.

Ассолийн догдолсон дуу гэнэт цангинасанд Эгль, завиа унагаад дээш болов. Өвгөн инээмсэглэж, шөрмөс гүрийсэн парвигар гараараа сахлаа аяархан шувтарч охиныг хувь хэртэй харав. Угаасаар байгаад онгосон эрээн давуу даашинз нь чөргөр бор хөлийг нь дөнгөж өвдгөөр татах ажээ. Торон хошуу алчуураар даран боосон өтгөн хар үс нь мөр рүү мушгиран буужээ. Ассолийн төрх хөнгөхөн, цэвэрхнийг үлгэрлэвээс хараацай шувуу дүүлэн нисэх мэт. Нэгийг гунигтайяа асуух мэт харах хар нүд нь нүүрээсээ овортой мэт санагдана. Гонзгойдуу ялдамхан цагаан царай нь хөөрхөн гэгч борлосныг үзэхэд эрүүл арьсны өнгө ийм л байдаг болов уу гэлтэй. Ялихгүй ангайсан бяцхан уруулд нь цайлган инээмсэглэл тодорно.

— Гримм, Эзоп, Андерсений нэрийг барьж тангараглая. Энэ чинь тун гайхалтай онцгой юм байх чинь вэ. Аль вэ, бялзуухай минь, энэ чиний юм уу гэж Эгль охиныг нэг харж, завийг нэг харан өгүүлсэнд

— Тийм ээ, минийх, би хойноос нь хэчнээн хөөв өө. Үхэх нь л гэж бодож байлаа. Энд байв уу? гэсэнд

— Яг хөлийн минь дэргэд. Миний биеийг эргийн дээрэмчний хувьд чамд үүнийг өргөн бариг гэж л энэ хөлөг энд сүйрчээ. Баг нь орхиж одсон завийг гурван ямхын давлагаа миний зүүн хөлийн өсгий, таягийн үзүүр хоёрын хооронд гаргаж хаясан юм гээд таягаараа түншсэнээ, — Чамайг хэн гэдэг вэ, охин минь? гэсэнд охин Эглийн өгсөн тоглоомыг сагсандаа хийх зуураа

— Ассоль гэж хэлэв.

Өвгөн үл ойлгогдох яриагаа үргэлжлүүлж

— За, үнэндээ чиний нэрийг асуух ч хэрэггүй байсан юм. Харин сум шурхийх, дун ханхийх шиг сонин, эгшиглэсэн нэр байсан нь юутай сайн бэ. Далдын сайхныг мэдэх хүсэл оргилуулж, сэтгэл гижигдэхгүй, чихэнд олон сонстсон энгийн нэр хэлсэн бол би яана аа. Гэхдээ чиний хэн болох, эцэг эх чинь ямар улс болох, яаж аж төрдөг зэргийг тэр тусмаа мэдэх хэрэг надад алга аа. Хөөрсөн сэтгэлийг хөргөхийн хэрэг юу вэ. Би энэ чулуун дээр фин, япон үлгэрийн сэдвийг харьцуулж суусан юм... Гэтэл горхи энэ завийг гадагш шидлээ... Дараа нь чи хүрч ирлээ. Яг л байгаа дүрээрээ ирлээ. Охин минь, би хэзээ ч шүлэг зохиол бичиж байгаагүй ч гэсэн сэтгэл зүрхээрээ бол яруу найрагч хүн. Чи юу авч яваа юм? гэхэд Ассоль сагсаа сэгсчин

— Завь, нэг онгоц, бас далбаатай гурван байшин байгаа. Дотор нь цэргүүд байгаа гэсэнд

— Сайн байна. Чамайг худалдаад ир гэж явуулж. Чи замдаа тогlochож, завиа хөвүүлж үзсэн чинь урсаад явчхаж. Тийм биз? гэхэд Ассоль өөрөө үүнийг ярьсан үгүйгээ санах гэж оролдон

— Та харсан юм уу? Хэн танд хэлсэн юм? Эсвэл таасан юм уу гэж эргэлзсэнд

— Би мэдсэн юм гэв.

— Яаж?

— Би чинь хамгийн мундаг илбэчин байхгүй юу.

Эглийн ингэж хэлэхэд уулаас айн түгшиж явсан Ассоль бүр ч айн сортосхийв. Завьтай эцтэлээ хөөцөлдсөнийг хэлэх үү, далайн эрэг эл хуль, нам гүм, гялалзсан нүдтэй өвгөний яриа ойлгомжгүй, сахал үс нь сүртэйг хэлэх үү, ид шид, биетэй бодитой хоёр нийлчихсэн мэт охинд санагджээ. Одоо Эгль нүүр амаа мурийлгах юм уу, нэг чангахан зандрахад л охин уйлж, үнхэлцэг хагарах шахан ум хумгүй зугтах

байлаа. Гэвч Эгль охины нүд нь том болж ирэхийг хараад дорхноо эргэж

— Надаас ер айх хэрэггүй. Харин чамтай сайхан ярилцмаар байна гэв.

Охины царайг харахдаа өөрийн сэтгэлийг юу тэгж их татсаныг сая ойлгов. «Үзэсгэлэнт сайхныг, аз жаргалтай хувь зохиолыг өөрийн эрхгүй хүн хүлээдэг юм. Юунд би зохиолч болж төрсөнгүй вэ! Ямар гайхамшигтай сэдэв бэ!» гэж үлгэрч халаглажээ.

Тэгээд учир нь олдохгүй байхаа (дандаа үлгэр зохиосоор түүнийхээ амтанд орсондоо хөтлөгдөж их мөрөөдлийн үрийг үл мэдэх хөрсөнд цацахаас ч буцахгүй болжээ) болих гэж оролдон.

— За хөө, Ассоль, миний ярихыг сайн сонсож ав. Миний ороод гарсан Каперна тосгоноос чи яваа бололтой. Би үлгэр дуунд дуртай, тэгээд хэний ч сонсоогүй сонин юм дуулах гэж би танай тэр тосгонд өнжлөө. Гэвч танай тосгонд үлгэр хэлдэггүй, дуу дуулдаггүй юм байна. Ярьж дууллаа ч гэсэн зальтай тариачин, цэргийн тухай ярьж дуулдаг булхай луйврыг магтсан түүх, шивэртэй хөл шиг бохир, гэдэс хурчигнах мэт бүдүүлэг айдас хүрэм сэдэвтэй оготорхон дөрвөн мөрт шүлэг хэлдэг юм байна. Байзнаарай, би хадуураад явчихлаа. Дахиж ярья гэснээ жаал бодоод:

— Хэдэн жил болохыг хэлж би мэдэхгүй байна. Капернад удтал дурсагдах үлгэрийн нэгэн явдал болно. Ассоль, чи өсөж томоо болно. Алс далайн уудамд, ургах нарны доогуур аранзал улаан дарвуул нэг өглөө чамд солонгорон харагдана. Туяаран гэрэлтсэн асар том дарвуултай хаш цагаан хөлөг номин цэнхэр давлагаа зүсэн чанх өөдөөс чинь чиглэн ирнэ. Энэ гайхамшигт хөлөг үхэр буу тавьж, уухай түрлэг хашхирч сүр бадруулахгүй намуухнаар хөвөн айсахад далайн эрэг дээр буман хүн бужигнан цуглаж, шагшран шуугин гайхацгаах болно. Тэдний дотор чи байх юм. Тэр хөлгийг цангинах хөгжим эгшиглүүлж сүр жавхлантайяа эрэгт ойртон ирэхэд цул хивс, саа, цэцэг бүрхсэн түргэн завь хөлгөөс тасран хөвнө. Хэтийн санаа юунд вэ, хэрэг зориг хэнд вэ? гэж эргийн улс асууна. Тэгэхэд нүүртээ галтай нүдэндээ цогтой ганган залуу хун тайж чиний зүг гараа сарвайн зогсож байгааг чи олж үзнэ. Тэр хун тайж «Сайн байна уу? Ассоль минь ээ! Эндээс холын хол газар чамайг би зүүдэндээ үзлээ. Тэгээд аваачихаар ирлээ. Хоёулаа гүн ягаан хөндийд аж төрөн сууна. Тэнд чиний минь юу санасан есөн хүсэл чинь сэтгэлчлэн биелж, чи бид хоёр амар сайхан

жаргана. Уйлж унжих, уйтгарлаж гунихын ..зовлонг чи минь хэзээ ч үзэхгүй ээ» гэж чамд хэлнэ. Тэгээд тэр залуу чамайг завиндаа суулгаад хөлөг онгоцондоо авчирч, чи гайхамшгийн оронд үүрд очиж, чамайг ирсний мэндийг мэдэх гэж нар сар, мандаж, одон мичид тэнгэрээс бууж ирнэ» гэж ярихад нь

— Би ингэх юм уу гэж охин аяархан асуув.

Жаал охины хэвлүүхэн нүд гэрэлтэн, итгэлээр гийв. Хорон санаатай илбэчин бол яалаа гэж ингэж ярих вэ. Охин бүр ойртлоо.

— Тэр онгоц чинь ирчихсэн юм биш байгаа?

— Мөд ирэхгүй ээ, эхлээд чи миний хэлснээр том болно. Тэгээд... Юу ч гэж хэлэх вэ дээ, ирэхдээ л ирнэ, тэгээд л болох нь тэр. Чи тэгвэл яах вэ?

— Би юу? гээд охин сагс руугаа харснаа бэлэг болгочихмоор аятайхан юм тун олсонгүй бололтой. Би тэр хүнд сайн байна аа.... гэж яаран дуугарснаа. Намайг шоглохгүй бол гэж тээнэгэлзэсхийн нэмж хэлэв.

— Яалаа гэж шоглох вэ гэж илбэчин учиртайхан нүд ирмээд

— Шоглохгүй. Би баталъя. Охин минь яв даа, анхилам дарс хоёр балгаж, цөлөгдөгчдийн дууны тухай бодох зуур ахынхаа хэлснийг битгий мартаарай. Яв даа яв, сөөсгөр толгойт минь, урт наслах болтугай гэв.

Лонгрэн ногооныхоо бяцхан газар төмсний бут манаж байв. Өндийн харвал Ассоль охин нь хар эрчээрээ айсуй хийгээд царайд нь туйлын баярласан, нэг юм хэлэх гэж яарсан байдал тодорно. Охин амьсгаагаа царах гэж оролдон, эцгийнхээ хормогчноос хоёр гараараа зуурч

— Хүүш ... Аан гэж бай, танд юм хэлье. Далайн эрэг дээр, бүүр хол нэг илбэчин байна... гэлээ.

Эхлээд илбэчинтэй уулзсанаа, түүний сонирхолтой бэлгэдэж хэлснийг ярив. Ярих гэсэн юм нь дээр дээрээсээ давхцан сэтгэлд нь орж ирээд дэс дараатай ярихад саад болно. Илбэчний гадаад төрхийг ярьснаа болиод завиа алдан хойноос нь хөөцөлдсөн рүүгээ оров.

Лонгрэн охиныхоо яриаг таслалгүй анхааралтай чагнаж, яриад дуусахад нь өрөөсөн гартаа анхилам, дарс, нөгөөдөө тоглоом барьсан үл таних өвгөн хүний дүр сэтгэлд нь дорхноо ургав. Лонгрэн цааш эргэх гэсэн боловч хүүхдийн амьдралд том явдал болоход буурь суурьтай байж, гайхсан дүр үзүүлэх ёстойг санаад толгойгоо ёсорхуу

гэгч нь дохин, «Уухай, уухай. Бүх байдлаас үзэхэд яах аргагүй илбэчин байж таарлаа. Би харах юм сан... Харин чи дараа явахдаа замаас бүү гар, ойд төөрч ядах юмгүй» гэж хэлжээ.

Лонгрэн хүрээ хаяад, намхан бургасан хашаа руу очиж суугаад охиноо өвөр дээрээ авав. Туйлгүй ядарсан охин өөр юм нэмж ярих гэсэн боловч халууцан, догдолж сульдсандаа болоод нойрт дийлдэж эхлэв. Нүд нь анилдаж, толгой нь эцгийнхээ чийрэг мөрийг налж, хариугүй давсны жинд явдаг дээр хүрсэн боловч яах бол гэж сэтгэл түгшсэндээ нүд аньстайгаа, гараараа хантаазыг нь тулан өндийж суугаад

— Илбэчний хэлсэн хөлөг намайг авахаар ирэх болов уу, үгүй болов уу гэж чанга гэгч асуухад нь усан цэрэг

— Ирнэ ээ ирнэ. Чамд тэгж хэлсэн болохоор ирж л таарна гэж тайван хэлэв.

«Том болохдоо мартаж биз ээ. Одоохондоо урмыг нь хугалаад яах вэ. Хожим хойно хүүд минь аранзал дарвуул тааралдахгүй, бохир, зэрлэг дарвуул, холоос харахад гоёмсог цагаан мөртөө ойртоод очиход уранхай зэвүүн далбаа мөн ч олон тааралдана даа. Явуулын хүн муу охиноор минь даажигнажээ. Яах вэ? Бэлгэ дэмбэрэлтэй л тоглоом байна. Дажгүй ээ. Өдрийн хугас ой, ширэнгэд явсаар зүдэрч дээ зүдэрч. Аранзал дарвуулаа над шиг л мөрөөд дөө, улаан дарвуулт хөлөг чинь ирнэ ээ ирнэ» гэж боджээ.

Ассоль унтав. Лонгрэн сул гараараа гаансаа авч тамхи нэрэхэд салхиар утааны үнэр нь сүлжмэл хашаа нэвтлэн, гаднах бутны дэргэд буруу хараад бялуу идэж суусан гуйлгачин залуугийн хамрыг цоргижээ. Эцэг хүүхэд хоёрын яриа сэтгэлийг нь хөгжөөж, сайн тамхины үнэр олз олохын санаа авхуулав бололтой.

— Буянтан минь муу ядуудаа тамхи хайрла. Миний тамхи таны тамхины дэргэд тамхишуу юм биш гэж хашааны завсраар гуйсанд Лонгрэн аяархан

— Уг нь өгөлгүй яах вэ. Даанч тамхи маань нөгөө талын халаасанд байгаа. Охиноо сэрээмээргүй байна даа гэсэнд

— Үгүй мөн гай яа! Сэрвэл сэрнэ л биз, дахиад л унтана шүү дээ, явуулын хүнд ганц тамхи татуулчихвал зүгээр сэн дээ гэвэл

— Чамд ямар ч гэсэн тамхи байгаа юм байна. Хүүхэд ядарсныг харахгүй юу. Яах вэ оройхон ирээрэй л дээ гэсэнд гуйлгачин зэвүүцэн нулимж саваандаа хүүдийгээ өлгөөд

— Ямбатай эд байх нь. Далайн чанадах хөлөг онгоц энэ тэр гэж хүүхдийн толгойг мангууруулж байх ч гэж! Ээ чааваас, айлын эзэн гэх, ёстой хачин амьтан юм даа чи гэж ёжлоход Лонгрэн нам дуугаар

— Би охиноо сэрээдэг юм гэхэд чиний мангар хүзүүг хуга мушгих болно доо. Тонил цаашаа! гэв.

Хагас цагийн дараа гуйлгачин гуанзанд арав гаруй загасчдын дунд сууж байлаа. Тэдний ард өтгөн хөмсөг, бэлцгэр гартай тэнтгэр эхнэрүүд нь суун, нөхрийнхөө ханцуйнаас нэг татаж, мөрөн дээгүүр нь аягатай архийг нь аван нэг уух ажээ. Гуйлгачин хор нь буцлан

— ...Тэгээд надад тамхи өгөөгүй. «Чамайг насанд хүрэхэд тусгай улаан дарвуулт онгоц... чамайг авахаар ирнэ. Яагаад гэвэл чи хун тайжтай суух тавилантай. Тэр илбэчний хэлсэнд итгэх хэрэгтэй» гээд л ярьж байх юм. Би тэгэхэд нь сэрээж байгаад ч гэсэн тамхи аваад өгчих л дөө гэсэнд намайг замын гол хүртэл хөөв шүү хэмээн бурж байлаа.

— Хэн гэнэ ээ? Юу гэнэ ээ? Юу ярьцгаагаад байна аа гэж эмэгтэйчүүд үгэнд дурлав.

Загасчид толгойгоо арайхийн эргүүлж, дооглонгуйгаар тайлбарласан нь

— Цаад Лонгрэн чинь охинтойгоо бүр зэрлэгшээд ухаан согогтой болсон бололтой. Тэднийд илбэчин ирж. Тэгж ойлгох хэрэгтэй. Тэр хоёр улаан дарвуултай онгоцоор далайн тэртээгээс ирэх хаан хүүг хүлээж байна гэнэ. Авгайчуул та нар хожимдоодох вий! гэлцэв.

Гурав хоноод Ассолийг хотын мухлагаас буцаж явтал

— Хөөе, дүүжлүүлмэр! Ассоль! Нааш хараач! Улаан дарвуулт хөлөг ирж явна! гэх нь анх удаа сонстов.

Охин дав хийж, далайн мандлыг өөрийн эрхгүй саравчлан харав. Тэгээд хашхирсан зүг эргэн үзвэл хориод, алхмын тэртээ хэсэг хүүхэд бөөгнөрөн зогсоод хэлээ гаргаж, нүүр амаа мурийлган тохуурхаж байлаа. Охин нэгэнтэй санаа алдаад гэр рүүгээ гүйчхэв.

II : ГРЭЙ

Ром хотод дэд байснаас хөдөө тосгонд тэргүүн байсан нь дээр гаж Юлий Цезарь үздэг байсан бол энэ их хүний мэргэн хүсэлд Артур Грэй ер атаархах хэрэггүй байв. Грэй, хөлгийн ахмад болох хувьтай төрж, ахмад болох гэж хүсээд санасандаа хүрсэн юм.

Грэйн, төрж өссөн лут том байшингийн дотор ороход баргар харанхуй атлаа гаднаас нь харахад сүрлэг төгөлдөр билээ. Байшингийн өмнө талд цэцэрлэгийн тал, цэцгийн мандал байх агаад мөнгөлөг хөх, нил ягаан, ягаан туяат хар гээд алтан зулын дээж болсон цэцэгс ногоон зүлгэн дээр маяглуулан цацсан сувд аятай угалзлан жирийж, өвгөн модод хээлэн урсах бяцхан торхийн хагд ожирс шагшуургын дээр униар дунд зүүрмэглэн байна. Тэр бол жинхэнэ харш байсан болохоор төмөр угалзан холбоостой мушгиа ширмэн шон бүхий хашаатай билээ. Шон бүрийн оройд гоёмсог ширмэн сараана цэцгэн цөгц сийлэн гаргаж, баяр ёслолын цагаар эдгээр цөгцөнд тос дүүргэн, гал асаахад шөнийн харанхуйд зэл татан ярайж үзэгддэг байжээ.

Грэй хүүгийн эцэг эх нь бидний хэмээн өөриймсөглөх нийгмийнхээ эрх ямба, эд баялгийг эдэлж, хууль зүйг нь ёсчлон баримталж байх тавилантай гэж үздэг ихэмсэг намбатай улс юм. Өтгөс дээдсийнхээ тухай тэдний бодож санадаг нь өгүүлээд байхааргүй бөгөөд харин бяцхан хүү Грэйгээс эхлээд гал голомтыг нь хойшид залгах үр садныхаа тухай зөгнөн боддогийг нь яриуштай. Грэй урьдаас зохиож өгсөн төлөвлөгөөнөөс гажилгүй энэ яваа насаа өнгөрүүлж, гэр бүлийнхээ нэр төрийг хөөдөн гутаахгүй бол үхэхийн цагт хөрөг нь гэрийн хананд хадагдах ёстой аж. Гэтэл энэ талаар баахан ташаа болсон бол уу. Грэй, уг удмынхныхаа хувь зохиолыг дагахааргүй сэргэлэн төрсөн байлаа.

Жаал хүүг найм хүрэхэд сэргэлэн, цовоо, этгээд гаж зан нь тодрох боллоо. Сонин хачныг ургуулан боддог рыцарь, адал явдлыг эрэлхийлэгч, сонин гайхамшгийг бүтээгч буюу нэг үгээр хэлбэл аж амьдралын тоолж баршгүй олон үүргийн дотроос юмыг билгийн нүдээр харах хамгийн аюул осолтой, хамгийн сэтгэл хөдлөм үүргийг сонгож авах хүн болох нь, Грэй нэг өдөр цовдлогдсон христосын зурагт сандал тавьж хүрээд, түүний цус болсон мутраас хадаасыг нь сугалж хаясан буюу ердөө л будагчнаас сэм авсан хөх будгаар түүнийг

нялж орхисноос мэдэгдсэн юм. Зургийг ийм байдалтай байвал арай аятайхан гэж боджээ. Энэ сонин ажилдаа бүр улайгаад цовдлуулсан Христосын хөлийг будаж эхэлж байтал эцэг нь орж ирэн жаал хүүг чихдэн сандал дээрээс буулгаад

— Яагаад зураг муухай болгов? гэж асуухад

— Муухай болгоогүй ээ гэж,

— Энэ чинь алдарт уран зураачийн бүтээл шүү дээ гэхэд нь

— Яадаг юм. Хүний гараас хадаас ёрдойж цус урсаж байхыг би тэвчихгүй. Би ингүүлэхгүй гэж ээ.

Хүүгээ ингэж хариулсанд Лионель Грэй инээдээ барьж, өөрийнх нь занг яг дуурайсныг мэдэж, гэсгээн шийтгэсэнгүй өнгөрүүлсэн юм.

Бяцхан Грэй харшийн нүх сүв бүрээр нэгд нэгэнгүй шургаж сонин сонин юм шинээр олж үзэж байлаа. Дээврийн хөндийгөөс баатрын хэмхэрхий болд хуяг, төмөр, ширээр хавтасласан ном, хувцасны тамтаг олж, бөөн тагтаа байхыг үзсэн бол дарс хадгалдаг зооринд улаан дарс, цагаан дарс, хатуу дарсны тухай сонин сонин юм олж мэдэв. Энд чулуун гурвалжин адрынх нь энгээрх гурвалжин цонхоор тусах сүүмгэр гэрэлд том жижиг торх үзэгдэж, газраас цухуйх хамгийн том хэвтээ модон торх зоорины ханыг тэр чигээр нь халхалж, зуун наст хар царс мод нь зүлгэсэн юм шиг гялтганана. Торх, гангийн дунд сүлжмэл сагсан дотор ногоон, хөх цүүзгэр лонхнууд байна. Ханын чулуу, шороон дээр нарийхан шилбэтэй бор мөөг ургаж хаа л бол хөвд буриваа бүрхэж, хөгц чийг үнэртэж амьсгал боосон эхүүн үнэр ханхална. Оройдоо шингэх нарны туяа тусахад алсын буланд аалзны том тор алтарч үзэгдэнэ. Нэг газар Кромвелийн үеийн хоёр торхонд шилдэг Аликанте дарс булаатай байх бөгөөд дарсчин хоосон буланг зааж, сүрэг хаваас илүү зүрх үхүүлэм үхдэлийг оршуулсан зартай булшны намтрыг ярих далим алддаггүй байлаа. Тэр бээр яриагаа эхлэхдээ том торхны цоргыг марталгүй үзэж, холдохдоо хосгүй баярын нулимс хөгжилтэй нүдэнд нь бүрхсэн байдгийг харахад үнэхээр нэг сэтгэл нь амарсан янзтай байдаг байлаа.

Польдишок, хоосон хайрцаг сандайж, хянган хамартаа тамхи чихэж аваад Грэйд өгүүлрүүн:

— Ингэхэд тэр газрыг харж байгаа биз? Тэнд байгаа дарснаас жижиг аягаар ч гэсэн уух соёрхол олдвол нэгээр тогтохгүй архичин нүдээ ухаад өгчихсөн биз? Цээжинд байгаа үгийг хатгаж цэлмэг биеийг усан шалхнаг болгож чадах зуу зуун литр ундаа торх бүрд бий.

Энэ дарсны шинжийг хэлбэл интоор жимснээс хүрэн, лонхноос гоожихооргүй өтгөн дөө. Хийсэн торх нь гэвэл ган төмрөөс дутахгүй бөх хар мод. Тэр торхонд аранжин зэсээр давхар бүслүүр хийж, бүслүүр дээр нь «Грэй, диваажинд залрахдаа надад ам хүрнэ» гэж латинаар , цохисон байгаа. Энэ бичээсний учрыг янз янзаар тайлдаг юм аа. Чиний элэнц эцэг, дээд төрөлт Симеон Грэй зуслан барьж, «Диваажин» гэж нэрлээд, учир битүүлэг сургаалаас зөрөлгүйгээр дарсыг уучих ухаан тэрүүхэндээ сийлж л дээ. Тэгсэн чинь юу болсон гэж бодно оо? Нанчдад дуртай өвгөн бүслүүрийг мултлах гэж байгаад сэтгэл хөөрсөндөө ч юм уу, ямар ч байсан зүрх нь дэлбэрч өөд болсон юм. Тэр цагаас хойш үнэт энэ дарсыг гай зовлон уддаг гэж итгээд энэ торхонд огт гар хүрэхээ больсон гэдэг. Үнэндээ бол мисир газрын ховдос ч ийм оньсого таалгахгүй сэн. Тэгэхдээ тэр ховдос нэг цэцэн хүнээс «Би бусдыг иддэг шигээ чамайг идэж чадах уу? Үнэнийг хэлбэл чамайг амьд үлдээнэ» гэсэн юм гэдэг.

Гэвч сийрэгхэн бодоод үзэхэд... гэснээ, — Дахиад л цорго гоожоод унав аа даа гэж өөрөө үгээ таслан, маажиг маажиг гэсээр булан руу очиж, цоргыг чангалаад, царай нь гэрэлтэй сайхан болж, цааш залган. Тэр цэцэн хүн яаралгүй сайн эргэцүүлээд «Ай хө, хоёулаа нанчид хүртье, тэгвэл чамд дэмий юм бодогдохоо болино» гэж хэлбэл таарах байсан юм. «Грэй, диваажинд залрахдаа надад ам хүрнэ». Юу гэсэн үг вэ? Үхсэн хойноо ууна гэсэн үг үү? Хачин юм. Грэй, ариун хутагт болохоороо амтат дарсыг ч, энгийн сархдыг ч уух ёсгүй гэсэн хэрэг үү? «Диваажин» гэж аз жаргалыг хэлжээ гэж бодъё. Ингэх дээр хүрвэл аз жаргал гэдэг хамаг өнгөтэй сайхнаа алдаад аз жаргалтай хүн маань «Энэ чинь диваажин мөн үү дээ» гэж үнэн сэтгэлээсээ асууна аа даа. Мөн золиг шүү. Ийм дарсыг санаа амар ууж, магнай тэнүүн баярлая гэвэл, хүү минь, өрөөсөн хөлөөрөө газар тулаад, нөгөөгөөрөө тэнгэрт гишгэх хэрэгтэй юм. Хэзээ нэгэн цагт Грэй ухаангүй согтуу байхдаа энэ дарснаас шаваагаа ханатал ууж, торхыг бүр шавхчихна гэдэг таамаг ч бий. Гэтэл энэ бол, хүү минь, захиасыг биелүүлж байгаа хэрэг биш, гуанзны архидаан болно гэсэн үг ээ гээд том торхны цоргыг дахин шалгаж үзсэнээ

— Энэ хоёр торхыг нэгэн мянган долоон зуун ерэн гурван онд чиний өвөг Жон Грэй Лиссабоноос «Бигль» хөлгөөр авчирчээ. Дарсны үнэд хоёр мянган алтан пиастр төлсөн гэдэг. Торхны бичээсийг Пондишер газрын зэвсгийн дархан Вениамин Эльян сийлсэн юм.

Торхыг зургаан футийн гүнд суулгаж усан үзмийн ишийн үнсээр манасан юм. Энэ дарсыг амсах амны хишигтэй хүн гараагүй, гарах ч үгүй гэж нухацтай бөгөөд дүнсгэрхэн хэлдэг байлаа.

Нэг удаа Грэй хөл дэвсэж

— Би наадахыг чинь ууна даа гэсэнд Польдишок

— Аргагүй л залуу хүн зүрхтэй байна! Чи диваажинд очсон хойноо уух юм уу? гэхэд Грэй аяархан инээж:

— Тэгэлгүй яах вэ. Диваажин гэдэг чинь энэ байна. Надад байна, хараач гээд бяцхан гараа дэлгэн үзүүлсэнд тодхон хээтэй булбарай алган дээр нь нарны туяа наадан гялалзахад гараа атгаж. Энэ дотор орчихлоо! ...Дахиад алга болчихлоо... гэж алгаа хэдэнтээ атган, хэдэнтээ тэнийлгэснээ тоглоом хийсэндээ их додигор гэгч нь харанхуй шатаар нэгдүгээр давхрын гудам руу Польдишокоос түрүүлэн гүйчхэв.

Грэйг, гал тогоонд орохыг тас хорьдог байсан боловч гал дүрэлзэж, уур утаа манарч, хөө тортог харлаж, хутга заазуур тачигнан харшиж, шөл цай шуугин порчигнон буцалж, шүлс гоожим үнэр ханх тавин байдаг гайхалтай энэ газар нэг орсноос хойш ер салахаа больжээ. Тогооч нар тахилчид лугаа адил дув дуугүй ажиллаж, хар тортог болсон ханан дээр гозгор цагаан малгай нь тодхон ялгарч хийж байгаа ажлыг нь ёслол төгөлдөр бодогдуулна. Наргианч тарган аягачид торхтой усны дэргэд шаазан мөнгө харшуулан, сав суулга угааж, зарц жаал хүүхдүүд сагс дүүрэн загас, хясаа, хавч, жимс тэргүүтнийг дааж ядан зөөнө. Алаг гургуул, бор нугас, эрээн тахиа, модгорхон сүүлтэй гахайн бүтэн мах, манжин байцай, самар хөх үзэм, шаргалтсан тоор урт ширээн дээр хөглөрч хэвтэнэ.

Гал зууханд буг чөтгөр орогнон, ордны бүх явдлыг далдын хүчээр хөдөлгөн байдаг гэж бодох учир Грэй, тэр том савд орохдоо баахан зэвүүцэн жийргэмсэглэх билээ. Тогоочид нэг нэгээ дуудах нь зарлиг болох, тарнидаж шивших мэт дуулдаж, тэд ажилдаа тун сурмаг, ганц алдалгүй яв цав хөдөлж барихыг нь харахад ёстой л онгод нь орох гэж ийм байдаг болов уу гэж бодогдоно. Везувийн галт уул шиг даргилан байх хамгийн том тогоог өнгийн харах нуруу хүрэхгүй байсан боловч түүнийг онцгой бишрэх бөгөөд хоёр зарц бүсгүй тэр тогоотойг хэрхэн хутган самарч шөл нь халин ширмэн дээр яаж шарчигнан асгарч, гал зуухаар нэг уур манан хэрхэн болохыг амьсгал даран хардаг байлаа. Нэгэн удаа шөл туйлгүй их дэврэн, Бетси гэдэг бүсгүйн гарыг түлчихсэнд арьс нь хоромхон зуур улайн, хумс нь

хүртэл хүрэн болж, тэр бүсгүй түлэгдсэн хуруундаа тос түрхэж, дугуй царайд нь айж сандарсан байдал тодрон, хацраар нь сувдан хэлхээ тасралтгүй бөмбөрөн байлаа.

Грэй таг болов. Бусад нь Бетсийг шаван пижигнэлдэн байх зуур Грэй өөрийн үзээгүй өрөөлийн хэцүү зовлонг сэтгэлээрээ эдэлж,

— Их хорсож байна уу? гэж асуухад нь Бетси хормогчоороо хуруугаа дарж

— Өөрөө үзэхгүй юу, тэгээд мэд гэж хэлбэл жаал хүү хөмсөг атируулж мухар сандал дээр авиран гараад халуун шөлнөөс (ялдамд хэлэхэд энэ нь хар шөл байжээ) урт халбагаар утгаж аван, гарынхаа сарвуу дээр асгажээ. Үзэх гэсэн нь амаргүйг мэдэж, тэгж айхавтар өвдөхийг үзээгүйдээ өөрийн эрхгүй гараа хойш нь татжээ. Цас шиг цагаан болсон Грэй тэсгэлгүй хорсох гараа өмднийхөө халаасанд хийгээд Бетси рүү очиж:

— Чиний гар их өвдөж байх шиг байна аа. Бетси, явъя эмчид очъё гэв.

Ардын аргаар эмчлэх талынхан тэгвэл сайн, ингэвэл сайн гэж ам булаалдан зөвлөж байх зуур Грэй, бүсгүйн хормойноос татсаар байлаа. Хорсох гэдэг тамтаггүй байсан тул бүсгүй Грэйг дагаж очсонд эмч хурууг нь боож өвчнийг намдаажээ. Тэгээд Бетсийг гарсан хойно л жаал хүү гараа үзүүлэв.

Энэ ялихгүй явдлаас хойш хорьтой Бетси, аравтай Грэй хоёр салахгүй нөхөрлөж, бүсгүй нь хүүгийн халаасанд алим, бялуу дүүртэл чихэж, хүү уншсан номоосоо үлгэр түүх бүсгүйд ярьж өгдөг болсон билээ. Нэгэн удаа Бетси агтач Жим хоёр гэр ахуйтай болох мөнгөгүй учир гэрлэн сууж чадахгүй байгааг мэдэхдээ Грэй хүү галын хайчаар мөнгө хураадаг шаазан саваа хага цохиж, түүн дотор байсан зуу гаруй фунтийг аваад, маргааш өглөө нь гал зуух руу инжгүй бүсгүйн явсан эзгүй хойгуур өрөөний нь шороод мөнөөхөн бэлгээ авдарт нь хийж, цаасан дээр «Бетси минь, үүнийг чамд өгч байгаа юм. Сайн эрчүүлийн толгойлогч Робин Гүүд» гэж товчхон бичээд нөгөө мөнгөн дээрээ тавиад орхижээ. Энэ явдлаас болж гал тогоонд бөөн хэрэг мандсан тул Грэй, аргагүй нэр зээлдсэнээ улайсан боловч мөнгөө сөөрөг нь авахгүй гэж тас зөржээ.

Грэйн эх бол амьдралыг хэвээр цутгачихсан юм шиг бэлэн зэлэн байдгаар бодож, ойр зуурхны хүслийн хүрээнд эргэлдэж, үүнийгээ сайн сайхан болж байна гэж сэтгэлээ хуурч явдаг эгэл нэгэн авгай

байлаа. Иймээс үйлчин, эмч, даамал нартай зөвлөж хэлэлцэхээс өөр хийх юм байдаггүй аж. Гэхдээ олсон хүмүүжил, оногдсон хувь тавиландаа баригдсаар сэтгэл хиртэйд хөөрч дэврэх гэж байхгүй болсон боловч хачин зантай хүүдээ амиа тавьж бараг орой дээрээ залах шахдаг байлаа. Тэр язгуурт эмэгтэй үлгэрлэн хэлбэл хунгийн өндөг дарсан тогос шувууны байдалтай ажээ. Хүүгийнхээ бусдаас нэг л онцгой байдагт их эмзэглэдэг байлаа. Хүүгээ элгэндээ тэврэхэд нь цээжинд нь уйтгар гуниг, элбэрэл хайр халгин ирж, зүрх нь бусад хүнтэй харилцдаг, ердийн бодож санадаг үеийнхээс нь огт өөрийг өгүүлэх билээ. Үлгэрлэвэл, нарны туяанд хачин сонин болж үзэгдэх үүлэн сүүдэр байшингийн нэгэн хэвийн байршилд тусахдаа улиг болсон зүйлийг нь халхалж, гэрлийн битүүлэг солонго ядуухан заслыг нь нүд гялбам хоршил болгон харагдуулж, уг өрөөг танигдахын аргагүй болгодогтой адил билээ.

Төрх байдлыг харахад гал халуун хүсэл эрмэлзлийн хар ус хийн унтраахдаа тоохгүй юм уу гэмээр, үнэхээр гоо үзэсгэлэн төгс боловч бүсгүй хүнд байх дур булаам наалинхай ялдам аашгүй, ихэмсэг хөшүүн байдалтай тул сэтгэлийг татахаасаа дурыг гутаах байдалтай Лилиан Грэй хэмээх сурвалжит энэ авгай хүүтэйгээ хоёулхнаа үлдэхдээ энгийн нэгэн эх болж, бичгээр илэрхийлэх аргагүй элбэрэл хайрын үгсийг энхрий дотно дуугаар өгүүлнэ. Үгийн хүчнээс сэтгэлийн хүч их буюу. Тэр бээр хүүгийнхээ хүссэнээс огтхон ч зөрж чадахгүй, гал зууханд ордгийг нь ч, хичээл номдоо дургүйг нь ч, үг хэл дуулдаггүйг нь ч, этгээд хачин аашилдгийг нь ч цөмийг нь өнгөрүүлнэ.

Грэй, мод огтлуулахгүй л гэвэл огтлуулдаггүй, хүн өршөөх, шагнах гэвэл түүгээр нь л болдог, морь унана гэхдээ унаж байдаг, ордонд нохой авчирна гэвэл авчирч л байдаг, номын санд ном онгично гэвэл онгичиж л байдаг, хөл нүцгэн гүйнэ гэвэл гүйж, идье гэснээ идэж, ер нь хийх л гэснээ хийдэг байлаа.

Эцэг нь ингэж дураар аашилдгийг болиулах гэж хэсэг үзсэн боловч сүүл сүүлдээ бууж өгсөн нь гэргийнхээ хүслийг дагуулсных болохоос ёс журмыг дагасных бус байлаа. Тэгээд хүүгээ харц доордсын хүүхэдтэй нийлсээр зан араншин нь эвдрээд засаршгүй хэцүү болчих вий гэж ордноос зарц нарынхаа бүх хүүхдийг зайлуулаад л зогсжээ. Ер нь цаасны үйлдвэр үүсэх үеэс эхлээд зарга зальхай хийгчдийн үхэж мөхсөнийг хүртэл удам судрынхаа тоо томшгүй явдлыг сөхөж үзэхэд бие сэтгэлээ зориулжээ. Түүнээс гадна төрийн

хэрэг, эдлэн эзэмшлийнхээ ажлыг эрхлэх, дуртгал дурсамж туурвих, ан авд мордох, сонин сэтгүүл унших, бичиг захидал бичих гээд өдий төдий ажилтай учир гэрийнхнээсээ нэлээд хөндий, хүүтэйгээ уулзах нь ховор, заримдаа хэдэн настайг нь ч мартаж орхидог байлаа.

Тийнхүү Грэй, өөрөө өөрийгөө зугаацуулнам билээ. Урьд бэхлэлт болж байсан арын хашаанд ихэвчлэн ганцаараа тоглоно. Энэ бол өндөр далангийн үлдэгдэл бөгөөд хөвдөд дарагдсан чулуун зоорьтой, шарилж, халгай, лошго, үүргэнэ болон хээрийн өнгө муутайхан алаг цэцэг дүүрэн ургасан том цулгуй газар байв. Грэй, сохор номины нүх ухаж, шарилжтай байлдаж, эрвээхэй авлаж, хагархай туйпуугаар бэхлэлт барьж, түүнээ мод чулуугаар шидэн эвдэлж хэдэн цагаар нааддаг байлаа.

Санаанд нь хааяа нэг бүүр түүрхэн ордог бүхэн, холбоогүй салангид бодол бүхэн, учир нь мэдэгдэхгүй дэврэн янз бүр болох сэтгэлийн догдлол бүхэн нь жаал хүүг арван хоёртой болох үеэс нийлэн цэгцрээд юунд ч дарагдахгүй тэмүүлэн оргилох нэгэн хүсэл болон лавширчээ. Үүнээс өмнө Грэй, цэцэрлэгийнхээ модны завсраар тусах гэрэл, сүүдэр, цэцэг гоёмсог том модыг тус тусад нь олж үздэг байсан бол гэнэт тэр бүхнийг гайхалтай сайхан цогцолсон байдлаар бүхэлд нь тов тодхон олж харжээ.

Номын сандсан билээ. Номын сангийн бүүдгэр шилтэй өндөр хаалга ихэвчлэн цоожтой байх авч цоож нь дөнгөж торж байсан тул ялихгүй түлхэхэд хаалга ангайн бас дахин тээглэхийснээ онгойчихдог байлаа. Онгорхой бүрээр шагайж юм мэдэх шинжих зантай болохоор Грэй, номын санд ороход өнгийн хээтэй шилэн цонхны дээд хэсгээр нар соньхон тусч, барамнас жирвэлзэн онцгой хачин харагджээ. Энд ажин түжин оргин, ойр хавь хүн ороогүйн шинж тодорхой. Номын том том хар шүүгээ эгнүүлэн тавьсан нь зарим газраар цонх халхлах шахаж, шүүгээний хөндийд ном бичиг овоолжээ. Тэнд ч зургийн цомог хуудас нь салчихсан дэлгээтэй хэвтэж, энд ч саат бүчээр боосон хуйлаастай бичиг хөглөрч, үзэмжгүй бараан ном, тэвхийсэн тэвхийсэн гар бичмэл давхарлан өрсөн үзэгдэж, сөхөж үзвэл хатсан навч шиг шарчигнах жижиг жижиг боть бутран хэвтэж, тэнд ч төсөл зураг, хүснэгт маягт, зэрэглэн өрсөн шинэ хэвлэл, бааз, хэврэг, хар, алаг, хөх, бор, зузаан нимгэн, барзгар гилгэр янз янзын гадартай ном алаглана. Хорго шүүгээнд ном пиг чихсэн нь үлгэрлэвээс амьдралыг тас хавчсан лужир том хэрэм мэт. Шүүгээний шилэн нүүрт бусад шүүгээ тусаж,

гялтганан харагдана. Улаан зам, уртраг хоёрыг зэсээр хөндий зөрүүлэн бүслүүрдэж хийсэн асар том бөмбөрцөг дугуй ширээн дээр байна.

Грэй, хаалга руу эргэтэл хаалган дээр асар том зураг өлгөөстэй үзэгдэж, түүнийг харахад номын сангийн доторх давчдам байдал дорхноо уужран тавигдах мэт боллоо. Уул зурагт нэгэн том хөлгийг далайн давлагааны хяр дээр дүүлэн гарч ирж байгаагаар дүрсэлсэн байлаа. Цагаан хөөс хоёр бөөрөөр нь цахран цацагдана. Үзэгчийг чанх чиглэн айсуу энэ хөлөг давлагааны хүчинд дээш цойлон тогтжээ. Налуу шураг нь дээш өлийхөөрөө өлийж, их шургынхаа угийг халхалжээ. Хурц өвчүүнд нь зүсэгдсэн давлагаа аварга том шувууны далавч аятай дүрслэгдэнэ. Хөөс агаарт цацагдаж, зүүн бөөрний цаанаас, налуу шургын дээгүүр сүүмийн харагдах дарвуул догшин улаан шуурганы хүчтэйг илтгэж бүх биеэрээ арагш гэдийснийг үзэхэд энэ дарвуул давлагаан өнгөрмөгц тэгширч ирснээ ёроолгүй хий рүү унан бөхийснөө уул шиг шинэ давлагааг дахин туулан гарахад бэлхэн байх мэт сэтгэлд бууна. Урагдаж нэвсийсэн үүлс далай шүргэх шахам уралдан нүүнэ. Сүүмгэр гэрэл нөмрөн ирэх шөнийн харанхуйтай үзэлцэж ядаад аргагүй дийлдэж байна. Гэвч энэ зургаас онгоцны хошуун дээр цааш хараад зогсож байгаа хүний дүрс хамгийн гайхамшигтай нь байлаа. Түүнээс энэ үеийн байдлыг бүрэн харж болох байв. Түүний байдлаас (хөлөө алцайн гараа өргөжээ) чухам юу хийж байгаа нь мэдэгдэхгүй боловч үзэгчдэд харагдахгүй байгаа тавцан дээрх нэгэн зүйлийг ихэд анхаарчээ гэж таамаглаж болно. Шуусан хормой нь салхинд дэрвэж, цагаан гэзэг, хар илд нь агаарт хийснэ. Хувцасны нь хээнцэр гоёлоор бодоход хөлгийн ахмад байртай, хөл дээрээ тогтож ядан байгаагаас нь харахад давлагаан тун хүчтэй байгаа нь мэдэгдэж, нэгэн осолтой зүйл рүү улайраад малгайгаа унагачихсанаа ч мэдэхгүй, нэг юм хашхирч байгаа байдалтай. Онгоцноос хүн унаж байгааг ч харсан юм уу, чигээ олохыг ч тушааж байгаа юм уу, эсвэл салхины улихыг даран боцманаа дуудаж байгаа ч юм уу? Зургийг харсаар байтал нь Грэйд ийм бодол гэнэт төрөв:

Үл үзэгдэгч үл таних хүн зүүн хажууд нь сэм ирээд сэвхийтэл зогсчих шиг болов. Хажуу тийшээ л харах юм бол энэ сонин сэрэл нь ул мөргүй алга болчих байлаа. Үүнийг ч Грэй мэдэж байв. Грэй, дүрслэн бодсоор чагнав. Номын санд Малай хэл шиг үл ойлгогдох хэдэн салгуу өгүүлбэр дуулдаж ядам хашхирах мэт уулын нураг удаан гэгч нь буух мэт чимээ сонсогдох, цуурай хангинан салхи хурайлах

мэт боллоо. Грэй энэ бүхнийг дотроо сонсжээ. Эргэн үзвэл агшин зуур дахин нам гүм болж хий бодол сарниад далайн шуургатай холбож байсан шижим тасрав.

Грэй, энэ зургийг үзэх гэж хэд хэд ирсэн билээ. Энэ зураг амьдралын учрыг сэтгэлээрээ ухаарах, өөрийгөө ойлгох түлхүүр болов. Яваандаа жаахан хүүгийн цээжинд сүн далай багтах боллоо. Номын санд ном онгичиж, далай тэнгисийн тухай номыг шимтэн уншиж, эрдэм номын алтан үүдийг татан их далайн гялтганан гялбалзах хөх номин мандлыг үзэж, гагцхүү үүнээс л амьд явахын идээшлийг олох болжээ. Хүслийн тэр мандлаар хөлөг онгоц ардаа цагаан зураас татуулан сүлжиж, зарим нь дарвуул, шургаа алдаад, хүчит давалгаанд хамагдан, загасны нүд гэрэлтэх харанхуй ёроол руу живэн одож, зарим нь эргүүлэгт орон усан доорх хад мөргөн хэмхэрч, татлага хэрэгсэл нь урагдан эзэнгүй болсон зарим нь шинэ шуурганд зомгол болтлоо цохиулсан ч живэхгүй гэж зүтгэх мэт их л тэсэж, нөгөө хэсэг нь нэг боомтоос ачаагаа эсэн мэнд ачин нөгөөд буулгаж, баг нь зоогийн газрын ширээнээ суун сархад таатайхан шимж, алтан шар замаа магтан дуулна. Хар далбаатай, хутга мэс гялалзуулсан аймар багтай дээрэмчний онгоц ч, мөсөн хөх өнгөөр гялтганах гандирсны хөлөг ч цэрэг цуух, их буу болж, хөгжим хуур хангинуулсан байлдааны хөлөг ч, галт уул, өвс ургамал, ан амьтан шинжилдэг эрдэм шинжилгээний онгоц ч, учир битүүлэг, цэрэг эрс нь самуурч боссон онгоц ч, элдэв нээлт хийдэг онгоц, адал явдал эрсэн онгоц ч санаанд нь бууж байлаа.

Энэ ертөнцөд хөлгийн ахмад гэдэг хамаг бүхнээс товойн харагдана. Ахмад хүн хөлгийн хувь заяаг атгаж, оюун билгээрээ жолоодож, амин сүнс нь болно. Багийнхан нь яаж амрах, юу хийх нь түүний зан байдлаас шалтгаална. Ахмад өөрийн дур сэтгэлд тохируулан багаа биеэр шилэн авч, хүн бүрийн ааш араншин, ар гэрийн байдлыг андахгүй мэднэ. Өөрийн захиргаанд байдаг улсдаа ид шидийн мэдлэгтэйгээ харуулж, ухаан нь Лиссабоноос Шанхай хүрэхдээ нүд алдам их усыг бат итгэлтэй гатлан туулж, салхи шуурга хөдлөхөд эвийн хүчийг нийлүүлэн сөрж, товч товчхон тушаал өгөөд айж сандарсан улсыг тайвшруулж, дураа хүрвэл аялж, дургүйгээ хүрвэл буудаллаж, ачаа ачих, амарч саатах, зогсоолоос мордох, засвар хийхийг ганцаар эрхлэн мэднэ. Зүгээр огт үл суулгах биетэй бодитой ажилд туйлын ухаалаг бөгөөд ихээхэн эрх мэдэлтэй хандана гэдэг

хэцүү. Орфей хүнийг яаж уяруулан татдаг вэ? Ахмад багаа нэг л мэдэхэд тэгж татна.

Сэтгэлд оршсон юм гэдэг аргагүй хүчтэй байдгийн учир хөлгийн ахмадын тухай тийм төсөөлөл, тийм дүр, жинхэнэ байдал Грэйнд ухаан бодлоос гарахгүй болжээ. Хувь тавилан нэг бүрийн тус тусдаа мэтгэсэн уран нарийн угалзыг огтхон ч хөндөлгүйгээр амьдралын хамаг эрхэм нандин бүхнийг тэгж гарамгай хослуулан цогцлуульж чадах мэргэжил түүнээс өөр байхгүй гэж бодогдоно. Хөлгийнхөө өрөөг өр зүрхнээс уяатай өсөж төрсөн гэрийнхээ байдлаар засаж, ном зохиол зураг хөрөг, захиа занааг нь нандигнан хадгалж, мяндсан зөөлөн даахинд ороолттой хатаасан цэцэг илгэн гэрт хийн сахиус болгож ханхар цээжиндээ зүүж яваа боловч аюул осолтой тулгарч, байгалийн сүр хүчийг туулж, мянганы газраар аялж, яах нь мэдэгдэхгүй сэтгэл дэнсэлгэсэн байдалд орж, энгэр зөрөөд өнгөрдөг зуурдын дурлалтай золгон, түмэн хүнтэй нүүр учирч, буман явдлыг үзэн нүд тайлж, амьдралын эрээн барааныг таних зэрэг хожмын мянган эхтэй явдал сэтгэлд нь эргэлдэж, нэг үе Өмнөдийн загалмай, нөгөө үе Долоон бурхан огторгуйн гүнээ гялалзан нүдэнд нь үзэгдэж, тив газар алган дээр нь байгаа юм шиг дурайн харагдана.

Артур Грэй, арван тав хүрснийхээ намар гэрээсээ оргон босож их далайн алтан үүдийг татан орсон юм. Асар удалгүй Дубел боомтоос Марсель орохоор явсан «Ансельм» усан хөлөгт эрэгтэй хүүхдийн хувцас өмссөн бүсгүй хүүхдийн байдалтай, бяцхан гартай нэгэн сурагч сууж явав. Хальс шиг нимгэн хээнцэр богц барьж, чийдмэл савхин гутал өшиглөж, титэм хээ шагласан пүүсүү цамц өмссөн тэр хөвүүн бол Грэй байлаа.

«Ансельм» хөлөг Франц, Америк, Испаниар аялсан нэгэн жилд Грэй авч явсан юмныхаа хагасыг бялуунаас өгч өнгөрснөө хүндэтгээд, үлдсэнийгээ хөзрийн мөрийд алдан өнөө ба ирээдүйгээ мялаасан юм санж. Хөвүүн, адтай далайчин болохыг мэрийн хахаж цацан архи ууж, хоёр сажин өндөр дээрээс ус руу толгойгоороо зүрх алдан үсэрч үзжээ. Гагц урагш дүүлэн тэмүүлэх сэтгэлээсээ бусдыг аажим аажмаар гээж, бие төлжин, яс бэхжиж, булчин чангарч, цонхигор царай нь борогшин борложээ. Урьд хөдөлж барихдаа хэнэггүй атлаа ёсорхог байсан бол одоо хийе гэснээ цохоод цохоод хийчихдэг, харж ширтэхдээ бодлогошронгуй байсан бол одоо цог золбоотой, хэлж ярихдаа дэгэн догон, ихэрхэг сунжруу байсан бол одоо товч товчхон оноод оноод

хэлчихдэг болсон нь гялтрах мөнгөн загасыг цахлай ганцхан шаачих аятай болж иржээ.

«Ансельмын» ахмад Гоп бол хүний хувьд хайр нь дотроо далайчны хувьд хал нь гаднаа эр байсан юм санжээ. Жаал хүүг авахдаа нэлээд басан түүнийг чамирхах гэсэндээ л тэгж зүтгэж байна хэмээн санаж, гурван сарын дараа л «Гоп ахмад аа, олс татлагаар авирч мацсаар тохой гэж авах танаггүй зулгарч, хавирга сүвээгээр хатгаж, ууц нуруугаар өвдөж, гар хуруу бадайрч, тархи толгой салчих шахаж, хоёр хөл салгалаад болохоо байлаа. Хоёр пүү нойтон татлагад гар минь буларч, леер, вант, брашпиль, татлага, стеньга, салинг гэдэг чинь над шиг танхил хүнд таарахгүй эд юм. Би чинь ээждээ очьё» гэж нүүр буруулан хэлнэ дээ гэж дотроо бодоод, «Ирсэн замаараа сурсан дуугаа дуулаад буц даа, шувуухай минь. Булбарайхан далинд чинь давирхай сэлт наалдсан бол гэртээ хариад «Хамба сарнай» сүрчгээр угаачхаарай» гэж хариулна гэж санадаг байжээ. Ахмад Гоп ийм сүрчиг бодож олсондоо бүр ч баярлаж, тийнхүү дотроо «За тэр «Хамба сарнай руугаа» явдаа» гэж чанга хэлдэг байжээ.

Гэвч хүү зорьсондоо хүрэх гэж шүд зуун, царай барайлган зүтгэх тул тэгж сүртэй ярилцана гэж ахмадын бодох нь улам цөөрөв. Грэй, амар заяа үл үзэвч бүсээ чангалан тэвчиж, хатуу хүтүүд бие дасаад сурч дадахын хэрээр ажил нь улам амар хялбар болж байгааг мэдэрч байлаа. Бархагийн оосрын гогцоонд цохиулан тавцан дээр унахдаа унаж, дэгээнээс мултарч гараас нь алдагдсан татлагад алганыхаа арьсыг хуу татуулахдаа татуулж, төмөр гархи бэхэлсэн далбааны нойтон сэжүүрийн салхинд хийсэхэд нь нүүрээ ороолгуулахдаа ороолгуулж, товчоор хэлэхэд хийж байгаа бүхэндээ авхаалж самбаагаа сориулж байлаа. Нуруугаа тэнийлгэж чадахгүй болтлоо сульдаж, бахардан амьсгаадаж байлаа ч гэсэн тоомжиргүйхэн инээмсэглэж явдаг байлаа. Хөвүүн, шинэ нөхдийнхөө басамжлах, доромжлох, харааж загнахыг дуугүй тэвчин өнгөрүүлдэг байсан боловч тэдэнтэй дасаад ирэхдээ өөрийгөө доромжилсон хэнтэй боловч хотойхгүй гар зөрүүлдэг боллоо.

Нэг удаа ахмад Гоп Грэйг шургын хөндлөвчид дарвуул хэчнээн чадамгай уяж байгааг нь хараад «Чи дийллээ, залийн хөрөнгө» гэж дотроо хэлжээ. Грэйг, тавцан дээр бууж ирэхэд Гоп өрөөндөө дуудан оруулаад үнгэгдэж ноорсон ном нээн үзүүлж,

— Аан гэж бай. Тамхиа хая. Гөлгийг одоо ахмад болгон сургана гэж хэлэв.

Тэгээд уг номоос далайн эртний үгийг уншиж, унших, гэж дээ дуудан хашхирч гарчээ. Энэ бол Грэйи заалгасан анхны хичээл байлаа. Жилийн дотор усан замын ухаан, практик, хөлөг онгоцны үйлдвэрлэл, далайн эрх, жолоодлогын ухаан, нягтлан бодохын аргатай танилцав. Ахмад Гоп гарыг нь атгаж «Бид хоёр» гэж ярьдаг боллоо.

Хүүгээ санахын ихээр санаж, хойноос нь зовохын ихээр зовж суудгаа бичсэн эхийнх нь захидал Грэйг Ванкуверт байхад нь очжээ. Грэйи хариулсан нь: «Би мэдэж байна аа. Гэхдээ та минь над шиг хардаг бол миний нүдээр хараач дээ. Та минь над шиг сонсдог бол угаагуурын шаазанг чих тавин чагнаад үзээрэй дээ, тэгэхэд тань далайн мөнхийн цалгиан сонстох вий. Та минь надтай л адилхан бүгдийг хайрладаг бол захидлаас тань элбэрэл хайр, хүнлэг сэтгэлээс гадна баяр хөөрийг олж үзэх сэн дээ» гэжээ. Грэй, аялан аялсаар «Ансельмыг» Дубельтад ачаа буулгахаар нэг ирж, түр зогссоныг завшаалж, гэрийнхнээ эргэхээр явжээ. Тэгэхэд Грэй хорь хүрсэн байлаа.

Бүх юм таван жилийн өмнө сэтгэлд яаж үлдсэн бэ яг л тэр хэвээрээ байлаа. Гагцхүү зулзаган хайлаас нь навч өтгөн болоод харшийн хананаа цоохортон тусах сүүдэр нь битүү бөгөөд саглагар болжээ.

Зарц нар нь түүнийг хараад баярлалдан гүйлдэж ирснээ өчигдөрхөн л энэ Грэйг ингэж угтаж байсан шиг бодогдон бишрэнгүй зогтусав. Эхийнх нь байгаа өрөөг хэлж өгсөнд цэлгэр тасалгааны үүдийг аяархан татаж ороод хар даашинзтай буурал авгайг харан дуугүйхэн зогслоо. Авгай цовдлуулсан Христосын өмнө зогсоод «Бядан хөвөгч, аялан жуулчлагч өвдөн зовогч, энэлэн шаналагч, сэтгэл алдагсдыг өршөөн соёрх» гэж амандаа хичээнгүйлэн уншихыг нь Грэй амьсгал даран сонсов. Дараа нь «хүүд минь...» гэхэд нь Грэй «хүү нь...» гээд цааш нь үг хэлж чадсангүй. Ээж нь эргэж харлаа. Мах мариа нь нэлээд шуугдаж, нимгэн царайд нь тодрох ихэмсэг дүр огт өөр байдалтай болсныг харахад эргээд залуу болсон шиг санагдана. Ээж нь хүү рүүгээ шалавхан очсоноо хангинатал инээж, нэгэнтээ дуу алдан, нүдэндээ нулимс цийлгэнүүлжээ. Гэвч энэ агшинд Тэр бээр энэ насандаа магнай тэнийгээгүйгээ тэнийсэн гэж болно. «Хүү минь, өөдөс минь, би чамайг дороо л таньсан!» Грэй ч эргээд бага болчих

шиг боллоо. Эцгийнхээ насан элэгдсэнийг сонсож, өөрийнхөө тухай ярьж өгөв. Ээж нь хүүгийнхээ яриаг сонсохдоо зэмлэсэн ч үгүй, зөрсөн ч үгүй боловч түүний амьдралын үнэн гэж батлах бүхнийг сонсохдоо хүү минь ийм л юмаар наадаж явдаг байна даа гэж дотроо санажээ Гэтэл тэр наадам нь тив дэлхий, тэнгис далай, хөлөг онгоц байлаа.

Грэй гэртээ долоо хоноод найм дахь өдөр нь бөөн мөнгө аван Дубельтэд эргэж ирээд, ахмад Гопод «Баярлалаа. Та сайн нөхөр байлаа. Хуурай ах минь, баяртай» гэж хэлэхдээ энэ үгийнхээ чин үнэнийг батлах гэсэн шиг гарыг нь бахь мэт чанга атгаад «Одоо би толгой дааж, өөрийн онгоцоор хөвнө» гэсэнд Гоп, дүрсхийн уурлаж, нэгэнтээ нулиман, гараа шувт татаж аваад эргэн алхахад нь Грэй хойноос нь гүйцэж очоод түүнийг тэврэн авчээ. Тэгээд багийн хорин дөрвөн хүн цөмөөр зочид буудалд орж, ууж идэж, дуулж бархирч, мухлаг, гал тогоонд байсан бүхнийг цөмийг нь хуурайлж билээ.

Төдий л удалгүй Дубельт боомтод үдшийн гялаан нэгэн шинэ хөлгийн хар шургын дээр цахилав. Энэ бол Грэйн худалдаж авсан гурван шурагтай, хоёр зуун жаран тонны даацтай «Нууц» гэдэг хөлөг байлаа. Артур Грэй тийнхүү хөлгийн эзэн, ахмад болоод, дөрвөн жил аялан явж, хувь зохиол зургаа даган Лисс хотод хүрч ирсэн юм. Гэвч ээжийнхээ чин хайрыг илтгэж түрхэн зуур цангинатал инээснийг сэтгэлдээ ямагт санаж, жилд хоёр удаа гэрээ эргэж, үсэнд нь мөнгөн сор суусан тэр авгайд хүү минь өдий том болсон юм байна, тоглоомоороо тоглож чадаад байна байгаа гэсэн муухан итгэл үлдээгээд эргэн оддог байлаа.

III : ҮҮРЭЭР

Грэйи хөлгийн хойно туузран үлдэх хөөс далай дундуур цагаан зам болон зурайсаар Лисс хотын үдшийн гэрэлд уусан замхрав. Хөлөг, гэрэлт цамхгийн харалдаа зангуу хаяж зогсов. «Нууц» хөлгөөс арван өдөр чисчүү, кофе, цай буулгаж арван нэгдэх өдөр нь багаараа хот орж архидан амарч өнжөөд арван хоёрдох өдөр нь Грэй зүв зүгээр байж байснаа сэтгэл нь гэнэт тавгүй оргиж яагаад ингэснийхээ учрыг өрөө ч олж чадахаа болив.

Бүүр өглөө нойрноос дөнгөж сэрэхэд л энэ өдөр өөрт нь нэг л ёозгүй болохын муу совин татаад байжээ. Тэгээд бүрсгэр царайтайхан хувцсаа өмсөж, дуртай дургүй цайгаа ууж сонин ч уншихаа мартаж орхиод тамхи удтал баагиулж, тархиа гашилтал мянган эхтэй явдлыг эргэцүүлэв. Сэтгэлд нэг бодол бүүр түүрхэн орж ирэхэд өөр нэг санаа төрөн нөгөөхийг замхруулна. Тэгэхэд нь ажил хийж гарчээ.

Грэй, боцманаа дагуулан хөлгөө шалган үзэж, татуургыг чангалж, залуурын татлагыг сулруулж, аргамжааны нүхийг цэвэрлэж, гурвалжин далбааг сольж, тавцангийн шалыг давирхайдаж, луужинг арчин, хөлгийн хэвлийг нээж, салхи оруулан, шүүрдэх тушаал өгөв. Ажил хийгээд ч сэтгэл сэргэсэнгүй. Тэр өдөр цухал ч хүрээд байх шиг, уйтгар төрөөд ч байх шиг, өөрийг нь хэн нэгэн хүн дуудсан боловч хэн хаашаа дуудсаныг мартсан ч юм шиг сэтгэл нэг л түгшин гэгэлзээд тун хачин байлаа.

Орой болохын алдад өрөөндөө орон ном барин сууж, зохиогчийн бичсэнийг эсэргүүцэн зах дээр нь хачин хачин тэмдэглэл хийжээ. Үхэж, үрэгдсэн хүнтэй ярилцан ингэж наадсандаа хэсэг сатааран зугаацав. Тэгээд гансаа аван тамхи нэрж манаран суунаглах хөх утаан дунд бодлого болон жаал суужээ.

Тамхины чадал юутай их. Оволзон хөөсөрч байгаа давлагаан дээр тос хийчихэд намддаг лугаа адил тамхи татахад цухалдсан сэтгэл онгойж, улмаар уужран тайвшрах билээ. Гурван ганс тамхи нэрэхэд нь Грэйи уйтгар аажмаар намдан бодлогоширсон, алмайрсан байдалтай болов. Цаг хэртэй ийм байлаа. Сэтгэлийн манан арилахад Грэй сэргэн, явж хөдөлмөөр санагдан тавцан дээр гарлаа. Шөнө орой болж, харлах уснаа одод, шургын дэнлүүний гэрэл тусжээ. Бүлээ оргих агаараас далайн үнэр ханхална. Грэй өлийж, цог мэт гялтганах одыг онийн

ширтэхэд холхи гарагийн оч агшин зуур түмэн бээрийг туулан нүдэнд нь харвав. Далайн тохойн гүнээс үдшийн бөглүү чимээ чих дэлсэнэ. Эрэг дээр хүмүүсийн ярилцах дуу нь заримдаа хөлгийн тавцан дээр ярилцах мэт салхин дээрээс тодхон дуулдсанаа шургын чахрах чимээнд дарагдан замхарна. Онгоцны хошуун дээр чүдэнзний гэрэл гялсхийж, дугуй нүд, ширвээ сахал, палбигар хуруу харагдав. Грэйг шүгэлдэхэд гаансны цог хийд хөдлөн дөхөж, удалгүй жижүүрийн царай, харанхуйд тодрон харагдлаа.

Надтай яв гэж байна гэж Летикад хэлээдэх. Загасны уурга аваарай гэж байна гээрэй гэж Грэй хэлэв.

Тэгээд завинд орж, Летикаг арваад минут хүлээлээ. Зальжин байрын шаламгай залуу сэлүүрээ хөлгийн бөөрөнд түр няр мөргүүлсээр Грэйд өгөөд өөрөө бууж ирэн, сэлүүрээ тогтоогоод, хүүдийтэй идэх юмаа завины хитэг рүү шургуулав. Грэй залуур дээр суулаа.

Летика баруун сэлүүрээрээ сэлүүрдэн завиа эргүүлэх зуур — Ахмад аа, хаашаа явах вэ? Тушаал биелүүлэхэд бэлэн гэв.

Ахмад дуугарсангүйд далайчин түүний ийнхүү дуугүй байхад үг хэлж болдоггүйг мэдэх болохоор өөрөө бас дуугаа хураагаад хүчлэн сэлүүрдэж гарлаа.

Грэй, далай руу чиглэснээ зүүн эрэг барин хөвөв. Хаашаа ч явсан түүнд үнэндээ ялгаагүй байлаа. Далайн ус мэлтийж, залуур үл мэдэг чийхрах, сэлгүүр ус шал пал хийлгэхээс өөр чимээ аниргүй.

Өдрийн турш хүний бодсон сэтгэсэн, хэлсэн ярьсан бүхнийг нэгтгэдэг бол нэгээр тогтохгүй зузаан ном болох сон билээ. Өдөр өдөр хүний сэтгэл өөр өөр байх бөгөөд Грэй өнөөдрийг ямар байна вэ гэж сайтар нягталж үзжээ. Бүүр түүрхэн төсөөлөгдөх шинж байдлаас нь үзвэл миний сэтгэл ийм байна гэж цохоод нэрлэчхэж болохгүй үе олон гардаг яг л нэг тийм үе байлаа. Анхилам үнэрийг тийм гээд хэлчих арга байдаггүйтэй адил тийм сэтгэлийг юу ч гэж нэрлэлээ гэсэн оноод хэлчих үг, тэр ч байтугай ухагдахуун байхгүй билээ. Грэйн сэтгэл одоо яг л тийм байв. «Нэг л юм болох нь гэж сэтгэл хүлээж, нүдэнд үзэгдээд байна, удахгүй олж мэднэ» гэж хэлж болохоор байсан боловч уран барилгын төслийг тус тусад нь гаргачихсан шиг авцалдаж өгөхгүй байжээ. Ингэж нэгийг хүлээсэн сэтгэлд урам бадраах хүч бас байлаа.

Тэдний хөвж яваа газрын зүүн талд эрэг бараантан сүглийж үзэгдэв. Гэрэл ярайсан цонхны дээгүүр яндангаас очнууд хийсэнэ. Энэ

бол Каперна байлаа. Хүн хэрэлдэх, нохой хуцах нь сонсогдоно. Тосгоны гэрлийг харахад цоо цоо үсэрсэн зуухны амаар нурам улалзан байх мэт. Баруун талд далай мэлтийн байх нь хажууд хүн унтаж байх шиг болно. Грэй, Каперныг өнгөрөөд завиа эрэг рүү эргүүлэв. Энд ус аяархан цалгиж, дэнлүү асааж үзвэл өндөр хүнхэр ирмэг харагдсанд энэ газар санаанд нь таарчээ.

Грэй, сэлүүрчний мөрийг алгадаж

— Энд загасчилна даа гэжээ.

Усан цэрэг юу гэж байгаа нь мэдэгдэхгүй гүнгэнэв. Дотроо бол ийм ахмадтай анх удаагаа аялж байна. Буурьтай мөртөө бусадтай адилгүй хүн. Гэхдээ энэ ахмад хүний хайр авч чаддаг хүн гэж үглэж явжээ.

Сэлүүрээ шаварт шааж, завиа аргамжиж орхиод өвдөг, тохойгоороо чулуу дайрч өнхрүүлсээр дээш мацав. Эргээс цааш төгөл мод байна. Летика хуурай мод тасхийтэл цавчиж унагаад эрэг дээр түүдэг асаав. Олон сүүдэр хөдөлж усанд туссан галын гэрэл чичгэнэж гэрэлд ногоо мөчир тодрон үзэгдэж, түүдгийн дээр мушгирах утаанд агаар жирвэгэнэн харагдана.

Грэй, галын дэргэд суугаад

— Аль вэ гэж лонхтой дарсыг сарвайн Летика нөхөр минь, архи амсдаггүй бүх хүний төлөө тогтоочих. Ингэхэд чи яагаад хинийн дарс авалгүй, имбирийн дарс авсан байдаг билээ? гэсэнд

— Уучлаарай, ахмад аа гэж амьсгаа аваад

— Үүгээр даруулчих уу?... гэснээ дэгдээхийн өрөөл махыг нэг завжаараа идэж, далавчийг нь нөгөө завжаараа хаяад

— Таны хинийн дарсанд дуртайг би мэднэ л дээ. Харанхуйд яараад анзаарсангүй. Имбирь¹ байна шүү. Хүнийг зориг оруулдаг юм. Би зодолдох болбол имбирийн дарс уучихдаг юм гэв.

Ахмадыгаа хоол идэж байгааг нь нүднийхээ булангаар харж байснаа тэсэлгүй

— Ахмад аа, таны эцэг эхийг язгууртан улс, гэдэг үнэн үү? гэвэл:

— Ийм дэмий юмаар яах вэ? Летика. Загас баримаар байвал дэгээгээ аваад яв л даа гэсэнд

— Та яах юм? гэжээ.

— Би юу? Яахаа мэдэхгүй л байна. Магадгүй, за... сүүлд больё гэв.

Летика дэгээгээ задалж, багынхаа хүмүүсийн амыг ангайтал шүлэглэдэг тул толгой холбож

— Утас саваа хоёроор урт гэгчийн уурга хийлээ, дэгээ түүндээ уяад даамай урт исгэрлээ гэснээ лаазтай өтөө хуруугаараа этэж үзээд

— Энэ өт газарт байхдаа өрөөлөөс дутахгүй явдаг байж. Одоо дэгээнд хийчихлээр урт цулбууртын зоог болжээ гээд

— Шөнө нь намуухан, сархад нь сайхан, Летика хүү, дэгээгээ хаялаа, муусайн хилэм чичрээрэй, май загас ухаан алдаарай гэж дуулсаар одов.

Грэй, галын гэрэлд мяралзах усыг гөлрөн түүдгийн дэргэд хэвтэж, элдвийг таваараа бодоход ойр тойрны юм сэтгэлд нь бүүр түүрхэн орж дотор нь бүдэг бадагхан харагдана. Бодол гэдэг бөөн улсын дундуур зүсэн, түлхэн довтолгох хүлгийн адил хадууран давхина. Хүний сэтгэл гэгч харахад дүрсгүй, хүрэхэд биегүй, сонсоход чимээгүй бөгөөд тэмүүлэн догдолж байснаа гэнэт дүнсийн газар тэнгэрээр халин эргэлдэж, дүрслэн бодсон хүнтэйгээ ярилцана, дуртгалыг нэг сэргээж, нэг бөхөөнө. Хүрье гэхэд биегүй энэ бодол бариад авмаар тод боловч дэмийрэл шиг огт холбоогүй. Жишээлэхэд: хувь заяаны тухай эргэцүүлж байтал огтын хамаагүй юм, тухайлбал хоёр жилийн өмнө хуга татсан төмөр саваа сэтгэлд орж ирэх нь үнэхээр инээдтэй. Тийнхүү бие махбод нь түүдгийн дэргэд авч бодол санаа нь тэртээд бэлчин одсон байлаа.

Шанаагаа тулж, газар тохойлдон хэвтсэн тул тохой нь норж, бас бадайрчээ. Одод бүдэгхэн гялайж, үүрийн өмнөх үнэгэн харанхуй болов. Ахмад, зөөлөн бөхөд өөрийн мэдэлгүй дийлдэж эхэлсэн байлаа. Түүний ам нь ангахад зүүдэн дундаа гар нь богц руугаа яван, амыг нь тайлжээ. Тэгээд зүүдлэхээ больжээ. Дараагийн хоёр цаг нь Грэйд гараа дэрлэх төдий болсон хэдэн хором шиг л санагджээ. Энэ завсар Летика галын дэргэд хоёр ч ирж, тамхи татан, барьсан загасныхаа амыг хэрэгт дурлан өнгийж харвал тэнд нь, мэдээж, юу байх билээ.

Грэй, сэрэхдээ энэ газар яаж ирснээ мартсан байлаа. Өглөөний туяа шаргалтан тусч, тодхон дурайх мөчрийн завсраар өндөр эрэг сүүхийж, далайн ус цэнхэрлэн туналзаж бүхийг гайхан ширтэв. Хөлийн нь дээр унжих шид модны навчис тэнгэрийн хаяанд байгаа юм шиг үзэгдэнэ. Эргийн дор ус аяархан цалгих нь архан дор нь байх мэт сэтгэл төрнө. Навчин дээрээс намирга гялсхийн унаж нойрмог нүүрэн дээгүүр нь бөмбөрөв. Грэй бослоо. Түмэн бодис гэрэлд тэр аяараа

булхжээ. Түүдгийн цогшсон цуцал унтрахгүй юм шүү гэсэн шиг нарийн утаа баагиулна. Шатсан модны үнэр навч ногооны анхилуун үнэртэй нийлээд ойн агаарыг амьсгалахуйяа тааламжтай сайхан болгоно.

Летика байсангүй. Мөрийтэй тоглоомчин шиг бүр улайрч орхиод, хөлсөө гоожуулчихсан, дэгээгээ чулуудаж байлаа. Грэй төглөөс гарч толгойн бэлийн оочин цоочин бут сөөг дундуур явлаа. Өвс ногооноос уур баагьж, нойтон цэцгийг харахад хүүхэд нүүрээ хүйтэн усаар мөлчийтөл угаачихсан юм шиг бодогдоно. Энэ ногоон ертөнц амьсгалж болох сүв бүхнээрээ амьсгалж, барьцалдан ороолдоод Грэйн явахад саад болно. Ахмад, алаг цэцэг бүрхсэн дэнж дээр гарч иртэл нэгэн бүсгүй унтаж байгаа нь нүдэнд туслаа.

Грэй, гараараа мөчрийг аяархан зайлуулснаа осолтой юм олсон мэт зог тусав. Тавхан алхмын тэртээ алжааж ядарсан Ассоль нэг хөлөө атийн, нөгөөгөө жийж, алгаа эвтэйхэн дэрлээд тугдайн унтаж байлаа. Үс нь бутран бууж хоолойны нь товч тайлагдаад булбарай дагаан хүзүү нь цухуйж, банзал нь огшин өвдөг нь ил гарчээ. Буржгар хар үсэн дороос хагас цухуйх товгор булбарай магнайн нь сүүдэр хацар дээр нь тусч сормуус нь буужээ. Толгойгоо тэвэрсэн баруун гарын нь чигчий хуруу дагз руугаа нугарсан байв. Грэй, явган сууж, бүсгүйн царайг дороос нь ширтэхдээ Арнольд Беклины зургийн Фавна шиг болж байна гэдгээ зүүдэлсэн ч үгүй.

Өөр үед тааралдсан бол энэ бүсгүй нүдэнд нь төдий л өртөхгүй сэн биз. Гэвч одоо өөр нүдээр харжээ. Грэйн бие сэтгэл тэр аяараа хөөрөн догдлов. Грэй түүнийг танихгүй, нэрийг нь ч дуулаагүй, тэр байтугай яагаад эрэг дээр унтсаныг нь ч мэдэхгүй ээ. Үүндээ ч тун баяртай байлаа. Грэй тайлбаргүй, нэргүй зурагт дуртай. Ийм зураг үзэхэд төрөх сэтгэгдэл зүйрлэшгүй хүчтэй байдаг бөгөөд үгээр илэрхийлээгүй болохоор агуулгыг нь дураараа зөгнөн тааварлаж, ургуулан бодож болдог билээ.

Навчны сүүдэр модны голд ойртож ирсэн боловч Грэй эвгүй байдалтай суусан чигээрээ байлаа. Бүсгүйн бүх юм унтана. Хар үс нь, өмссөн дашинз нь, дашинзны нугалаа нь хүртэл унтаж, түүний биеийн ойролцоох ногоо хүртэл сэтгэл дагаад зүүрмэглэх мэт санагдана. Грэй шаваагаа ханатал харж аваад сэтгэлд дулаа оргиулах мөрөөдлийн давалгаанд умбав. Летика аль түрүүнээс хойш «Ахмад аа, та хаа байна?» гэж хашхиравч ахмад нь түүнийг дуулсангүй. Грэй тэгж

тэгж өндийхдөө бухимдсан эмэгтэй яахаас ч буцахгүй зоригтой болдог шиг ер бусын юм хийе гэж сэтгэл нэгэнт шулуудсан байлаа. Энэ бодолдоо автаж, эртний үнэт бөлзгөө хуруунаасаа мулталж, алдахын аргагүй зөв юм амьдралдаа хийж байна гэж бас ч гэж үндэстэй боджээ. Грэй, бүсгүйн дагзны дороос цайрах бяцхан чигчий хуруунд бөлзгийг сэмхэн хийв. Чигчий хуруу аажимхан нугарав.

Бүсгүйн амарч байгаа царайг Грэй бас дахин хараад эргэн үзвэл бутан дотроос усан цэрэг нүдээ бүлтийлгэчихсэн бас харж байлаа. Амаа ангайн гайхчихсан харж байгааг нь зүйрлэвэл эвэртэй туулай харсан мэт.

— Өө, Летика, чи юу? Энэ бүсгүйг хараач. Хөөрхөн байгаа биз? гэж Грэйг хэлсэнд бичгийн үгээр ярихдаа дуртай усан цэрэг

Ёстой зургийн хуар байна гэж шивнэн дуу алдаад

— Байдлыг эргэцүүлбэл сэтгэл татмаар юм ч байна шүү. Би дөрвөн мурен, цозгор лонх шиг нэг бүдүүн загас барилаа гэсэнд

— Летика, чимээгүй. Эндээс явъя гээд хоёул бут руу оров. Одоо завь руугаа явбал таарах байсан боловч Грэй нэг л алгуурлаж, хөх ногоо, шар элсэн дээгүүр Каперна тосгоны яндангаас өглөөний утаа бургилан байх намхан эргийг ширтэв. Тэр утаан дотроос унтаа бүсгүйг дахин олж харсан юм.

Тэгэхэд Грэй огцом эргэж уулын бэлийг жишүүдэн дагаж буусанд усан цэрэг яав ийв гэж асуусангүй, араас нь дагаж, нөгөө үг дуугарч болдоггүй үе дахин боллоо гэж бодож явав. Захын барилгын дэргэд ирээд Грэй

— Летика, юм үзсэн хүн байна, гуанз хаана байгааг хэлээдэх гэсэнд

— За тэр хар дээвэртэй байшин л болов уу, биш ч байж болох л юм даа гэхэд

— Юугаар нь чи тэгж мэдэв? гэв:

— Өөрөө ч мэдэхгүй байна, ахмад аа. Зөн л гэх юм уу даа.

Тэр байшинд дөхөж очвол үнэхээр Меннерсийн гуанз байлаа. Нээлттэй цонхоор ширээн дээр лонх тавиастай хажууд нь нэг хүн бохир гараараа бууралтаж яваа сахлаа шувтарч байгаа нь харагдав.

Өглөө эрт байсан боловч нийтийн танхимд гурван хүн сууж байна. Цонхны дэргэд бидний түрүүнд харсан нойтон сахлын эзэн болох нүүрсчин сууж, лангуу, дотор хаалга хоёрын дунд хоёр загасчин шарсан өндөг, шар айраг тавьчихсан байв. Худалдаачдад байдаг

зальжин байрын харц бүхий харалгандуу нүдтэй, сэвхтэй, уйтгартай царайтай өндөр залуу Меннерс лангууны ард сав суулга арчиж зогсов. Халтар шалан дээр цонхны гэрэл тусжээ.

Грэйг гэрэлд орж ирэнгүүт Меннерс их хүндэтгэмгүй бөхөлзөн лангууныхаа араас гарч ирэв. Меннерс, Грэйг харангуутаа л жинхэнэ ахмад, ховорхон үзсэн эрхэм зочин ирлээ гэж мэджээ. Грэй ром захив. Меннерс, бүүр хуучраад шарлачихсан бүтээлгээр ширээ бүтээж, лонхтой архи авчрахдаа ховорсон шошгыг нь шүлсээрээ наав. Тэгээд Грэйг нэг харж, тавагт наалдаад хатчихсан юмыг хумсаараа маажин, тавгаа нэг харсаар лангуу руугаа явав.

Летика аягатайгаа хоёр гардан аваад, цонх руу харан шимж гарав. Грэй, Меннерсийг нааш ир гэж хуруугаараа дохилоо. Меннерс өөрт нь ингэж аминчлан дохиж, найр тавьсанд маасайж, сандлын ирмэг сандайлан додигор гэгч нь суулаа. Грэй тайван дуугаар

— Та эндхийнхнийг цөмийг нь таних биз дээ? Хошуу алчуур, ягаан цэцэгтэй даашинзтай, хар үстэй, намхавтар нуруутай, арван долоогоос хорь хэрийн насны бүсгүйг мэдэх гэсэн юм. Түүнтэй эндээс холгүй дайралдлаа. Хэн гэдэг юм бол? гэв.

Грэй, үүнийгээ энгийн мөртөө баттай хэлсэн учир Меннерс булзаж бултах аргагүй болжээ. Дотроо бол сэрдхийж, тэр ч байтугай хөх инээд нь хүрсэн боловч гаднаа Грэйг хэлсэн байдлыг дагажээ. Гэвч хариу хэлэхээсээ урьтаад яах гэж байгааг нь мэдэх сэн гэж дэмий л хүссэндээ хэсэг таг болсноо

— Хн? гэж тааз ширтэн хэлээд, — «Онгоцны Ассоль» л байж таарна даа, өөр хэн байх вэ. Солиотой юм гэсэнд Грэй дарсаа том том балгах зуураа

— Тийм бий? Яагаад тийм болчихсон юм бол? гэж хэнэггүйхэн асуусанд

— Яах вэ, би ярьж өгье л дөө гэв.

Тэгээд долоон жилийн өмнө далайн эрэг дээр охины үлгэрчтэй ярилцсан тухайг ярьж өгөв. Энэ гуанзанд гуйлгачны анх ярьснаас хойш уг түүх бүдүүлэг, заваан хов живийн шинжтэй болсон боловч гол утга нь хэвээрээ үлдсэн байлаа.

— Түүнээс хойш түүнийг «Онгоцны Ассоль» гэж дууддаг болсон юм гэж Меннерс хэлэв.

Байгаа, үгүй нь мэдэгдэхгүй шахам чимээгүй суусаар байгаа Летикаг Грэй түргэн харснаа гуанзны хажуугаар гарсан тоост замыг

үзтэлээ, зүрх, тархи хоёр руугаа зэрэг цохиулах шиг болов. Дөнгөж сая Меннерсийн гажигтай гэж хэлсэн мөнөөхөн Онгоцны Ассоль замаар чанх өөдөөс нь чиглэн айсуй байв. Энгийн мөртөө нэг л сонсоход сэтгэлд хоногшдог үгийн нууц увдис шиг тэр бүсгүйн нүүрийн нь гайхалтай төрх одоо нүдэнд нь гэрэлтэн байлаа. Усан цэрэг, Меннерс хоёр буруу хараад сууж байсан боловч тэр хоёрыг гэдрэг эргээд харчих вий гэхдээ Грэй зориг гарган харц шилжүүлж, Меннерсийн шар нүдийг ширтэв. Ассолийн нүдийг харснаас хойш Меннерсийн ярьсан шал худал болохыг ойлгов.

Энэ завсар Хин Меннерс ямар ч ажиг сэжиггүй үргэлжлүүлж

— Танд гэж хэлэхэд, эцэг нь ёстой адгийн амьтан байгаа юм.

Муур усанд живүүлж байгаа юм шиг л муу аавыг минь живүүлсэн хүн дээ, тэнгэр өршөө. Бас... гэтэл тэнхээгээр архирах чимээ гэнэт ард гарч яриаг нь таслав. Харвал нүүрсчин нүдээ аймшигтай эргэлдүүлэн согтуугаа гаргах гэсэн мэт гэнэт бүгдийг цочтол,

Сагсчин, сагсчин, чи биднээс

Сагсныхаа үнийг авч л бай

гэж байдгаараа дуулав.

— Хар архины хөнөг, бас л усан шалхнаг болсон уу! яв зайл гэж Меннерс зандрав.

...Харин тэгэхдээ манай нутагт

Хүрч ирэхдээ л мэдээтэй байгаарай!...

гэж нүүрсчин орилоод, юу ч болоогүй юм шиг сахлаа цалгих архиндаа дүрж орхив.

Меннерс мөрөө эгдүүцэнгүй хавчисхийлгэж

— Хүн биш шаар. Дандаа л ингэж байдаг юм! гэж харамч хариг хүний зэвүүн байдлаар хэлсэнд Грэй

— Та өөр юм нэмж хэлж чадахгүй юү? гэж асуувал

— Би юу? Би танд хэлээд байна шүү дээ, эцэг нь адгийн амьтан.

Түүний балгаар, эрхэм минь, би өнчин хоцорч, хар нялхаасаа толгой дааж амь зуухчаа аядах болсон юм гэтэл нүүрсчин

— Худлаа бүү ярь. Хүн үнэмшимгүй ингэж муухай худад хэлэхэд чинь харин архи минь гарчхав байна гэж хэлээд, Хинийг ам ангайхын завдалгүй Грэй рүү эргэж

— Наадах чинь худлаа хэлж байна. Энэ амьтны эцэг нь ч үнэн хэлж байгаагүй, эх нь ч үнэн хэлж байгаагүй. Удмаараа худалч хударгагүй улс. Та санаа зоволтгүй. Тэр бүсгүй, та бид хоёр шиг л эрүүл хүн. Би түүнтэй ярьж хөөрдөг. Миний тэргэн дээр наян дөрвөө байг гэхэд түүнээс арай цөөн суусан байх. Би нүүрсээ зарчхаад буцахдаа бүсгүйг хотоос явган буцаж явахтай тааралдвал заавал суулгадаг юм. Яах вэ суугаад явж л байг. Би түүнийг толгой сайтай гэдэг юм. Одоо энэ нь ч харагдаж байгаа юм. Хин Меннерс чамтай бол ганц үг солихгүй л дээ. Гэвч ноёнтон минь, би бол нүүрсний чөлөөт ажилтай хүн болохоор элдэв хов живийг жигшиж үздэг хүн. Тэр бүсгүй яг л том хүний яриатай. Гэхдээ ярих нь нэг л янзтай. Чагнаад байхад та бидний л ярьдаг юмыг хэлээд байдаг юм шиг мөртөө арай л өөр. Ухаан нь, түүний хийдэг ажлын тухай нэг яриа үүслээ л дээ. Бүсгүй хонхон дээр суусан ялаа шиг мөрнөөс минь зүүгдээд: «Танд гэж хэлэхэд би хийж байгаа ажилдаа уйддаггүй ээ, ганцхан онцгой хачин юм бодож олох сон гэж дандаа бодогдоод байдаг юм. Банзан дээгүүр завь өөрөө хөвөөд, сэлүүрчид нь жинхэнэ ёсоор сэлүүрдэж, эрэг рүү ойртон, зогсоол дээр ирж ёслоод, яг л амьд юм шиг эрэг дээр сууж замынхаа хүнсийг гарган идэхээр тийм уран нарийн хийх юм сан гэж хүсдэг» гэхэд нь миний инээд хүрээд хөхөрч «Ассоль минь, ингэхлээр чи тэгж боддог болоод л ажил чинь сонин санагдаж байгаа хэрэг. Эргэн тойрноо хар л даа, ажил гэдэг эх толгойгүй л байх юм байна шүү дээ» гэж хэлэхэд минь «Үгүй ээ, би мэдэх юмаа мэдэлгүй яах вэ? Загасчин загас барихдаа хэний ч бариагүй том загас барих сан гэж бодож байдаг шүү дээ» гэлээ. «Тэгвэл би юу гэж боддог вэ?» гэхэд минь бүсгүй инээж «Та сагсанд нүүрс хийж байхдаа сагснаасаа цэцэг ургана гэж бодож байдаг» гэлээ шүү. Ингэж л хэлж байгаа юм даа. Тэгэхэд нь хоосон сагс руугаа хармаар санагдаад харсан чинь нээрээ л бургас гөлөглөж сагс маань туж навч намиа болчих мэт болсон шүү. Архи маань овоо гарчхав байна. Хин Меннерс бол худал залахдаа шал тоохгүй. Наадахыг чинь ах нь андахгүй ээ? гэв.

Меннерс улаан цайм доромжлууллаа гэж үзээд, нүүрсчинийг шөвөгдөн харснаа лангууныхаа цаагуур орж тэндээсээ

— Өөр юм авах сан болов уу? гэж гомдолтойёо дуугарсанд Грэй мөнгөө гаргаж

— Үгүй ээ бид явлаа. Летика чи энд үлдээд орой харь. Харин юм ярьж болохгүй. Байдлыг сайн мэдэж аваад очоорой. Мэдэв үү? гэхэд

ромдоо халж зориг орсон Летика

— Буянт ахмад аа. Үүнийг дүлий хүн л ойлгодоггүй байх даа гэж нэлээд нүүрэмгий хэлсэнд

— Сайн байна. Бас юу ч боллоо гэсэн миний тухай ярьж, тэр ч байтугай миний нэрийг дурсаж болохгүй гэдгийг санаарай! Баяртай гэв.

Грэй гарлаа. Сэтгэл зүрх нь гал дөл шиг дүрэлзэн бадраад Бертольдын дарийн хотод оч авалцах шиг гайхалтай сониныг олж мэдлээ гэсэн бодол цээжнээс нь гарахгүй боллоо. Хийх гэснээ даруйхан хийхээр сэтгэл шулуудав. Завиндаа суухдаа л сэхээ орж, энэ тэрийг, эргэцүүлэхтэй болжээ. Грэй, инээд алдаж, дарсны зооринд багадаа нэг удаа нарны туяаг алгаараа тоссон шигээ төөнөх нарны туяаг тосов. Тэгээд хөлгийнхөө зүг хурдлан сэлүүрдэж эхэллээ.

IV : УРЬД ӨДӨР НЬ

Үүний урьд өдөр буюу үлгэрч Эгль далайн эрэг дээр охинд аранзал дарвуулт хөлгийн үлгэр ярьж өгснөөс хойш долоон жилийн дараа билээ. Тэр өдөр Ассоль ердийнхөөрөө тоглоомын мухлагт очоод, урам муутай, уруу царайтай буцаж ирэхдээ бараагаа сөөрөг нь авчирсан байв. Бүүр гутарч хоцроод, яасныг шууд хэлж чадсангүй боловч эцгийнхээ зовонгуй царайгаар их л муу юм бодож байгааг нь гадарлаад цонхны дэргэд очиж, шил хуруугаараа зуран, далайг алмайдуухан харсаар юу болсныг ярьж өгчээ.

Тоглоомын мухлагийн эзэн энэ удаа дансаа нээгээд, хэчнээн өртэй болсныг нь харуулсанд гурван оронтой том тоо харж цочих шиг болжээ. «Арван хоёрдугаар сараас хойш хэчнээн мөнгө авсан байна даа. Одоо хэдэн тоглоом зарсныг үзье» гэж худалдаачин хэлээд хоёр оронтой өөр нэг тоо хуруугаараа хатгасныг үзвэл даан ч гонсоймоор, гомдмоор байжээ. Тэр худалдаачны царайг харахад их л ууртай байсан гэнэ. Би гүйгээд явчихмаар байсан боловч үнэнийг хэлэхэд ичээд хөдөлж ч чадсангүй. «Хонгор минь, ийм тоглоом надад ашиггүй байна. Одоо гадаадын бараа чамин болж, дэлгүүр бүрд элбэгшээд ийм юм авахаа больжээ» гэж надад хэлсэн. Өөр зөндөө л юм ярьж байсан. Би самуураад мартаж орхиж. Тэгээд «Хүүхдийн зах», «Алладины шидэт дэнлүү» мухлагаар орохыг зөвлөснийг бодоход намайг өрөвдсөн байх л даа гэж Ассоль ярив.

Бүсгүй, гол хэлэх гэснээ хэлээд, эргэж өвгөнийг эмээсхийн харав. Аав нь өвдгөө тулж, гараа салаавчлан бөхийн сууж байснаа охиныгоо өөрийг нь харж байгааг мэдээд толгойгоо дээш болгон санаа алдав. Ассоль сэтгэлээ хатамжлан, аавынхаа дэргэд гүйж хүрээд, савхин хүрмийн нь ханцуй руу бяцхан гараа шургуулж, царайг нь өлийн ширтэж, их л баясгалантай дүр үзүүлэн

— Дажгүй ээ, аав аа, дажгүй, та дуулж бай, за юу. Тэгээд би аймаар том дэлгүүрээр орлоо. Хүн амьтан гэж тэнд пиг юм аа. Түлхүүлсээр явж, нүдний шилтэй хар хүн дээр очлоо. Тэр хүнд юу гэж хэллээ дээ санахгүй байна. Тэгсэн чинь тэр хүн инээмсэр болсноо сагстайг минь онгичиж, ганц тоглоом авч үзсэнээ дахин байснаар нь бааданд боогоод эргүүлж өгсөн гэж хэлэв.

Үүнийг сонсоход нь олон баячуулын дунд, үнэтэй цайтай бараа туруу овоолсон лангууны дэргэд самгардан зогсоо охин нь нүдэнд нь үзэгдэх шиг болж, уур нь хүрч суулаа. Нүдний шилтэй цэмцгэр хүн Лонгрений бүдүүн бааз бүтээгдэхүүнийг худалдаж эхлэх юм бол хоосрохын цондон гэж Ассольд их л эелдгээр тайлбарласан байна. Тэгээд барилга, төмөр замын гүүрний угсармал загвар, жинхэнэ юм шиг жижигхэн машин, цахилгаан хэрэгсэл, нисэх онгоц, хөдөлгүүр зэргийг Ассолийн урд лангуун дээр хайхрамжгүйхэн атлаа сурмаг гээч нь гаргаж тавив. Эдгээрээс будаг ханх тавина. Тэр хүний хэлэх нь хүүхдүүд тоглохдоо ч томчуулын хийж байгааг л дуурайдаг гэнэ.

Ассоль, «Алладины шидэт дэнлүү» болон өөр хоёр мухлагаар орсон боловч хөлийн гарз болжээ. Бүсгүй ийнхүү яриад хоолоо зэхэв. Лонгрэн хоолоо идэж, аяга аагтай кофе уугаад өгүүллрүүн:

Ажил, амьжиргаа ингэж бүтэл муутай байгаа боловч ажил эрэх л хэрэгтэй. Би «Фицроя» юм уу, «Палермо» хөлгийн аль нэгэнд дахин ажилд ордог юм билүү гэснээ тоглоомоо бодсон бололтой

— Тэднүүсийн ч зөв юм байх аа даа гэж бодлогошронгүй хэлээд

— Одоо ч хүүхэд тоглоомоор наадахаа байгаад сургуульд сурдаг болсон юм чинь дээ. Сурсаар байгаад нэг насыг барах болж. Яах аргагүй тийм болж. Тоогүй, тун тоогүй. Намайг нэг яваад ирэхэд надгүй байж чадах уу? Ганцаарыг чинь орхиж сэтгэл нэг л түвдэхгүй юм гэхэд нь, — Би ч гэсэн тантай хамт ажиллаж болно шүү дээ. Ухаан нь, хөлөг онгоцны гуанзанд юм хийе гэсэнд Лонгрэн ширээ хайвганатал алгадаж

— Үгүй ээ. Амьд байсан цагтаа би чамайг зарц болгохгүй. Цаг бас байна, амьд хүн аргатай гээд хөмсөг зангидан чимээгүй болов. Охиноо өөрийнх нь суугаа сандлын өнцөг сандайлаад, сэтгэлийг нь засах гэж бондгонон байгааг нүднийхээ булангаар харахдаа золтой л инээд алдчихсангүй. Гэвч инээмсэглэнэ гэдэг охиноо ичээчихнэ гэсэн үг байлаа. Ассоль амандаа юм үглэн, буурал үснийх нь ширэлдээг гарган илж, сахал дээр нь үнсээд, үсэрхэг чихийг нь нарийхан жижиг хуруугаараа бөглөн

— Одоо та миний өөртөө хайртайг дуулахгүй байгаа даа гэжээ.

Лонгрэн, охиныхоо үсээр нь тийнхүү оролдож байхад тамхины утаа үнэртүүлчих вий гэж амьсгаа авч чадахгүй байгаа хүний байдалтай хөмсгөө атируулан сууж байсан боловч тэгж хэлэхэд нь тэссэнгүй түсхийтэл инээд алдаж, охиныхоо хацрыг өхөөрдөн илснээ

— Миний охин, эрэг дээр очиж завь харахгүй юу даа гэж хэлжээ.

Ассоль эрэг дээр очиж юм бодон суудаг юм уу, эсвэл гэрийнхээ ажлыг хийдэг юм уу гэж тасалгааныхаа голд хэсэг зуур тээнэгэлзэн зогссоноо, сав суулга угаагаад, шүүгээгээ нээн идэх юмныхаа байрыг харжээ. Жигнэж хэмжсэнгүй боловч гурил нь долоо хонохгүй, чихрийнх нь савны ёроол гарчихсан, боодолтой цай, кофе бараг барагдсан, цөцгийн тос бүүр дууссан, санаа зовохгүй байж болох цор ганц зүйл гэвэл шуудай төмс л байгааг үзээд шалаа угааж хуучин цамцаа засаж байж хийсэн банзалд хуниас гаргахаар суусан боловч даавууны өөдөс толины ард байгааг санаад очиж боодолтой юмаа авахдаа өөрийгөө толинд харжээ.

Хуш модон жаазны цаанаас, толинд туссан тасалгаа дотор ягаан цэцгэн хээтэй хямдхан цагаан даавуу даашинз өмсөж, мөрөн дээрээ бор торгон хошуу алчуур тохсон намхан нуруутай турьхан бүсгүй зогсож байгаа харагдав. Ялихгүй борлосон хүүхдийнхэрхүү царайд нь сэтгэлийн нь байдал тодорч, ийм бага залуу хүнд баймааргүй нэлээд тогтуун сайхан харцнаас нь уужим сайхан сэтгэлтэй нь илхэн харагдана. Нүүр нь этгээд сонин боловч нугалаа зураас бүхэн нь дурайж зурайгаад сэтгэл хөдөлгөнө. Энэ царайн нүд, ам, хамар, зэргийг олон олон эмэгтэйн төрх байдлаас олж үзэж болох боловч цөм нэгэн царайд нийлэн цогцлохдоо туйлын өвөрмөц, тун хачин ялдам болж үзэгдэнэ. Ингээд бид зогсёе. Бусдыг нь «сэтгэл булаах» гэдэг ганц үгнээс өөрөөр илэрхийлэх аргагүй ээ.

Толин доторх бүсгүй, Ассоль шиг санаандгүй инээмсэглэв. Инээмсэглэсэн нь гунигтай болж, өөрөө үүнийгээ харахдаа зовчхов. Өөр хүн ингэж инээмсэглэхийг харсан бол бас л ингэж зовох сон биз ээ. Тэгээд шилэнд хацраа нааж, нүдээ аниад, өөрийн дүрс туссан газар толио аяархан илэв. Бүүр түүрхэн, эергүү таатайхан бодол халгин ирж, бүсгүй цэлхрэн, инээд алдсанаа юм оёод суучхав.

Бүсгүйн үйл хийж байхад нь цээжийг нь өнгийж үзье. Гайхалтай этгээд сонин чанарыг хослуулсан хоёр бүсгүй, хоёр Ассоль энэ цээжнээ байна. Нэг нь тоглоом урладаг усан цэргийн охин, нөгөө нь уянга айзам, уран дүр гайхамшигтай зохилдсон, онч үг учиртай хоршин бие биеэ товойлгож өгсөн, гэрэл сүүдэр нь гайхалтай тохирсон амьд найраг байлаа. Тэр бээр амьдралыг үзсэн туршлагынхаа хэрээр л мэдэх боловч түгээмэл үзэгдлийг харахдаа өөр утга учиртай болгон ургуулан дүрсэлнэ. Тийнхүү юмыг хараад байхад амьгүй мөртөө

хүнтэй адил юм шиг, тэгэхдээ бүр хүн хүн янз янз байдаг шиг юм бас онд ондоо байх мэт бодогдоно. Бидний энд жишээ болгож хэлсэнрхүү юмыг Ассоль харахдаа байгаа зүйл дээр нэмж хардаг байжээ. Энгийн ойлгогдох бүхнийг заавал ингэж сэтгэлдээ зураглан боддог байлаа. Ном уншиж чаддаг, унших дуртай, тэгэхдээ амьдардаг шигээ номынхоо далд утгыг олон уншиж чаддаг байлаа. Илэрхийлэн хэлэх аргагүй боловч хиргүй сэтгэл, халуун илч шиг чухал агаад ижилгүй нарийн юмыг өвөрмөц онгод бадрахдаа алхах гишгэх тутамдаа өөрөө ч мэдэлгүй нээн олно. Заримдаа ийм байдал хэдэн өдрөөр үргэлжилж, төрөл арилжсан юм шиг болоод, хөгжмийн эгшиг нам гүмд уусан шингэх мэт бие сэтгэл байгальд нийлээд түүний үздэг, хийдэг бүхэн, эргэн тойронд нь байдаг бүхэн өдөр тутам дайралдавч учир тайлагдахгүй нууц шиг болчихдог байлаа. Догдолж хөөрөх, айж эмээх зэрэгцээр шөнө далайн хөвөөн дээр очиж Улаан дарвуулт хөлгийг үнэнээсээ харуулдан үүр цайлгадаг байлаа. Ингэж суух нь түүнд жаргал билээ. Бидэнд бол үлгэрийн оронд тийнхүү очиход хэцүү байдаг бол үлгэрийн эрхшээл, сэтгэл татах чадлаас гарахад нь бүсгүйд түүнээс ч хэцүү байдаг ажээ.

Бусад үед энэ тухай эргэцүүлэхдээ өөртөө үнэнээсээ гайхаж, итгэж байсан юмандаа ч итгэл алддаг байлаа. Далайд гомдоогүйгээ илтгэн инээмсэглэж, сэрүүнээрээ зүүдлэхээ гунигтайяа болиод одоо банзлынхаа хуниасыг хийнгээ өнгөрсөн амьдралаа бодож суув. Уйтгар гунигтай, эгэл жирийн юм амьдралд нь их байлаа. Хоёулхнаа байдагтаа туйлын гутрах боловч дотроо айж, шаналснаас урамшиж хөгжихөөргүйгээр сэтгэлд нь сэв суужээ. Түүнийг «гажигт», «солиот» гэж шоолох боловч ингэж нүд үзүүрлэхэд нь ч дассан байв. Жаал бүсгүй тэр ч байтугай муухай гэгч доромжлуулсныхаа дараа цээж нь балбуулчихсан юм шиг хөндүүрлэн байдаг байлаа. Капернад түүнийг бүсгүй хүнийх нь хувьд үнэлдэггүй байсан боловч олонх нь түүнийг бусдаас илүү заяатай, тэгэхдээ бүр онцгой илүү заяатай гэдгийг зөнгөөрөө мэдэхдээ байж ядна. Каперныхан том булчинтай, бахим гартай, тос даасан, тарган лагс хүүхэнд дуртай. Энд хүүхний дал мөрийг алгадан, зах зээл дээр байгаа юм шиг түлхэж чангаан эргүүлдэг. Сэтгэлээ ингэж илчилнэ гэдэг энгийн нэг хашхирчихаас юуны өөр. Ад мөрийн амьтад Ассунт буюу Аспаз дагинас шиг гоо үзэсгэлэнтэй байлаа ч гэсэн эмзэг нарийн сэтгэдэг хүмүүст ямар санагддаг вэ, Ассоль бүсгүй тэр бүдүүн хадуун улсад яг л тэгж

санагддаг байлаа. Ингэхлээр хайрын нандин сэтгэл гэж ярихын ч хэрэг байсангүй. Тийнхүү цэргийн бүрээний жигд цангинах дуун дотроос хийлийн гайхамшигтай гунигт аялгуу догшин хороо цэргийг шуудран чиглэсэн замаас нь гаргаж чадахгүйтэй адил юм. Энд өгүүлсэн зүйлийг бүсгүй үл тоомсорлоно.

Толгойд нь аж амьдралын тухай бодол эргэлдэж байхад бяцхан гар нь нямбай сурмаг хөдөлж, утасныхаа учгийг тас хазахдаа урагшаа ширтсэн байвч оёдлын машинаас дутуугүй даавуугаа нарийн эмхэрдэж, товчны нүх гаргаж байлаа. Аав нь ирэхгүй удаж байсан боловч санаа төдий л зовсонгүй. Сүүлийн үед аав нь шөнө загас барих буюу салхинд гарах гэж зөндөө явах болжээ.

Аавдаа муу юм тохиолдохгүй гэж бат бодоод айж сандарсангүй. Энэ талаар бол «Эзэн тэнгэр сайн байна уу?» гэж өглөөд нь, «Эзэн тэнгэр сайхан нойрсоорой» гэж үдэш нь өөрийнхөөрөө шулганан мөргөдөг бяцхан охин хэвээрээ байжээ.

Ингэж мөргөхөд л эзэн тэнгэр гай тотгорыг зайлуулаад өгнө гэж тэр бодно. Тэнгэрийн оронд өөрийгөө тавьж үзнэ. Эзэн тэнгэр сая живаа хүний аж төрлийг дандаа мэдэж байх учир дүүрэн хүн цуглараад байгаа айлд ирээд дайралдсан суудалд нь морилчхоод юу таарсныг нь зооглочхоод ядарсан эзний нь зүйг баримтлан тэвчээртэй хүлээж байгаа зочны байдлаар амьдралын аар саар зүйлд хандах ёстой гэж бодно.

Ассоль оёж дуусаад, банзлаа булангийн ширээн дээр тавьж хувцсаа тайлан хэвтэв. Гал унтарчээ. Нойр нь хүрч үл өгнө. Яг л гэгээн цагаан өдрөөр юм шиг л тархи нь саруулхан, шөнийн харанхуй хүртэл хиймэл юм шиг санагдана. Бие нь ч өдрийнх шиг хөнгөхөн байна. Зүрх нь дэр, чих хоёрын хооронд байгаа юм шиг халаасны цагийн цохих хэмээр цохино. Ассоль эргэж хөрвөж, хөнжлөө нэг тийчин хаяж, нэг толгой дээгүүрээ бүтээн уур нь хүрч хэвтэв. Тунгалаг усанд чулуу шидэхэд хөнгөхөн цагариг үүсэхийг нь харж байна гэж төсөөлөн бодвол унтахад нь тус болдог учир тийнхүү сурснаараа төсөөлөн бодов. Энэ дохиог хүлээж байсан юм шиг нойр нь хүрээд явчхав. Зүүд нойрны эзэн хүрч ирээд, орны нь толгой дээр зогсож байгаа Меритэй шивнэлдсэнээ Мерийн инээмсэглэхэд автан эргэн тойрондоо «Чш-ш-ш-ш» гэж хэлэв. Ассоль дорхноо унтлаа. Тэгээд мод цэцэглэх, сэтгэл уйтгарлах, нэг юм дурыг нь булаах, дуу хөгжим хангинах, битүүлэг үзэгдэлтэй тааралдах зэрэг дуртай зүүд нь зүүдлэгджээ. Сэрээд

бодоход өлмийнөөс нь аваад зүрхэнд нь хүртэл сэрүү татуулж, сэтгэл баясуулан халгих хөх усны гялтганасан мандал л ганцаараа санаанд нь хоцорсон байлаа. Бүсгүй энэ бүхнийг үзэж, байхгүй оронд хэсэг байснаа сэрээд босож суув.

Огт унтаагүй юм шиг нойр нь бүр хулжжээ. Баярын совин татаж, нэгийг хийх хүсэл төрөв. Бүсгүй, шинэ байшинд ороод харж байгаа юм шиг эргэн тойрноо харна. Үүрийн хяраа дөнгөж татаад, гэгээ сайн ороогүй боловч барай бүрийн дунд орчны юмыг барагцаалж болохоор байлаа. Цонхны доод хэсэг нь харлах боловч дээд тал нь гэгээтэй болжээ. Гэрийн гадаа, бараг цонхны жаазны хөмсөг дээр үүрийн цолмон гялбалзана. Ассоль одоо нойр нь хүрэхгүй гэдгийг мэдээд, хувцсаа өмсөж, цонх руугаа очоод, дэгээг нь мултлан, цонхоо онгойлгов. Гадаа ажин түжин. Саяхан л ийм болоо юу гэмээр. Хөхрөх бүрэнхийд бут сөөг бүрэлзэж, цаадтай нь модод унтаж, бүгчим оргин, шороо үнэртэнэ.

Бүсгүй, цонхны дээд ирмэгээс барин инээмсэглэн зогсоно. Гэв гэнэт алс тэртээгээс дуудах мэт болж хамаг бие сэтгэл нь догдлон оволзоод, сэрүүн байснаа бүр ч сэргэж ирэв. Энэ агшнаас эхлээд хөөрөн догдолсон сэтгэл нь намдсангүй. Хүний үгийг бид сонсож байхдаа ойлгож байдаг боловч тэр хэлснээ дахиад хэлэхэд өөр шинэ утгыг гүнзгийрүүлэн ойлгодог шүү дээ. Ассоль яг л тийм байдалтай боллоо.

Нэлээд хуучирсан боловч өөрийн нь нөмрөхөд ямагт шинээрээ юм шиг харагддаг торгон хошуу алчуураа авч, эрүүвчлэн боогоод, хаалгаа цоожлон, хөл нүцгэн гүйж гарав. Эргэн тойронд эл хуль, анир чимээгүй байсан боловч өөрөө хөгжим шиг хангинаж, түүний нь хүмүүс сонсож байх мэт бүсгүйд санагдаж байлаа. Бүх юм ялдам санагдаж, бүх юманд баясал төрнө. Умбарсан бүлээн шороо хөлийг нь гижигдэнэ. Дотор нь цэлмэг бөгөөд баясгалантай. Бүдэгхэн цайрах тэнгэрийн наана байшингийн дээвэр, үүл харлаж, сүлжмэл хашаа, нохойн хошуу, ногооны талбай, цэцэрлэгт хүрээлэн, нүдэнд дулаахан үзэгдэх зам тэргүүтэн зүүрмэглэн байна. Энэ бүгд өдрийнхөөс нэг л өөр байдалтай агаад урьд нүдэнд нь өртөж өгөхгүй байсан зохилдлого одоо тодрох мэт болно. Бүгд дэргэдүүрээ өнгөрөх бүсгүйг сэмхэн ширтэж хараастайгаа унтах ажээ.

Бүсгүй, холдох тусмаа сууринаасаа гарах гэж яаран, алхаагаа нэмэв. Каперна тосгоны цаана нуга цэлийж, нугын тэртээх эргийн

толгодын бэлээр шид, улиангар, туулайн бөөр, нил ургажээ. Зам баларч бүдэг бадагхан жим болох үед зүрх цагаан, нүд ухаалаг нэгэн сэгсгэр хар нохой гарч ирээд Асолийн хөлийн дэргэд эрхлэн эргэлдэв. Нохой Асолийг таниад, бие биеэ андахгүй шүү дээ гэж бүсгүйд өгүүлэх мэт гийнаж, хажууд нь мойтгоносоор даган явав. Ассоль нохойн нэгийг хэлэх мэт нүдийг хараад, хэрэв дуугардаггүй нууц шалтгаан байдаггүй сэн бол нохой юм ярих байсан гэдэгт бат итгэжээ. Дагаж яваа хүнийхээ инээмсэглэхэд нохой хамраа баяртайяа хөдөлгөж, сүүлээ нэгэнтээ шарваад урагш түрүүлэн гүйснээ гэнэт ажиггүй суугаад, нэг насныхаа дайсанд уруулсан чихээ хөлөөрөө хичээнгүйлэн маажсанаа эргээд давхичхав.

Ассоль шүүдэр цацах нугын өндөр өвсөн дунд орж, алгаараа толгойг нь шүргэн өнгөрөхөд алга нь ирвэгэнэн инээд нь хүрч явлаа. Цэцэг цэцгийн өвөрмөц өнгө, орооцолдсон ишийг сайн ажиглавал цөмөөрөө л хүн шиг төрх, тэмүүлэл, хөдөлгөөн, шинж, харцтайг ялган үзэж болно. Хэрэв одоо хулгана жагсаж, зурам найрлаж, зараа унтаж байгаа анхайг үргэтэл тургин хөгжилдөж байгаатай тааралдсан бол Ассоль гайхахгүй сэн билээ. Санаа дагасан юм шиг зараа буурайчхаад зам дээр нь гүйн гарч ирээд, тэрэгний хөтөч явган хүнд уурлах мэт «ух-ух» гэж уухилав. Ассоль ойлгодог, таньдаг, бүхэнтэйгээ ярина. Өтөнд сархинаг болтол идүүлсэн цанхир сахалдагт «Сайн байна уу, мундгаа» гэж хэлэв. Жимийн голд ургаад, үүгээр өнгөрөгсдийн хувцсаар чангаагдан сугарсан бутанд «Гэрээсээ гарах хэрэггүй ээ» гэв. Том цох хонхон цэцгэн дээр суугаад ишийг нь бөхийлгөн, өөрөө унан алдавч хөлөөрөө базан дүүжигнэнэ. «Тарган зорчигчийг сэгсрээд хаячих» гэж бутанд зөвлөв, Цох нээрээ ч тогтож чадсангүй юу гэлтэй хажуу тийш шарчигнан нисэв. Тийнхүү Ассоль сэтгэл хөдөлж, зүрх догдолсоор, толгойн бэл хүрч, тэгш нугаас харагдахааргүйгээр ширэнгэн дунд орсон нь аргил хоолойгоор ярьдаг (үүнийг нь бүсгүй мэддэг байлаа) жинхэнэ анд нөхдийнхөө дунд орох шиг болжээ.

Энэ бол далан хальс, шидийн бутан дунд ургасан том хөгшин модод байжээ. Эдгээрийн нэлмийн буусан мөчир нь бутны үзүүрийн навчсыг шүргэнэ. Туулайн бөөрний тайван унжих далбигар навчин дотор цагаан цэцэг бурзайж, анхилам үнэр нь намирга, давирхайн үнэртэй нийлэн сэнгэнэнэ. Гилийсэн үндэс товойлдон үзэгдэх жим нэг өгсөж нэг уруудна. Ассоль яг л гэртээ ирсэн юм шиг болж, модтой яг л хүн шиг мэндэлж, далбигар том навчийг нь атгана. «Чи байна. Бас өөр

нэг чи байна. Ах дүү нар минь та нар олуулаа юм аа! Ах дүүс минь, би яарч явна шүү дээ, намайг явуулаач! Би та нарыг бүгдийг нь танина, бүгдийг нь санаж байна, бүгдэд нь хайртай» гэж сэтгэлдээ бодож, амандаа шивнэсээр явахад нь «ах дүү» нар нь хариуд нь навч нахиагаараа ихэмсгээр илбэж, элгэмсүү гэгч нь чийхран дохино. Ассоль хөлөө цул шавар болгон далай руу өнгийсөн ганганы ирмэг дээр гарч ирээд хурдан явсандаа амьсгаадан зогсов. Юунд ч дийлдэшгүй гүн их итгэл цээжинд нь оргилон, халгилан байлаа. Энэ их итгэлээ харцаараа дамжуулан тэнгэрийн хаяа руу илгээхэд, тэр нь эргийн давлагааны намуухан цалгих чимээтэй хамт цэнгүүн сайхнаар дүүлэнхэн буцаж ирэх шиг болно.

Энэ зуур хаяагаараа алтан саа эмжээртэй болсон их далай нойрсож, гагцхүү эргийн доорх хонхор хотгорт л ус гүвэлзэн байна. Амгалан нойрсох далайн тунамал цайвар өнгө цэнхэр, хар хоёр өнгөнд шингэн уусна. Алтан сааны цаана тэнгэр өөд түмэн цацраг шижиртэй цацарч, цагаан үүлс ялихгүй ягаарчээ. Ижилгүй гоё, нарийн өнгө эдгээрт цогцолсон байлаа. Харлан бараантах алс жирвэгэнэсэн сүүн цагаан гэрэлд сүлэгдэж эхлэв. Хөөс мөнгөрч, гал улаан туяа алтан сааны голд бадамлан, далай дундуур Ассолийн хөлийг хүртэл зурваслан татаж, энэ туяанд ус мяралзан бидэртэн үзэгдэв.

Бүсгүй өвдгөө тэврэн суулаа. Далайн зүг их л мэрийсэн янзтай бөхийж, том хүний буурь огт байхгүй хүүхдийн цайлган харцтай том нүдээрээ тэртээ тэнгэрийн хаяаг дүрлийтэл ширтэнэ. Бүсгүйн тийнхүү өнө удаан, тэсэж ядан хүлээж байгаа бүхэн нь ертөнцийн хязгаарт болж байжээ. Далайн хязгааргүй алс дахь хөлгүй гүнд байх орноо усан доорх толгой дээрээс эрчлэн мушгирсан өвс ургамал найгалзан дээш тэмүүлж, хэлхээстэй сувд шиг дугуй навчсын дунд хачин чамин цэцэг солонгорон байгааг Ассоль үзнэ. Оройнх нь навчис далайн мандалд гялтганан байна. Ассолиос өөр юу ч мэддэггүй хүн бол гагцхүү далайн бидэртэх, гялганахаас өөрийг олж үзэхгүй сэн биз ээ.

Төгөлийн цаанаас хөлөг гарч ирээд, үүрийн туяа голлон зогсов. Энэ алсаас хөлгийг харахад тов тодхон үзэгдэнэ. Тэр хөлөг баяр хөөрийг түгээж, хөвөн явахыг нь зүйрлэн өгүүлбээс амтат дарс, анхилуун сарнай, булгилах зүрх, бүлээхэн уруул, аранзал хилэн, дүрэлзэх гал гэлтэй. Хөлөг, Ассолийн чанх өөдөөс айсуу. Хүчирхэг өвчүүгээрээ ус зүсэхэд хоёр тийш цагаан хөөс цахран зурайж, бүсгүй зүрхээ даран босвол гэрлийн гайхамшигт энэ наадам долгион дунд

зэрэглээтэн алга болж нар мандан, өглөөний хурц гэрэл нялхамсан наалинхайтаж, нойрмог газар руу татагдан байсан бүхний хучлагыг хуу татан хаявай.

Бүсгүй шүүрс алдан эргэн тойрноо харав. Найрал хөгжим чимээгүй болсон боловч цангинам аялгуу нь түүний сэтгэлд уянгалсаар байлаа. Дэвэрсэн сэтгэл нь намж намжсаар, түрүүнд ийм юм бодогдож байсан гэх төдий болж, бүр сүүлдээ бүх бие нь алжаан сулрав. Ассоль ногоон дээр хэвтээд, нэгэнтээ эвшээлгэсэнээ нүдээ таатайяа анин, залуу хүний бөх нойроор санаж бодох, зүүдэлж барих юмгүй унтаж орхилоо.

Нүцгэн тавгийг нь ялаа ирвэгэнүүлээд сэрээчхэв. Хөлөө түргэн хөдөлгөснөө сэрчхэв. Суугаагаараа үсээ гараараа самнах гэсэн боловч Грэйнд бөлзөг тээглэсэнд, түүнийг хурууныхаа завсар хавчуулагдсан өвсний иш гэж бодоод хуруугаа тэнийлгэсэн боловч нөгөө тээглээд байгаа юм нь арилж өгөхгүй байсанд гараа дахин лавлан харснаа үргэсэн гөрөөс мэт огло үсрэн босжээ.

Грэйнд бөлзөг хуруунд нь шижиртэй солонгорч байсанд энэ хуруу чинь минийх мөн үү, биш үү гэж гайхжээ. «Хэний бөлзөг юм бол?» Хэнийх юм бол? Би чинь унтаж байна уу? Эсвэл урьд олоод мартчихсан хэрэг үү?» гэж дуу алдав. Солгой гараараа бөгжтэй зөв гараа бариад далайн мандал, ногоон төглийг шинжин шинжин харсан боловч бутан дунд хөдөлж байгаа юм ч харагдсангүй, нуугдсан ч юм үзэгдсэнгүй, туяаран цэнхэрлэх далайд нүдэнд торох бараа ч байсангүй. Ассолийн нүүр халуу оргин улайж, зөнч зүрх нь «мөн, мөн» гэж булгилан байлаа. Энэхүү болсон явдлыг тайлбарлах юм байсангүй боловч хэлэх, бодох юмгүй, гагц сэтгэлийн хачин байгаагаар тайлбарлан бодож, бөлзөг нь сэтгэлд улам дотно санагдаад явчхав. Хамаг бие нь чичирч, бөлзгөө хуруунаасаа аваад, ус утгасан юм шиг хоёр алган дээрээ тавин, бүхий л сэтгэл, бүхий л зүрх, бүхий л баясал, залуу насны бүхий л сүжгээр хараад өвөртлөв. Нүүрээ алгаараа дарснаа инээдээ барьж ядсаар доош тонгойн ирсэн замаараа буцав.

Бичгийн мэргэдийн өгүүлдэгчлэн, өлзий учрал төгс бүрдсэн зуны энэ өглөө Грэй, Ассоль хоёр ийнхүү санамсаргүйеэ учран золгожээ.

V : ЮМАА ТӨХӨӨРСӨН НЬ

Грэй «Нууц» гэдэг нэртэй хөлгийнхөө тавцан дээр гараад толгойгоо илж баахан зогсов. Үүнийг нь харахад ихэд самгардсан нь илт. Сэтгэл тогтворгүй байгаагийн шинж үүлгэр байдал зүүдэн өвчтэй хүн шиг хайнгадуухан инээмсэглэх царайнаас нь харагдана. Туслах Пантен нь тавагтай хайрсан загас барьчихсан хажуугаар нь гарч яваад, Грэйг харснаа ахмадынхаа нэг л хачин байгааг ажиглаж

— Та гэмтчихээгүй биз? Хаагуур явав? Юу үзэв? Энэ ч надад хамаагүй л дээ. Харин пүүсийн төлөөлөгч их ашигтай ачаа ачих санал тавиад байгаа даа, тэгээд бүр шагналтай юм гээч. Үгүй, та чинь яачхаа вэ? гэсэнд Грэй хүлээс сая алдрах мэт санаа алдаад

— Баярлалаа. Чухам л таны энгийн ухаалаг дуу надад дутаж байж. Энэ чинь надад хүйтэн ус л гэсэн үг. Пантен, өнөөдөр зангуугаа татаж эндээс арван бээрийн газар байгаа Лилиан голын адагт очно. Гол харгиа ихтэй учир далайгаас л голын адаг руу орж болно. Надаас газрын зураг аваарай. Лоцманыг авч явах хэрэггүй. Одоохондоо ийм байна... Аа тийм, тэр ашигтай ачаа чинь надад даанч хэрэггүй. Үүнийг цаад төлөөлөгчдөө хэлээрэй. Би хот орлоо, оройноос нааш ирэхгүй гэж хэлсэнд

— Юу болов? гэж гайхжээ.

— Онцын юмгүй ээ, Пантен. Элдэв долоон юм асуухад дургүй байгааг минь болгоогоосой гэж хүсэх байна. Цагийг нь болоход учрыг би танд өөрөө хэлнэ. Онгоцонд засвар хийнэ, эндхийн засварын газар зайгүй байна гэж далайчдад хэлээрэй гээд Грэй цааш явахад Пантен араас нь

— За биелүүлье гэж хэллээ.

Ахмадын өгсөн тушаал тов тодорхой байсан боловч туслах нь нүд бүлтийн гайхаж, тавгаа барьсаар өрөө рүүгээ сэтгэл тавгүй харайлгах зуур «Пантен, чамаар ч ёстой тайлагдахгүй оньсого таалгалаа даа. Хулгайн тээвэр хийх гэж байгаа юм биш биз? Хар туг хийсгэж далайн дээрэмчин болох гээгүй байгаа?» хэмээн амандаа үглэнэ. Пантен, тийнхүү янз янзаар эргэцүүлсээр толгой эргэж хоцров. Түүнийг загасаа цухалдангуй эд бад хийж байх хооронд Грэй өрөөндөө орж, мөнгө аваад, тохойг гатлан Лиссийн худалдааны хороололд очлоо.

Грэй, одоо яахыгаа нэгд нэгэнгүй мэдэж, шийдвэртэй, тайван хөдөлж байлаа. Сэтгэх, хөдлөх бүрийдээ уран бүтээл туурвих мэт цэнгэлийн дээдийг эдэлнэ. Төлөвлөгөө дор нь барин тавин зохиож орхив. Грэй аж амьдралын тухай ойлголтоо сүүлийн удаа нягтлан тодруулсан нь, уран барималч мөнх гялалзах гантиг баримлыг эцсийн удаа өнгөлөх лугаа адил болжээ.

Грэй, ямар өнгийн торго авахаа сэтгэлдээ үзэж байсан учир зөв сонгохыг гол гэж бодон гурван ч мухлагаар оров. Эхний хоёр мухлагт ямар ч яадаг юм гэсэн нэрэлхүү хүний сэтгэлд таарахаар олиггүй өнгөтэй торго үзүүлжээ. Сүүлийн гуравдахаас нь санаандаа таарсан өнгөний дээдийг олов. Мухлагийн эзэн удтал дарагдсан торгыг гаргаж тавин, хөл алдан хөдлөвч Грэй шинжээчийн буурь зааж байлаа. Хуйлаастай торгыг уйгагүй ялгаж, хойш тавихыг нь хойш тавьж, хажуу тийш түлхэхийг нь түлхэж, дэлгэн харахыг нь харж, гэрэлд барин үзэхийг нь үзэхэд лангуун дээр хөглөрөх торго гал ноцож байна уу гэмээр болж байлаа. Грэйн гутлын өлмий дээр гал улаан торго эвхрэн унаж, гар нүүр нь торгоны гэрэлд туяарчээ. Гарт яльгүй сөргөх торгыг ухаж, улаан, цайвар ягаан, хүрэн ягаан, хүрэн улаан, улбар ягаан, зэвхий улаан гэж өнгө өнгөөр нь ялгалаа. «Сайхан», «гоё», «хээнцэр», «ганган» зэрэг адил утгатай үг олон байдагчлан эдгээр торго ижил юм шиг мөртөө л нарийн ялгаатай байлаа. Нугалаас хуниасанд нь нүдээр үзээд ялгахгааргүй туяа байх боловч жинхэнэ аранзал улаан өнгө манай ахмадын нүдэнд удтал өртсөнгүй аж. Мухлагийн эзний авчирч байгаа бүхэн сайхан байсан боловч яг л энэ болно гээд авчихаар өнгөтэй торго байхгүй л байлаа. Тэгж тэгж худалдан авагч нэг торгыг тогтоон анхаарч, цонхон тийш очиж, сандал дээр суугаад, сэрчигнэх торгоны урт үзүүрийг өвдөг дээрээ татан авчирч тавиад гансаа зуусаар, гэдрэг налан, бясалгал үйлдэх мэт таг болжээ.

Үүрийн туяа шиг ийм хольцоогүй, нүд баясгасан жавхлан төгөлдөр өнгө бол Грэйн яг эрж байсан сүрлэг өнгө дүрээрээ мөн. Үүнд галын дөл, намуу цэцгийн холимог өнгө ч, нил хөх, хөх ягаан өнгө ч солонгорч харагдахгүй, тэр ч байтугай хөх, хар туяа татахгүй, огт эргэлзэх юмгүй цэвэр өнгө байлаа. Энэ торго сэтгэлийг тольдох мишээл лугаа адил үзэсгэлэнтэйеэ улайран байна. Грэй, бодол болоод, мухлагийн эзэн ухасхийхээр зэхэн мяраасан гөрөөч нохой шиг ард нь

хүлээн зогсоог мартаж орхижээ. Худалдаачин хүлээж ядаад нэг торго шажигнатал цуу татан чимээ өгсөнд Грэй босох зуураа.

— Одоо торго үзэхгүй, боллоо, энэ торгыг би авъя гэв.

— Хуйгаар нь? гэж худалдаачныг эргэлзэхэд Грэй түүний духыг дуугүй ширтвэл мухлагийн эзэн нүүрэмгий болж, — Тэгвэл хэдэн метрийг вэ? гэж асуулаа.

Грэй, жаахан хүлээж бай гэж дохиод, цаасан дээр хэрэгтэй тоогоо бодож гаргаад:

— Хоёр мянган метр гэснээ тавиурыг эргэлзэнгүй харж

— Тийм ээ, хоёр мянгаас доошгүй метр гэсэнд эзэн дороосоо хатгуулсан юм шиг цовхрон босож

— Хоёроо? Мянга аа? Метрээ? Ахмад та суу. Шинэ торго нэмж үзэхгүй биз? Өөрөө л мэд. Май, сайн тамхи, энэ чүдэнз. Хоёр мянга... хоёр мянгын чинь... гээд үнийг хэлсэн боловч Грэй үнэ хаялцах дургүй учир хэлсэнд нь сэтгэл дүүрэн байлаа.

— Хамгийн сайн гайхалтай торго, юутай ч зүйрлэхгүй бараа, ганц надад л байгаа юм даа гэж эзэн сайрхан үглэнэ.

Эзний баяр хөөр жаал намдахад Грэй түүнтэй торгоо хүргүүлэх тухай тохиролцож, зардлыг нь өөрөө даахаар болж, тооцоо ёсоор мөнгөө төлөөд, хятадын хаан шиг хүндлүүлсээр мухлагаас гарчээ. Энэ зуур мухлаг байсан гудамжнаас нэг гудамж алгасаад хэрмэл хөгжимчин эхил хуураа хөглөж, нумаа татан, гунигтай боловч нэг л сайхан аялгууг тоглож, түүний нөхөр лимбэчин хөөмийн цэцгэн аялгууг ундруулж, энэхүү энгийн дуу халуунд нозоорон зүүрмэглэх хашаанд эгшиглэн, Грэйн чихний тус өртөөлөн, зүрхний угт хүрэхэд одоо яах ёстойгоо дорхноо мэджээ. Ер нь энэ хэдэн өдөр азын тэнгэр нааш эргэж, хажуугийнхаа дохио, хөдөлгөөн бүрээс санаа авах билгийн нүдийг олсон мэт байлаа. Сүйх тэрэгний явж өнгөрөх чимээнд дарагдаж байгаа хөгжмийн аялгууг чагнасаар, өөрийн зан байдлаас нь уламжлаад энэ хөгжмийн аяар сэтгэлд ургах олон бодлоос хамгийн голыг нь олж санасан бүхэн нь хэрхэн яаж сэтгэлчлэн бүтэхийг мэдэрчээ. Нарийн гудамжийг өнгөрөөд хөгжимчдийн тоглолт болж байгаа байшингийн дааман хаалгаар оров. Энэ үеэс хөгжимчид явахаар завдаж, унжгар царайтай өндөр лимбэчин мөнгө шидсэн цонхнуудын зүг малгайгаа өргөн тал өгч, эхил хуурч хуураа сугандаа хавчуулаад, духныхаа хөлсийг арчин, лимбэчнээ хүлээж байлаа.

— Үгүй, энэ чинь Циммер үү! гэж Грэй хэлэв. «Мөнгөө торхон дээр» гэдэг зоогийн газар далайчид, зочдыг гайхалтай сайхан тоглолтоороо хөгжөөж байдаг хийлчийг таньж

— Чи яагаад хийлээ орхисон байдаг билээ? гэж асуув.

— Эрхэм ахмад аа гэж Циммер биеэ тоохгүй дуугараад

— Хангинадаг, жингэнэдэг болгоноор би тоглодог юм аа.

Залуудаа мөхөс би хөгжмийн алиалагч байлаа. Одоо урлагт татагдаад ирэхлээрээ хайран сайхан авьяасаа талаар болгож гэж хар бууж сууна. Иймээс оройтсон хүслээ дагуулж эхил хуур, хийл хоёрт дуртай болчихоод байгаа юм даа. Өдөр нь эхил хуур дарж, үдэш нь хийлээр тоглож, нэг ёсондоо, авьяасаа хий үрснээ харамсан уйлж байгаа юм. Дарс барих юм биш биз дээ? Эхил хуур бол миний Кармен, хийл бол... гэхэд нь Грэй

— Ассоль гэв. Циммер эндүү сонсож:

— Тийм ээ, соло-г² таваг дээр буюу зэс гаансаар тоглоно гэдэг өөр хэрэг. За надад ямар хамаа байх билээ! Урлагийг маяг болгогчид маяглаж байг. Харин хийл, эхил хуур хоёрт лусын дагинас амардгийг би мэднэ ээ гэж толгой дохиход тэдэн дээр ирсэн хонин бор нүд, цайвар сахал, өндөр нуруутай лимбэчин

— Тэгвэл миний «тур - люр - лю» дотор юу нуугдаж байна вэ? Аль вэ хэлээдхээч? гэсэнд

— Өглөөнөөс хойш чиний хэр зэрэг уув гэдгээс л болно доо.

Заримдаа шувуухай жиргэнэ, заримдаа архины уур савсана. Ахмад аа, энэ бол миний найз Дусс. Таныг алтаар туйлж байдаг гэж хэлсэн чинь танд эчнээ дурлачхаад байгаа хүн гэхэд Дусс,

— Тийм ээ, буянт үйл, өглөгч занд би дуртай. Гэхдээ миний зальтайг яана, булай муухай зусардахад минь итгэх хэрэггүй шүү гэсэнд Грэй инээж:

— За ийм байна. Надад зав алга, ажил их. Нэлээд овоо мөнгө олж болох байна гэдгийг та нарт хэлье. Нэг найрал хөгжимчдийг бүрдүүлээдэх, тэгэхдээ аяны ганганыг бодох буюу эсвэл авианы нарийныг хөөцөлдсөөр хөгжмийн амин сүнсийг мартаж орхиод толгой эргэм шааг шууг хийтэл хяхтнуулдаг үхсэн хүнийх шиг хиймэл царайтай ганган маягийн хөгжимчдийг битгий аваарай. Тогооч эмэгтэй, зарц эрчүүлийн эгэл зүрхийг уяруулж чаддаг өөрийнхнийгөө, тэнэмэл хөгжимчдөө цуглуулаарай. Далай, дурлал хоёрт ёсорхуу амьтад таардаггүй юм. Би та хоёртой хамт сууж нэгээр тогтохгүй лонх

дуртай суллах байсан боловч даанч ажилтай байна. Энэ мөнгийг аваад А үсгийг бодож уугаарай. Хэрэв миний хэлж байгаа сэтгэлд тань таарвал оройхон «Нууц» гэдэг хөлөг дээр очоорой. Гол далангаас холгүй байгаа гэсэнд Грэй хан хүн шиг өгөөмөр загнадгийг мэдэх Циммер

— Ай болохгүй яах вэ! Дусс минь, шалавхан бөхийж, малгайгаа дээш нь чулуудаад «за» гэж хэл! Ахмад Грэй гэрлэх гэж байгаа юм байна! гэхэд нь Грэй

— Тийм ээ гэж энгийн хэлээд

— Нарийн ширийнхийг сүүлд «Нууц» дээр очиж байгаад та нарт хэлэмз. Та нар... гэтэл Дусс Циммерыг тохойгоороо ёворч

— А үсгийн төлөө! Гэвч... цагаан толгойд чинь ямар олон үсэг байдаг билээ дээ! Ухаан нь Я-гийн төлөө ч юм уу уучих юмныхыг хайрлахгүй юу?... гэв.

Грэйг мөнгө нэмж өгөхөд хөгжимчид явлаа. Грэй захиалгын контороор орж, ихээхэн хөлсөөр зургаан өдрийн дотор яаралтай биелүүлэх нууц даалгавар өглөө. Грэйг хөлөг дээрээ эргэж ирэхэд конторын төлөөлөгч хэзээний галт онгоцонд суусан байлаа. Орой нь торго авчирч өгөв. Грэй, дарвуул хийх хөлсний таван хүнийг далайчидтай хамт байрлуулав. Летика буцаж ирээгүй, хөгжимчид алга байсан тул Грэй тэднийг хүлээх зуураа Пантентай ярилцах гэж очив.

Грэй, хэдэн жилийн турш багийнхаа бүрэлдэхүүнийг солиогүй явааг тэмдэглэх хэрэгтэй. Эхлээд далайчид ахмадынхаа хачин хачин аян хийж, ямар ч худалдааны ашиг байхгүй, эзгүй газар, сараар зогсоход нь гайхдаг байсан боловч аажимдаа Грэй «грэйзмд» автжээ. Ачуулах гэсэн бараа сэтгэлд нь тохироогүй учраас хоосон ч явж байлаа. Онгоцны хөндийд дүлий дүмбий оргин хэвтэж, хэрэгцээтэй л юм гэж бодогдуулахаас цаашгүй саван, хадаас, машины эд ангийг ач гэж яаж ч ятгаад нэмэргүй. Гэтэл чихэр жимс, шил шаазан, мал, амьтан, таван халуун, цай, кофе, тамхи, тариа, торго дурдан хийгээд шинэс, зандан, дал мод тэргүүтнийг дуртай ачна. Ийм бараа эрхэмсэг санаанд нь нийцэж, тансаг байдлыг бий болгодог юм сан уу! Ийнхүү өвөрмөц байдлаар хүмүүжсэн «Нууцын» багийнхан хялбархан олз олохын хойноос хөөцөлддөг бусад бүх хөлгийг тоомжиргүй харах болжээ. Гэсэн ч энэ удаа Грэй далайчдынхаа хачирхан гайхаж байгааг царайг нь хараад ойлгож байсан бөгөөд хамгийн мангуу далайчин ч ойн голын голдиролд засвар хийх хэрэггүй гэж мэдэхгүй яах вэ.

Пантен тэдэнд Грэйг тушаалыг дамжуулсан агаад Грэйг ороход туслах нь өрөөн дотуураа холхисоор зургаа дахь янжуураа татаж, утаанд нь мансуурч орхиод, очиж сандал мөргөж байжээ. Орой болсон байлаа. Нээлттэй цонхоор алтан шаргал гэрэл тусаж, тэр гэрэлд ахмадын нь малгайны чийдмэл саравч гялсхийв.

— Бүх юм бэлэн. Хүсвэл одоо ч зангуугаа татаж болно гэж Пантен бүсгэрдүүхэн хэлбэл

— Пантен, та миний занг сайн мэдмээр юм даа. Миний хийж байгаад нууц юм байхгүй ээ. Зангуугаа Лилиан голын ёроолд хаямагц би учрыг тайлан хэлж өгнө. Тэгэхэд та ийм муу янжуур асаах гэж өдий олон чүдэнз гарздахгүй байх аа. Явж зангуугаа тат гэсэнд Пантен зовонгуй инээмсэглэж, хөмсгөө маажин:

— Тэр ч тийм шүү. Үгүй, би яах вэ дээ гэжээ.

Пантенийг гарахад Грэй дутуу хаасан хаалгыг гөлрөн харж хэсэг сууснаа өрөөндөө оров. Тэгээд нэг сууж, нэг хэвтэж, асар том гинжийг татан авч байгаа нижигнэх чимээг чагнаж, дээш гарахаар завдсанаа дахин бодлогошрон ширээ рүүгээ эргэн ирж, хулдаасан дээгүүр хуруугаараа шууд шууд шугам түргэн түргэн зурна. Нударга зангидан, хаалга нүдэх чимээгээр дэвэрсэн сэтгэл нь дарагдаж, Грэй доожоо тайлахад Летика орж ирэв. Далайчин цаазаар авхуулах гэж байгаа хүнд амжиж хэл хүргэсэн элчийн дүртэй аахилан зогсож:

— Татуургын дэргэд манайхны гараа нулимаад бүжиглэж байгааг далангийн тэндээс хараад «Летика нисээрэй» гэж өөрөө өөртөө хэллээ шүү дээ. Миний нүдийг бүргэдийн нүд гэж мэд. Би чинь ёстой нисэж, завьчныг шавдуулж, ганц хөлсөлсөн дөө. Ахмад минь, та чинь намайг эрэг дээр орхих гээ юу? гэсэнд Грэй далайчны улаан нүдийг ширтэж

— Летика, чамайг өглөөнөөс нааш ирэхгүй гэж санасан юм. Чи толгой дээрээ хүйтэн ус хийв үү дээ? гэвэл

— Хийсэн. Өвчүүнийхээ ар руу хийдгээс бол ч бага л даа.

Гэхдээ л хийсэн. Таны хий гэснийг хийлээ гэв.

— Яриад бай.

— Яриад яах юм бэ, ахмад аа. Энд цөмийг бичсэн байгаа. Май унш. Мөн ч их хичээлээ шүү дээ. За би явъя даа.

— Хаашаа?

— Таны зэмлэнгүй харж байгаагаас толгой руугаа хүйтэн ус бага хийжээ гэж мэдлээ.

Летика эргэж сохор хүн шиг тэмтэчсээр гарав. Грэй цаасыг дэлгэн үзэв. Хорхой мөрлөчихсөн юм шиг юм сараачиж байхад нь манай эзэн яачхаа юм бол гэж харандаа нь лав гайхсан биз ээ.

Летикагийн бичсэн нь:

Заавар ёсоор ажиллав. Таван цагаас хойш гудамжаар нь явлаа. Саарал дээвэртэй, хоёр цонхтой, хажуудаа ногооны газартай байшин байна. Мөнөөхөн эмэгтэй хоёр удаа гарч ирсний нэгэнд нь ус авах гэж, хоёр дахид нь түлэх зомгол авах гэж гарлаа. Харанхуй болмогц цонхоор нь шагайсан боловч хөшигтэй байсан учир юу ч олж харсангүй.

Дараа нь гэрийн дотоод амьдралын тухай хэдэн зүйл байв. Үүнийг Летика гуанзанд архидаж суухдаа олж сонссон бололтой. Учир нь тэмдэглэлийн төгсгөлд «Зардалд өөрийнхөөсөө нэлээдийг нэмж төлсөн болно» гэж бичсэн байлаа.

Энэ мэдээлэлд бидний нэгдүгээр бүлгээс мэдэх зүйлийг голчлон өгүүлсэн байлаа. Грэй, цаасыг ширээнийхээ нүдэнд хийгээд жижүүрийг шүгэлдэн дуудаж, Пантений хойноос явуулсан боловч туслахын нь оронд боцман Атвуд шамласан ханцуйгаа буулгасаар хүрч ирээд

— Бид Далангаас хөдөлсөн. Пантен таныг юу гэх гэсэн юм бол гэдгийг мэдээд ир гэж явууллаа. Бүрээ, бөмбөр, хийл барьсан хэдэн хүн дайрч орж ирээд, Пантен тэдэнтэй байж байна. Та тэднийг «Нууц» дээр ир гэсэн юм уу? Пантен ирээч гэж гуйж байна, ер учрыг олохоо байлаа гэж хэлж байна гэсэнд Грэй

— Тийм ээ, Атвуд би тэднийг ир гэсэн юм. Командын байранд очиж бай гэж тэдэнд хэлээдэх. Хаана яаж байлгах янз нь мэдэгдэнэ биз. Атвуд, намайг арван таван минут болоод тавцан дээр гарна гэж байна гэж тэр улсад, мөн багийнханд очиж хэл. Пантен та хоёр ч гэсэн миний хэлэхийг чагнана биз ээ гэв.

Атвуд зүүн хөмсгөө солбин өргөж, хаалган дээр ташаалдан зогссоноо гарч одов.

Энэ арван минутад Грэй нүүрээ даран суухдаа юунд ч бэлдсэнгүй, юу ч тооцоолсонгүй, ердөө өөрөө бодлоо бодон дуугүй байхыг хүсжээ. Энэ завсар цөмөөрөө ахмадынхаа яахыг нь тааж ядан сониучирхаж, тэсэж ядан хүлээж байлаа. Грэй гарч ирээд, ер бусын юм хэлэх нь гэж хүлээсэн байдал хүмүүсийн царайд тодрон байгааг

харахдаа энэ явдлыг болох ёстой юм ёсоороо болж байна гэж бодох учир өрөөлийн сэтгэл түгшсэнд ялихгүй уцаарлах шиг болов.

Грэй тайн шатан дээр сууж

— Онцгой гойд юм байхгүй ээ. Онгоцны бүх дарвуулыг сольж дуустлаа бид голын адагт байх болно. Улаан торго авчирсныг та нар үзсэн. Дарвуулын мастер Блент удирдаж, түүгээр «Нууцад» шинэ дарвуул хийнэ. Тэгээд бид хөдөлнө, гэхдээ хаашаа гэдгийг нь одоо хэлэхгүй ээ. Ямар ч л гэсэн эндээс нэг их холгүй газар очно. Би эхнэр рүүгээ очно. Одоохондоо эхнэр минь болоогүй байгаа боловч болох юм. Улаан дарвуул хийх гэж байгаагийн учир гэвэл зүрхний маань хүн болзсон ёсоор биднийг тэр дарвуулаар алсаас олж харах ёстой юм. Ийм л байна. Учир битүүлэг юм ер байхгүй байгаа биз дээ. За энэ ч яах вэ гэсэнд Атвуд далайчдын инээмсэглэх царайнаас тэдний гайхаж, үүнийгээ ярьж зүрхлэхгүй байгааг нь хараад

— За, ийм учиртай байж, ахмад аа... Үүнийг шүүж хэлэлцдэг нь бид биш ээ. Хүссэнээрээ болох шүү дээ. Танд баяр хүргэе гэсэнд Грэй

— Баярлалаа! гэжээ.

Грэй боцманыхаа гарыг хүчлэн атгасанд цаадах нь ер бусын чармайлт гаргаж, өөдөөс нь бүр чанга атгасанд ахмад бууж өгөв. Түүний дараагаар цөмөөрөө ээлжлэн ирж, зөөлөн дулаан харцаар харан баяр хүргэв. Хэн ч хашхирч шуугьсангүй. Далайчид ахмадынхаа тасалданги үгнээс нэг л энгүүн бус зүйлийг олж мэдэрчээ. Пантен санаа амран, шүүрс алдаж, сэтгэл сэргээд, цээж дээр нь бөглөрч байсан хар юмыг аваад хаячих шиг болов. Хөлгийн нэг дархан яагаад ч юм сэтгэл дундуурхан үлдэж

— Ийм юм таны толгойд яаж оров оо? гээд гарыг нь сулхан атгахад

— Сүхээр чиний мод цавчдаг шиг л гэж хэлээд

— Циммер! Залуусаа харуулаач гэв.

Циммер хөгжимчдийн далыг алгандан, хүмүүсийн дотроос хааш яаш хувцасласан долоон хүнийг түлхэн гаргаж

— Энэ бол татуур бүрээч байгаа юм. Тоглох ч гэж их буугаар буудаж байгаа юм шиг л авна гэж мэд. Энэ хоёр сахал үсгүй залуу бол дохио бүрээч байгаа юм. Эднийг бүрээдээд унахад байлдан тулах хүсэл төрөөд явчихдаг юм. Дараа нь бялар бишгүүрч, бүлүүрт бүрээч хоёр дахь хийлч байна. Эд цөмөөрөө нэгдүгээр хийлчийг, өөрөөр хэлбэл намайг тэврэх их дуртай улс байгаа юм. Аа, энэ бол манай хөгжилтэй

ажлын гол эзэн, бөмбөрчин Фрип. Бөмбөрчид ихэвчлэн урам хугарсан царайтай байдаг. Энэ бол нэр хугалахааргүй, урамтай нүүддэг хүн. Тоглолтод нь цохиур шиг нь шулуун, ил нэг л юм байдаг юм. Таны санаанд таарахаар болж уу, ахмад Грэй? гэсэнд

— Гайхалтай. Та бүхэнд дор байр гаргаж өгсөн. Ингэхлээр энэ удаа «скерцо», «адажно», «фортисимо» ачих болох нь. За тарцгаа. Пантен аргамжаагаа аваад хөдөл. Хоёр цаг болоод таны халааг би авна гэв.

Судас үргэлж лугшиж байдагчлан Грэйнд сэтгэлд хөгжим үргэлж уянгалсаар байсан тул энэ хоёр цаг яаж өнгөрснийг ч мэдсэнгүй. Гагцханыг бодож, ганцханыг хүсэж, ганцханыг эрмэлзэнэ. Зүгээр сууж чаддаггүй хүн болохоороо сэтгэл нь яарч, үйл явдлыг шатрын хүү нүүж байгаа юм шиг санааны зоргоор хөдөлгөж болдоггүйд харамсана. Гаднаа хэчнээн тайван байлаа ч гэсэн дотор нь туйлаас үймрэн шаналж, зүйрлэвээс толгой дээр нь дэлдэх асар том хонхны дуу зүрх шимшрүүлж, хамаг биеийг нь зовоож байх мэт болжээ. Сүүлдээ бүр болохоо болиход нь дотроо «нэг... хоёр... гуч...» гэж тоолсоор «мянга» хүргэв. Ийм дасгал хийсэн нь тус болж, болж байгаа бүхнийг хажуугаас нь харах чадвартай болов. Ассольтой үг ч сольж үзээгүй болохоор бодол сэтгэлийг нь төсөөлж чадахгүй байгаадаа нэлээд зовно. Өөрийгөө тэр хүн болгон бодож, нүүрийн нь төрхийг тодруулан бодвол тэр хүнийг муухан ч гэсэн ойлгож болно гэж нэг номоос уншсан нь санагдав. Грэй, нүднийхээ харцыг ердийнхөөсөө хачин болгож, сахалтай уруулаараа туягүй муухан инээмсэглэснээ гэнэт санаа авч инээд алдаад, Пантений халааг авахаар гарав.

Харанхуй болжээ. Пантен хүрмийнхээ захыг босгож, луужингийн дэргэдүүр алхан, «За зүүн тийшээ дөрвөн румб, зүүн тийшээ. Зогс, арван таван румб»³ хэмээн залуурчид хэлж байлаа. «Нууц» хөлөг далбааныхаа хагасыг татаж, аясын салхи даган явж байв.

— Би сэтгэл өег байна гэж Пантенийг Грэйд хэлэхэд

— Юунд тэр вэ? гэвэл

— Тантай л адил. Би бүгдийг ойлгосон. Энд тавцан дээр гээд зальтайяа нүд ирмэн инээмсэглэх нь тамхины цогийн гэрэлд харагдав.

Юу гээд байгааг нь Грэй гэнэт тааварлаад

— Аль вэ, юу гэнэ ээ! Та юу гэж ойлгов оо? гэвэл

— Хулгайн тээвэр хийх ганц сайн арга байна. Хүн дуртай далбаатайгаа л явж болно шүү дээ. Грэй, та аргагүй лут толгойтой юм

аа гэж шивнэсэнд

— Ээ чааваас, Пантен минь! гэж уурлах хэцүү, инээх хэцүү болж

— Таны таамаг ухаалаг боловч огт үндэсгүй юм. Явж унт. Танд ам алдъя, та эндүүрч байна. Би хэлснээ л хийж байна гэжээ.

Грэй түүнийг унт гэж явуулаад, чигээ шалгаад суулаа. Одоо түүнд ганцаараа байх нь дээр тул түүнийг энд нь орхиё.

VI : АССОЛЬ ГАНЦААРАА ҮЛДЭВ

Лонгрэн шөнө далайд хонов. Тэгэхдээ унтсан ч үгүй, загас ч барьсангүй, далбаагаа босгоод, усны цалгихыг чагнаж, түнэр харанхуйг ширтэж, сэвшээ салхинд илбүүлж, гүн бодлого болсоор толгой хазайсан зүгтээ явж байв. Амьдралын хүнд үед ганцаараа ингэж тэнэх шиг сэтгэлийг нь сэргээдэг юм гэж үгүй байлаа. Гагцхүү хүний хөлөөс зайдуу, нам гүмд л өнчрөн ээдэрсэн, тамирдан сульдсан сэтгэл нь тайвширч юмыг ойлгохтой болдог байлаа. Энэ шөнө хойч ирээдүйгээ, ядуу зүдүүгээ, Ассоль охиноо боджээ. Охиноо түр ч гэсэн орхиод явахад туйлын хэцүү. Түүнээс гадна мартагнаж ядаж байгаа сэтгэлийнхээ зовлонг сэдрээхээс айна. Онгоцонд буцаж ажил хийвэл талийгаач хань нь түүнийг Капернадаа хүлээж байгаа мэт санаж, буцаж ирэхдээ хий хүлээхийн зовлон эдлэх биш үү. Мери нь гэрийнхээ хаалгаар хэзээ ч гарч ирэхгүй. Гэвч Ассолийгоо хүнээс дутуугүй байлгахыг хүсэх тул үйлээ дагая гэж шийдэв.

Лонгрэнг гэртээ ирэхэд охин нь байсангүй. Өглөө эрт охиноо салхинд гарахад санаа огт зовдоггүй боловч энэ удаа сэтгэл нь ялихгүй зовуурилаад байв. Хоёр булангийн хооронд холхиж байтал Ассоль өнцөг тойроод гэнэтхэн гарч ирэх нь харагдав. Тэгээд чимээгүйхэн гялсхийн орж ирээд өмнө нь дуугүй зогсохдоо ихэд догдолсон байртай нүд нь гялалзсанд Лонгрэн айх шиг болов. Бүсгүйн хоёр дахь царай буюу гагцхүү нүдээрээ танигддаг жинхэнэ царай тодрон харагдав. Охин нь нүүрийг нь яасан нь мэдэгдэхгүй ширтэн дуугүй зогссонд — Хүүхээ өвдсөн юм биш биз? гэж яаран асуулаа.

Ассоль тэр дороо дуугарсангүй. Юу асуусныг сая л ойлгохдоо хуурын чавхдас чичирхийлэх лугаа адил болсноо баясан удтал намуухан инээв. Юм хэлэх болбол ер бодож цөхдөггүй зангаараа

— Үгүй ээ, охин нь эрүүл байна. Та юунд нэг их ингэж хараа вэ? Би их баяртай байна аа. Өдөр их сайхан байгаа болохоор бүр хөөрчхөөд байна, нээрээ шүү. Та юу гэж бодов? Таны царайг харахад нэг л юм боджээ дээ гэсэнд Лонгрэн охиноо өвөр дээрээ суулгаж

— Би юу ч бодсон байлаа гэсэн чамайг учир ойлгоно гэж бодож байна. Амь зуух юм алга. Би дахиад алсын аянд явахгүй, харин Кассет, Лисс хоёрын хооронд явдаг шуудангийн онгоцонд ажилд оръё гэсэнд

аавынхаа юунд тэгтлээ сэтгэл тав алдаад байгааг ойлгох гэж оролдож, баярласан сэтгэлээ дарж чадахгүйдээ зовж

— Энэ ч муу даа. Би уйдна шүү дээ. Та хурдан ирээрэй гээд инээдээ барьж ядан

— Хурдан ирээрэй аав аа, санана шүү гэсэнд Лонгрэн охиныхоо хоёр хацрыг хоёр алгаараа шахан, өөр рүүгээ эргүүлээд

— Ассоль, юу болоов, хэлээч гэжээ.

Санааг нь амраах ёстой гэдгийг мэдээд хөөрсөн сэтгэлээ дарж, царайгаа төв болгосон боловч нүдэнд нь цог гэрэлтсээр байлаа.

— Та ямар хачин юм бэ? Онц гойд юм болоогүй. Би самар түүсэн юм гэв.

Лонгрэн бодолдоо дарагдаагүй байсан бол үүнд нь төдий л итгэхгүй байсан биз. Хоёул ажил төрлөө сайн ярьж авав. Пүүгээг бэлд гэж охиндоо хэлээд, авч явах юмаа тоочиж, нэлээд юм захив.

— Аав нь арав хоноод буцаж ирнэ. Миний охин бууг минь барьцаанд өгөөд сууж бай. Хүн чамайг дээрэлхэх гэвэл намайг мөд ирнэ гээрэй. Аавынхаа хойноос санаа зовох хэрэггүй. Би огт алзахгүй.

Ингээд хоолоо идэж, охиноо шов хийтэл үнсээд, пүүгээгээ үүрэн замд гарав. Ассоль эцгийгээ далд ортол харж зогссоноо гэртээ орлоо. Гэрт нь хийх ажил их байсан боловч үүнийгээ мартаж, төрж өсөөд идээшиж дассан гэр нь нэг л хүнийх юм шиг, огт өөр газар байж байгаад олон жилийн дараа төрсөн нутагтаа ирсэн юм шиг болж эргэн тойрноо ялихгүй гайхан харжээ. Гэвч ингэж бишүүрхэж байгаа нь нэг л тусгүй ч юм шиг, эвгүй ч юм шиг санагдана. Аавынхаа тоглоом хийдэг байсан ширээн дээр сууж, нэг завины хитэгт залуур наах гэж оролдож байтал энэ завь нүдэнд нь томрон үзэгдэж, өглөө сэтгэлд нь харагдсан нь дахин нүдний өмнө жирвэгэнэн тодорч, нарны дайтай алтан бөлзөг далай даваад өлмийн тушаа нь унах шиг болов.

Ассоль тогтож сууж чадсангүй, гэрээс гарч Лиссийг зүглэв. Тийш очих ямар ч хэрэг байсангүй. Яах гэж яваагаа ч өөрөө мэдсэнгүй.

Гэвч явахгүй байж чадсангүй. Замд нь зам заалгах гэсэн нэг явган хүн дайралдсанд, яахыг сайн гэгч хэлж өгсөн боловч түүнийгээ дорхноо мартжээ.

Урт замыг өөрөө мэдэлгүй туулсан нь нэг хөөрхөн шувуу авч яваад, түүндээ сатаарсаар замаа өнгөрөхийг мэдсэнгүй юу гэлтэй. Хот хүрээд чимээ шуугианд анхаарал нь ялихгүй сарнисан боловч урьд хотоос айдаг байсан шигээ айсангүй ээ. Тойрог хэлбэртэй цэцэрлэгт

гудамжаар аяархан өнгөрч, моддын хөх сүүдрийг хөндлөн огтолж, хажуугаараа өнгөрөх хүмүүсийн царайг итгэмтгий харцаар зэрвэсхэн харсаар итгэл төгс жигдхэн алхана. Тэр өдөр эрээн мяраан улсын дотор үл таних содон бүсгүйг бодлого болон явааг гярхай хүн хэд хэд харжээ. Талбай дээр усан оргилуурын усанд гараа тосон, үсчих дусал дунд нь хуруугаа ээлжлэн нугалснаа хэсэг сууж амраад, гэдрэг буцан, ойн зам руу оров. Эргэх замдаа сэтгэл нь сэргэлэн, санаа бодол тод, тогтуун байлаа. Үлгэрлэвэл өдөр булингартан байснаа үдшийн сүүдэрт тунгалагшсан гол шиг болжээ. Сууриндаа ойртож явтал нь сагснаасаа цэцэг ургаж байна гэж харсан нөгөө нүүрсчин дайралдав. Нүүрсчин туж хөө, шавар болсон үл таних баргар царайтай хоёр хүнтэй хамт тэрэгний хажууд зогсож байлаа. Ассоль баярлаж

— Сайн байна уу, Филипп гуай, та яаж байгаа юм бэ? гэсэнд

— Зүгээр ээ дүү минь. Дугуй мултарч уначхаад. Сая засчхаад нөхөдтэйгөө тамхи татаж, дэмий бурж сууна. Чи хаачаад явж байна? гэж асуув.

Ассоль хариу дуугарсангүй.

— Филипп гуай. Би танд их сайн болохоор танд л гэж хэлье. Би удахгүй явна аа. Бүр л явах байх аа даа. Та хүнд битгий хэлээрэй гэсэнд нүүрсчин

— Явна аа? Хаашаа тэр вэ? гэж гайхан ам ангайсанд сахал нь бүр урт юм шиг болчхов.

— Мэдэхгүй байна аа гээд тэрэг зогсож байгаа хайлаасны доорх чөлөөг, үдшийн улбар туяанд ногоорох ногоо, дуу цөөтэй, хар царайтай нүүрсчдийг алгуурхан харснаа

— Би өөрөө мэдэхгүй л байна. Хэдний өдөр, хэдэн цагт явахаа, тэр ч байтугай хаашаа явахаа ч мэдэхгүй байна. Өөр юу хэлэх вэ. Ямар ч гэсэн сайн сууж байгаарай. Та намайг дандаа тэргэндээ суулгаж явдаг байсаан гээд нүүрсчиний палбигар том гарыг барин сугсрав. Ажилчны нүүрт инээмсэглэл тодров. Бүсгүй толгой дохиод, цааш эргэн, Филипп, түүний нөхдийн эргэж харж амжаагүй байхад дорхноо далд оржээ.

— Гайхалтай юм. Өнөөдөр энэ яачхаа вэ. Нэг л хачин гэж нүүрсчинийг хэлэхэд нөгөө нэг нь

— Зүгээр яриад байгаа ч юм шиг, зориуд ятгаад байгаа ч юм шиг. Бидэнд ямар хамаа байх вэ дээ гэсэнд гурав дахь нь

— Бидэнд падгүй л дээ гэв.

Тэгээд гурвуул тэргэндээ сууж, чулуут замаар дугуйгаа
түжгэнүүлэн гэлдэрсээр тоосон дунд далдрав.

АРАНЗАЛ ДАРВУУЛТ ХӨЛӨГ

Үүр манхайтал цайлаа. Намжаа их ойд шингэн манан татаж, мод юмс хачин сонин дүрстэй болон үзэгдэнэ. Нэгэн анчин отголсон газраасаа дөнгөж гараад гол даган явав. Модны завсраар голын дээрх хөндий зурвасхан гэрэлтэх боловч хичээнгүй анчин тийш ойртолгүй, уулын зүг одсон баавгайн шинэхэн мөр мөшгөлөө.

Моддын дотор гэв гэнэт бишгүүр уянгалсан нь нэхэн хөөгчид палхийтэл цочмог гараад ирдэгтэй адил болой. Хөгжимчин хөлгийн тавцан дээр гарч, хөгжмөө гунигтайяа уянгалуулан татлаа. Уй гашуугаа хэчнээн нуух гэвч хоолой алагладаг шиг тэр аялгуу чичирхийлэн чангарч ирээд, гунигтайяа өтгөрснөө тасалдав. Алсын цуурай энэ аялгууг бүдэгхэн давтлаа.

Анчин хугархай мөчрөөр баавгайнхаа мөрийг тэмдэглээд, ус руу явав. Манан хараахан дэгдээгүй, голын адаг руу аажуухан эргэж байгаа асар том хөлгийн бараа сүүмэлзэн харагдав. Хуниран унжсан эвхээстэй далбаа нь задран, том том хуниас гаран хүлхийж, шургыг бүрхэж байв. Хүн ярилцах, явах чимээ гарна. Эргийн салхи үл мэдэгхэн сэвэлзэж, дарвуул залхуутайяа дэрвэлзэн байснаа нар мандахад зохих өнгөө оллоо. Салхины эрч нэмэгдэж, мананг сарниулаад олон далбааг бөмбийлгөсөн нь цоморлогоо дэлгэсэн гал улаан сарнай шиг болов. Цасан цагаан шураг, олс татлага ягааран туяарна. Магнай тэнийх баяр баясгалангийн өнгө бүхий алгуурхан дэрвэх дарвуулаас бусад нь цав цагаан байлаа.

Эрэг дээрээс үүнийг анчин нүдээ арчин арчин хараад, буруу харсангүй гэдэгтээ сая итгэжээ. Хөлгийг голын цаагуур далд орон ортол харж зогссоноо мөрөө дуугүйхэн хавчсанаа баавгайнхаа араас явав.

«Нууц»-ыг голоор явж байхад Грэй онгоцоо тандах болуужин гэж залуураа далайчинд өгөлгүй өөрөө барьж явав. Пантен шинэ цэмбэн хувцас, гялалзсан саравчтай малгай өмсөж, сахлаа хусаад, чимээгүйхэн хөрөхийн сууж байлаа. Хөлгийн улаан гоёл, Грэйин шууд зорилго хоёр ямар холбоотой болохыг одоо болтол ойлгоогүй л явлаа. Грэй өгүүллүүн:

— Дарвуул маань улаан болж, аясын салхи найртай үлээж, бяцхан талх олоод баярласан зааныхаас ч илүү их хөөр баясал сэтгэлд

минь бялхан байна. Одоо танд Лиссад амласан ёсоор санаагаа хэлэх гэж оролджё. Би таныг тэнэг юм уу, зөрүүд гэж үзэхгүй байна. Харин ч та бол үлгэр жишээч хүн. Энэ чинь үнэтэй чанар юм шүү. Гэхдээ та олонх хүний адил, үлгэрлэж хэлэх юм бол энгийн үнэнийг амьдралын зузаан шилний цаанаас харах гэдэг юм байна. Энэ үнэн хэчнээн тод байвч та олж харахгүй ээ. Онцгой сайхан ч гэлээ огт бүтэшгүй санагдах мөртөө хотын захад гараад зугаалчих шиг амархан биелж, бүтэж болох юмыг би хийж байна. Удахгүй та бүхэн нэг бүсгүйтэй нүүр учирна. Энэ бүсгүй та бүхний нүүрэн дээр миний хийж байгаагаас өөр байдлаар нөхөрт гарахгүй, гарах ёсгүй юм гээд бидний сайн мэдэх зүйлийг далайчинд товчхон өгүүлж

— Энд хувь заяа, хүсэл зориг, зан чанар яаж салшгүй авцалдсан байгааг та харж байгаа биз. Намайг, магадгүй ганцхан намайг хүлээж байгаа хүнийг би зорьж явна. Би сэтгэл зүрхнийхээ тэр хүнээс өөрийг хүсэхгүй байна. Яагаад гэвэл гайхамшиг гэгчийг өөрийн гараар бүтээж болно гэдэг ердийн нэг үнэнийг түүний ачаар ойлгосон юм. Хүний хувьд эрээд олдохгүй тавтын мөнгө авах нь гол байвал тэр мөнгийг өгөх амархан, харин гайхамшигийг бүтээх бадрангуй оч сэтгэлд чинь байгаад, өөрөө бас чадал чинь хүрч байвал тэр гайхамшигийг бүтээ.

Чи ч шинэ сэтгэлтэй болно, тэр ч шинэ сэтгэлтэй болно. Гяндангийн дарга ялтанг өөрөө суллаад, саятан хүн бичээчдээ харшаа, жүжигчин хүүхнийгээ мөнгөнийхөө авдартай бэлэглэж, уралдаанд байнга түрүүлдэг морины эзэн аз дайрч түрүүлж үзээгүй нөхөртөө туслах сан гэхдээ мориныхоо амыг татаж нөгөө хүнээ түрүүлүүлбэл хэчнээн аятай мөртөө хэлж баршгүй сайхан болохыг бүгд ойлгоно. Гэхдээ ялдамхан мишээчих, баясаж цэнгэх, өршөөж уучлах, яг цагт нь хэрэгтэй үг хэлж хүний сэтгэл амраах энэ тэр гээд түүнээс дутахгүй гайхамшигтай юм бий. Үүнийг эзэмшинэ гэдэг бол хамаг сайхныг эзэмшинэ гэсэн үг. Миний тухайд гэвэл хайр сэтгэл гэдгийг сайн мэддэг санааны угаас хийсэн дарвуулын аранзал туяанд Ассоль бид хоёрын хувь ерөөл үүрд гэрэлтэж үлдэнэ. Та миний хэлснийг ойлгов уу? гэсэнд Пантен нямбайлан эвхсэн цэвэрхэн алчуураар сахлаа арчаад

— Ойлголоо ахмад аа. Цөмийг ойлголоо. Та намайг уяраачихлаа. Доош орж, Никсээс уучлал гуйя байз, өчигдөр усанд хувингаа алдчихлаар нь загначихсан юм сан. Цаадах чинь бас тамхиа мөрийд алдчихсан юм. Би өөрийнхөө тамхийг өгье гэжээ.

Түрүүхэнд хэлсэн үгээ ийм түргэн сүрхий нөлөөлсөнд нэлээд гайхсан Грэй ам нээж амжаагүй байтал Пантен шатаар түжгэнэтэл гүйж, нэлээд цаахна нь очоод санаа алдах нь дуулдав. Грэй дээш харахад, дээр нь аранзал дарвуул дэрвэж, нарны гэрэлд хуниас нь хөхрөн солонгорч үзэгдэнэ. «Нууц» хөлөг далайн уудамд орж, эргээс улам холдлоо. Грэйнь уянгалан дуулах сэтгэлд битүүхэн түгшин шаналах ч, аар саар юманд зовох ч, ер нь яадаг ийдэг бол гэж эргэлзэх юм ч огт байсангүй. Залуу эр гайхамшигт зорилгодоо хүрэхээр дарвуул шигээ тайван тэмүүлж, бодол гэдэг үгнээс хурдан болохоор ирээдүйгээ зөгнөн хүсэж явлаа.

Үдийн алдад тэнгэрийн хаяанд цэргийн хөлгийн утаа үзэгдэв. Тэр хөлөг чигээ өөрчилж «Нууц» хөлгөөс хагас бээрийн газар ирээд зогсох дохио өглөө. Ах дүү нар минь, биднийг эд буудахгүй битгий айгаарай. Цаадуул чинь ердөө л нүдэндээ ч итгэхгүй байгаа юм гэж Грэй далайчдадаа хэлэв.

Грэй, онгоцоо зогсоохыг тушаасанд Пантен, гэнэт гал гарав уу гэмээр хашхичин «Нууцыг» салхины дагуугаас гаргаж, энэ завсар байлдааны хөлгөөс баг цэрэг, цагаан бээлийтэй дарга суулгасан уурын завь давхин ирэв. Дэслэгч хөлгийн тавцан дээр гарч ирээд, ийш тийш гайхан харснаа, Грэйнь хамт тасалгаанд нь ороод цагийн дараа гарч ирэхдээ гараа хачин зангаснаа, цол нэмэн шагнуулсан юм шиг инээмсэглэсээр хөх онгоц руугаа буцсан юм. Энэ удаа Грэй гэнэхэн Пантентай ярилцсанаас амархан хэл амаа олсон бололтой. Учир нь байлдааны хөлөг явдлаа сааж ёслолын буудлага хийсэнд хүчирхэг цуурай нь нирхийж, утаа нь олгойдон, агаарт гялтганасан том том бөмбөлөг болон дэгдсэнээ намуухан усан дээгүүр сэмрэн сэмэрсээр сарнин замхрав. Өдөржингөө байлдааны хөлөг дээр бараг баяр ёслол болчихсон юм шиг хүмүүсийн сэтгэл хөөрөн, задгай чөлөөтэй болж, танхимаас машины тасаг хүртэл хаа л бол хайр дурлалын тухай ярьж, миний тасгийн харуул хажуугаараа өнгөрч яваа усан цэргээс

— Том, чи яаж гэрлэсэн бэ? гэж асуухад цаадах нь

— Цонхоор зугтаж гарах гэхээр нь банзлаас нь шүүрч бариад авсан гэж хэлээд бавгар сахлаа бардам гэгч нь имэрчээ.

Хэсэг зуур «Нууц» хөлөг задгай тэнгэсээр явлаа. Үд дундын хэрд алсын эргийн бараа харагдан Грэй дуран авч Каперныг дурандлаа. Хэдэн байшингийн орой халхлаагүй сэн бол нэгэн байшингийн цонхоор Ассоль ном уншаад сууж байгаа нь харагдахаар байлаа. Ном

уншиж суухад нь номын дээгүүр нь ногоон цох явж, ихээ өөриймсөг, намайг яах ч үгүй гэсэн байртай урд хоёр хөл дээрээ өндийн зогсоно. Тэр цох хоёр ч удаа сайхан явж байснаа цонхны тавцан руу үлээлгэсэн боловч нэг юм аминчлан хэлэх гэсэн мэт итгэмтгий байдлаар дахин дахин хүрч ирээд байв. Номын хуудасны булангаас барьсан бүсгүйн гарт энэ удаа бараг хүрч, «хараач» гэдэг үгийг голлон зогсоод, дахиад л салхи дайрах байх хэмээн хүлээж, үнэхээр ч золгүй явдлаас ам мөлтөс аврагдсан бөгөөд Ассоль «Дахиад чи явж байна уу... золигийг» гэж дуу алдаад зочныг өвс рүү чангахан үлээх гэж өндийтөл гудамжны хоорондуур цэнхэрлэн мяралзах далайн мандалд аранзал улаан дарвуултай хундан цагаан онгоц хөвөн айсуй нь нүдэнд нь туслаа.

Ассоль давхийж, хойш далдираад таг болов. Тэгээд дотор нь палхийн, гэнэт цочирдсондоо нулимс асгаруулан огло харайн босов. Энэ үес «Нууц» хөлөг жижиг хошууг тойроод зүүн хажуугаараа эрэг барин ойртож явлаа. Аранзал торгон дарвуулын доорх хаш цагаан тавцан дээрээс хөгжим намуухан эгшиглэж үгээр эв хавгүй хэлбэл «Хундага жүнзээ дүүргэцгээ, хайр дурлалын төлөө тогтооцгооё, нөхөд минь» гэсэн дууны аялгууг шуранхайлан эгшиглэв.

Ассоль, гэрээсээ яаж гарснаа ч сайн санасангүй, үйл явдлын дийлдэшгүй хүчинд автан нэг мэдэхэд далайн зүг гүйж явлаа. Эхний гудамжны өнцөг дээр ирэхдээ хамаг биеийн чадал алдран зогсож, хөл нь туйвж, амьсгал нь бөглөрч, ухаан нь орон гаран болж ирэв. Биеэ барьж чадахгүй болохоос ухаангүй айж, хөлөө дэвслээд, авбал гайгүй болжээ. Аранзал дарвуул нэг үе байшингийн орой, нэг үе хашаанд халхлагдан үзэгдэхгүй болоход ерийн зэрэглээ шиг замхран алга болчих вий гэж айн, сэтгэл зовоосон саадыг өнгөрөх гэж яарч, дахин хөлөг харагдахад дотор нь онгойн санаа алдаж явав.

Энэ зуур Капернад хэн хүнгүй үймэн газар аймшигтай хөдөлснөөс ер дутахгүй сандран бужигнав. Энэ эрэгт том хөлөг хэзээ ч ойртож ирж байсангүй. Айсуй яваа хөлгийн далбаа доромжлол мэт дуулддаг өнгөтэй бөгөөд ийм дарвуул байдаг гэж аж амьдралын аль ч хуульд байдаггүй, эрүүл хүний ухаанд багтамгүй боловч одоо яахын ч аргагүй барин тавин улайран хийссээр ирлээ. Эрэгтэй эмэгтэй, хүүхэд шуухадгүй цөмөөрөө өмссөнтэйгөө тэр чигээрээ эрэг рүү ум хумгүй харайлгаж, хүмүүс байшин байшингаас бие биеэ дуудан гуаглаж нэг нэгийгээ дайрч унаган хашхиралдаж унаж тусан гүйлдсээр удалгүй усны захад бөөгнөрч, энэ бөөн улсын дундуур Ассоль шуугин оров.

Ассолийг ирээгүй байхад хүмүүс нэрийг нь цухалдсан, дүнсийсэн, түгшсэн, хорсож айсан янзтай ам амандаа хэлж байлаа. Ихэвчлэн эрчүүл нь ярьж, мэл гайхсан эмэгтэйчүүл нь могой аргих мэт шийг шааг хийж, ганц нэг нь атаархаж хорссондоо хэл амаа билүүднэ. Ассолийг ирэнгүүт цөмөөрөө дуугаа хурааж, цэрвэн холдсонд халуун элсэн дунд самгардсан, бишүүрхсэн, баярласан, гайхамшигт дарвуулаас ч илүү улаа бутарсан царайтай Ассоль өндөр хөлгийн зүг гараа сарвайн зогссоор үлдэв.

Хөрслөг царайтай сэлүүрчид дүүрэн суусан завь онгоцноосоо тасран хөвөв. Одоо бодоход, бүүр хүүхэд байхаас сэтгэлдээ төсөөлөн харж байсан тэр хүн тэдний дотор зогсож залуу эр илч түгээн, сэтгэл яаруулах мишээлээр өөрийг нь шагнан байна. Инээдтэй бөгөөд аймаар бодол сэтгэлд давхцан орж, эндүүрэх, алдах, далд хорон саад учрахаас үхтлээ айж, аяархан долгиж байгаа бүлээхэн уснаа бүслэхийгээ хүртэл гүйн орж «Би энд байна, би энд байна! Би байна!» гэж хашхирчээ.

Тэгэхэд Циммер дохио өгсөнд мөнөөхөн хөгжимчдийн наадах аялгуу бөөгнөрсөн хүмүүсийн дотрыг арзгануулан баяр баясгалан төгөлдөр нижигнэлээ. Бүсгүй, сэтгэл хөдөлж, үүл нүүж, давлагаан давлагаалж, ус гялтганаж, холхи мандал цайлалзан байгааг харахдаа чухам юу хөдөлж байна вэ, өөрөө юу, хөлөг үү, аль эсвэл завь уу гэдгийг ялгаж чадахаа байсан бөгөөд бүх юм хөдөлж, эргэлдэж, дайвалзаж байсан билээ.

Гэтэл хажууханд нь сэлүүр ус цалгиулсанд бүсгүй толгой өндийлгөв. Грэйг тонгойход Ассоль түүний бүснээс бариад авлаа. Ассоль нүдээ аньснаа дорхон нь нээгээд, Грэйн баяр гийсэн царайг харан зоригтой инээмсэглэж, амьсгал давхцуулан

— Яг мөн байна гэхэд нь Грэй норчихсон эрдэнээ уснаас татан авах зуураа

— Чи ч гэсэн, хонгор минь яг мөн. Би ирлээ шүү дээ. Чи намайг таньсан уу? гэж асуув.

Ассоль Грэйн бүснээс зуурсаар хөөрсөн сэтгэлээ барьж чадахгүй, нүдээ аниастай толгой дохижээ. Сэтгэлийн дотор нар мандав. Ассолийг нүдээ нээхэд завины бүүвэйлж, усны гялтганаж, хөлгийн сүртэйеэ эргэсээр ойртож байгаа нь туяа сацрах ханан дээр нарны гэрэл наадан байх мэт, гэрэл ус хоёр туналзан үзэгдэх зүүд мэт санагджээ. Хивсээр бүрхэн чимсэн тавцан дарвуулын улаан туяанд

умбан байхыг харахад хурмастын цэцэрлэгт ороод ирэв үү гэлтэй байлаа. Грэйг хүчит гарт тэврүүлэн шатаар яаж гарч ирснээ ч Ассоль мэдсэнгүй. Түдэлгүй нэг харвал үүнээс илүү гоё юм байдаг болов уу гэмээр тийм өрөөнд зогсож байлаа.

Тэгтэл дээр хөгжим сэтгэл бөмбөрүүлэн дахин уянгалав. Хараад байвал энэ бүхэн алга болчих юм шиг санагдан Ассоль дахиад нүдээ аньчихав. Грэй, гараас нь барьсанд бүсгүй одоо айх юмгүй гэдгийг мэдээд, тэгж ид шидээр ирсэн нөхрийнхөө цээжинд нулимс болсон нүүрээ наажээ. Үгээр илэрхийлэх аргагүй, хэнд ч олдохгүй үнэтэй агшин ирснийг мэдэн догдолсон Грэй баярлан инээсээр сэтгэлдээ эртнээс төсөөлж харж байсан бүсгүйн нүүрийг харах гэж эрүүн дороос нь зөөлхөн өргөв. Бүсгүй, нүдээ нээхэд хүний хамаг шилдэг сайхан бүхэн тэр нүднээ цогцлон шингэсэн байлаа.

— Чи аавыг маань авч явна биз? гэж бүсгүй асуув.

— Авч явна аа.

Ийнхүү «авч явна аа» гэж бат итгэлтэй хэлээд хайрт хүнээ чанга гэгч үнсэхэд Ассоль инээд алдав.

Тэр хоёр одоо хоёулхнаа байсан нь дээр болохоор тэднийг энд нь үлдээе. Энэ ертөнцийн буман хэлээр үй түмэн үг байдаг боловч тэр бүгдийг нийлүүлээд ч энэ өдөр тэдний бие биедээ өгүүлснийг тойм төдий ч гэсэн гарган хэлж болох болов уу даа.

Энэ завсар их шургын дэргэд, өтөнд идэгдэж, зуун жилээр дарагдсан буян хишгээ нээж ёроол нь бүлт үсэрсэн торхны дэргэд багийнхан цөмөөрөө хүлээж байлаа. Атвуд зогсож, Пантен үүлээ хөөсөн тэнгэр шиг цэмцийн сууна. Грэй дээш гарч ирээд, хөгжмийнхөнд дохио өгч, малгайгаа аваад алтан бүрээний сайхан аялгуу дунд цамцаалт шилэн аягаар ариун дарсыг анхлан утгаж залгилснаа аягаа бут чулуудаад

— Одоо ууцгаа, хундага тавилгүй ууцгаа. Уугаагүй хүнийг надад муу юм гэж бодно гэжээ.

Энэ үгийг дахин хэлэх хэрэг байсангүй. Хирдхийн цочсон Капернаас «Нууц» хөлөг хамаг хурдаараа холдон одож байхад торхны дэргэд улс түлхэлдэн шавсан нь далай их найран дээр болдгоос ч давж гарчээ.

— За дарс ямар санагдав? гэж Грэй Летикээс асуусанд

— Ахмад аа! гэж далайчин хэлэх үгээ олж ядан

— Би дарсандаа ямар санагдсаныг бүү мэд. Миний сэтгэгдлийг бол тунгааж болно. Бал бурам л гэсэн үг гэв.

— Юу!

— Аманд минь бал бурам хоёрыг чихээд оруулчих шиг л боллоо гэж хэлэх гэсэн юм. Ахмад минь, жаргалын дээдийг эдэлж яваарай. «Нууц» гэдэг энэ хөлгийн эрхэм зорчигч, эрээд олдошгүй эрдэнэ гэж миний нэрлэх энэ бүсгүй жаргаж яваг аа! гэв.

Хойд өдөр нь үүр хаяарч байх үес хөлөг Капернаас нэгэнт алслан одсон байлаа. Багийнхны хагас нь Грэйн дарсанд нам цохиулан тавцан дээр унасан чигээрээ унтаж орхижээ. Залуурч, харуул, халамцуу бодлогошронгуй Циммер гурав л босоо байлаа. Циммер хитэг дээр эхил хуураа эрүүндээ тулан, хилээ аяархан татаж, чавхдас нь сэтгэл уярам тэнгэрлэг сайхнаар эгшиглэхүйеэ аз жаргалын тухай бодон явбай...

Уг номыг “[Болор дуран](#)” шалгуураар шүүсэн болно. Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу орно уу.

5
БОЛОР ДУРАН 2.0
АМДМ ШАЛГУУР

**"БОЛОР ДУРАН"
ЗӨВ БИЧИГ ШАЛГАХ
ПРОГРАМ**

- ✓ 60 сая үгийн сантай.
- ✓ Алдаатай үгсийг илрүүлж, зөв үгсийг санал болгоно.
- ✓ Хэлзүйн тайлбар тольтой.
- ✓ Хувийн үгийн сан үүсгэх боломжтой.

БОЛОР
БОЛОР

Өглөгийн эзний сонорт



Та манай номын санд хандив өргөж болно.

Таны хандивласан мөнгө:

- Хэвлэгдсэн номыг цахим хэлбэрт оруулах
- Цахимд оруулсан номыг ариутган шүүх
- Цахим технологийн тоног төхөөрөмж авах
- Цахим номын санг өргөжүүлэх
- Цахим номын сангийн чиглэлээр судалгаа хийж, сурч байгаа оюутан судлаачийг дэмжихэд зарцуулагдана.

Хандив өргөх данс "Хаан банк" 5027 8982 35 (төгрөг) ЦОГТ ОХИН ТЭНГЭР САН

Qpay

1983 оны хэвлэлийн Хэвлэн нийтлэлийн мэдээлэл :

[А. ГРИН](#)

АРАНЗАЛ ДАРВУУЛТ ХӨЛӨГ

Шидэт үлгэр

*АРДЫН БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ХЭВЛЭЛ
УЛААНБААТАР 1983*

Орчуулсан [Г. Аким](#)

Редактор [Э. Оюун](#)

Хэвлэлийн редактор [З. Түмэнжаргал](#)

Зураач А. Лүндэн

Уран сайхны редактор З. Нямжав

Техник редактор Р. Оюун

Хянагч Агиймаа, Ш. Уртнасан

Өрөлтөд 1982 оны 10 дугаар сард

Хэвлэлтэд 1932 оны 12 дугаар сард

Цаасны хэмжээ 84X108 1/32

Хх 2,5

Хнх 4,1

Тооцооны хуудас 3,81

Хэвлэсэн тоо 8000

Үнэ 1 тө 50 мө

АБЯ-ны хэвлэл

БНМАУ Улаанбаатар 11

Ардын армийн хэвлэх үйлдвэр

Улаанбаатар хот, Партизаны гудамж 2

Заметки

[←1]

Халуун өвс (ЦБ)

[←2]

Соло — гоцлол аялгуу

[←3]

Румб — өнцгийн хэмжээний нэгж. Жишээ нь зүүн тийшээ дөрвөн румб гэвэл зүүн тийшээ 45° гэсэн үг.